

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМАНД

СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН

СЭДЭВ:

**Гадаад орнуудын арилжааны/худалдаа/-ны
тухай хуулиудын харьцуулсан судалгаа**

Судалгааны багийн ахлагч: Н.Норовсамбуу /LL.M/

Судалгааны багийн гишүүн: Г.Давааням /LL.D/

Судалгааны багийн гишүүн: Ж.Содномдаржаа /судлаач /

**УЛААНБААТАР ХОТ
2019 ОН**

БҮТЭЦ

ТАЛАРХАЛ.....	3
ОРШИЛ.....	4
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БҮТЦИЙН ХАРЬЦУУЛАЛТ.....	5
1.1 ХБНГУ-ын Худалдааны хууль	5
1.2 Япон Улсын Худалдааны Хууль	11
1.3 Вьетнам улсын худалдааны хууль	12
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХУДАЛДААНЫ ХУУЛИЙН ЗАРЧИМ	13
2.1 ХУДАЛДААНЫ ХУУЛИЙН ЕРӨНХИЙ АНГИЙН ЗАРЧИМУУД	13
2.2 ХУДАЛДААНЫ ХУУЛИЙН ТУСГАЙ АНГИ БУЮУ ХЭЛЦЛИЙН ЗАРЧМУУД.....	14
ГУРАВДУГААР БҮЛЭГ. АГУУЛГЫН ХАРЬЦУУЛАЛТ	18
3.1 ХУДАЛДААНЫ ХУУЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ.....	19
3.2 ХУДАЛДААНЫ ЭРХ ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭГ ХЭРЭГЛЭХ ЭРЭМБЭ.....	20
3.3 ХУДАЛДАА ЭРХЛЭГЧ ГЭХ ОЙЛГОЛТЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ	22
3.4 ХУДАЛДААНЫ БҮРТГЭЛ.....	29
3.5 ХУДАЛДААНЫ НЭР.....	36
3.6 ХУДАЛДААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ШИЛЖҮҮЛЭХ.....	41
3.7 ХУДАЛДААНЫ АЖИЛТАН	44
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХУДАЛДААНЫ ХЭЛЦЭЛ	46
4.1 ХУДАЛДААНЫ ХЭЛЦЛИЙН ЕРӨНХИЙ ЗОХИЦУУЛАЛТ	53
4.2 ХУДАЛДААНЫ ХЭЛЦЛИЙН ТУСГАЙ АНГИ	67
4.2.1 ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ.....	68
4.2.2 ТЭЭВЭРЛЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	71
4.2.3 АГУУЛАХЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	75
4.2.4 ХУДАЛДААНЫ ЗУУЧЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА	79
4.2.5 ХУДАЛДААНЫ КОМИССЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	80
4.2.6 ТЭЭВРИЙН КОМИССЫН ГЭРЭЭ.....	81
4.2.7 САНХҮҮГИЙН ТҮРЭЭСИЙН ГЭРЭЭ.....	82
4.2.8 ТООЦОО НИЙЛЭХ ГЭРЭЭ	83
4.2.9 ТӨЛБӨР ТООЦООНЫ ГЭРЭЭ	85
4.2.10 ДААТГАЛ.....	85
ТАВДУГААР БҮЛЭГ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ.....	91
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ	93

ТАЛАРХАЛ

Эрх зүйн шинэчлэлийн хүрээнд хийгдэж буй Арилжааны эрх зүйн зохицуулалтыг Иргэний хуулиас ялгаж, салгах томоохон судалгаа, шинэжилгээний ажлууд хийгдэж байгаа үед “Гадаад орнуудын арилжааны/худалдаа/-ны тухай хуулиудын харьцуулсан судалгаа”-г бидний судалгаа багт итгэж хариуцуулан гүйцэтгэх боломж олгосонд ХЗДХЯ-ны хамт олонд гүнээ талархаж байгаагаа илэрхийлье.

Түүнчлэн, уг судалгааг гүйцэтгэхэд хамтарч ажилласан болон судалгаанд хамрагдсан нийт байгууллага, хувь хүмүүст туйлын ихээр талархаж буйгаа энд тэмдэглэмээр байна.

Судалгааны баг, 2019 он

ОРШИЛ

Худалдааны эрх зүй гэх ойлголтыг эх газрын эрх зүйн тогтолцоонд өргөн болон явцуу утгаар нь авч үздэг. Өргөн утгаараа худалдааны эрх зүйн харилцааг зохицуулж буй хувийн эрх зүйн хэм хэмжээг нийтэд нь авч үзнэ. Харин явцуу утгаараа нь худалдааны эрх зүй гэдэгт Худалдааны тухай хууль(кодекс)-ыг ойлгодог.

Эх газрын эрх зүйн тогтолцооны эх үндэс болсон Ромын эрх зүйд иргэний болон худалдааны эрх гэсэн ангилал байдаггүй. Иргэний эрх зүйн кодификацлал нь Ромын эрх зүйгээс эхлэлтэй бол, Худалдааны эрх зүйн хэм хэмжээний кодификацлал нь харьцангуй сүүлд буюу 19-р зуунаас эхлэн Эх газрын эрх зүйн тогтолцоо бүхий улсуудад анх Худалдааны хуулийг баталснаар үүссэн гэж үздэг. Харин Англи-Америкийн эрх зүйн тогтолцоотой орнуудад хувийн эрх зүйн харилцааг иргэний болон худалдааны эрх зүйн харилцаа гэж тусад хуваан авч үздэггүй болно.

Эрх зүйн тодорхой бие даасан салбар гэж үзэхийн тулд тухайн салбарын гэж нэрлэж, системчилж болохуйц эрх зүйн хэм хэмжээнүүд хуримтлагдсан байх ёстой. Худалдааны эрх зүй гэсэн бие даасан салбар эрх зүйн үүсэж хөгжих ул үндэс нь дундад зууны үеээс хөгжиж ирсэн, тухайн үеийн Европын худалдаачид дунд хэрэглэгдэж байсан “Lex mercatoria” гэх худалдааны эрх зүйн хэм хэмжээнүүд юм. Өнөө цаг үед хууль, эрх зүйн хэм хэмжээ гэвэл парламент зэрэг төрийн байгууллагаас баталсан хэм хэмжээний тухай ярьдаг бол, эсэргээрээ “Lex mercatoria” нь төрийн оролцоогүйгээр тухайн үеийн худалдаачдын худалдааны практикаас үүсэж хөгжсөн эрх зүйн хэм хэмжээ, зарчмын нийлбэр цогц байсан бөгөөд худалдаачдын дундах худалдааны практик, заншлын бүтээгдэхүүн гэж хэлж болно. “Lex mercatoria” нь худалдааны практиктаас үүссэн эрх зүйн хэм хэмжээний нийлбэр цогц байхын зэрэгцээ маргаан гарсан тохиолдолд түүнийг хурдан шуурхай, шударга шийдвэрлэх тогтолцоог ердийн шүүхээс тусад нь бий болгосон байдаг. Энэ нь мөн л цаг алдалгүйгээр маргаанаа хурдан шуурхай шийдвэрлүүлэх гэсэн тухайн үеийн худалдаачдын хэрэгцээ, шаардлагатай холбоотой үүссэн бөгөөд өнөө үеийн худалдааны арбитр, шүүхийн эх үндэс болсон байдаг. Гол онцлог нь худалдааны маргааныг шийдвэрлэх гэж буй этгээд нь худалдааны практик, заншлын талаар мэдлэг, туршлагатай байх ёстой байдаг.

Үүнээс гадна хамгийн чухал асуудал нь Иргэний хуулиас Худалдааны хуулийг салгах шаардлагатай эсэх, Худалдааны хууль гэсэн бие даасан хууль байх шаардлагатай эсэх нь анхаарал татсан асуудал байдаг. Дэлхий нийтийн хүрээнд мөн Иргэний хуулийг худалдааны шинжтэй болгох(Commercialization of Civil Code), Худалдааны хуулийг иргэний эрх зүйн шинжтэй болгох(Civilization of Commercial Code) гэсэн хандлагууд гарч ирсэн бөгөөд энэ талаарх харьцуулсан судалгааг орхигдуулж болохгүй юм. Өөрөөр хэлбэл Иргэний хууль болон Худалдааны хуулийн харилцан хамаарал, зохицуулалтын хэв шинж орчин үед ямар байх ёстой талаарх судалгаа гэж хэлж болно.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БҮТЦИЙН ХАРЬЦУУЛАЛТ

Энэхүү судалгааны хүрээнд дараах орнуудын арилжааны хууль тогтоомжийг харьцуулан судална.

№	Гадаад улс	Нэршил	Хэсэг	Зүйл, заалт
1	ХБНГУ	Handelsgesetzbuch ¹ Батлагдсан он сар өдөр 1897.05.10	I. Худалдаа эрхлэгчийн нийтлэг зохицуулалт	§§ 1–104a
			II. Худалдааны компани болон нөхөрлөл	§§ 105–237
			III. Худалдааны нягтлан бодох бүртгэл	§§ 238–342e
			IV. Худалдааны хэлцэл	§§ 343–475h
			V. Далайн худалдаа	§§ 476 ff–617
3	Япон	商法 Батлагдсан он сар өдөр 1899 он	I. Нийтлэг үндэслэл	§§1-500
			II. Худалдааны хэлцэл	§§501-683
			III. Далайн худалдаа	§§684-850
5	Вьетнам	Luật Thương mại Батлагдсан он сар 2001.12.25	I. Нийтлэг үндэслэл	§§1-23
			II. Хөрөнгө худалдах худалдан авах	§§24-73
			III. Үйлчилгээ үзүүлэх	§§74-87
			IV. Худалдааны үйл ажиллагаа хөхиүлэн дэмжих үйл ажиллагаа	§§88-140
			V. Худалдааны үйл ажиллагаанд оролцох	§§141-177
			VI. Бусад худалдааны үйл ажиллагаа	§§178-291
			VII. Худалдааны харилцаанд гарсан маргааныг шийдвэрлэх	§§292-319
			VIII. Худалдааны хуулийн зөрчилд хүлээлгэх хариуцлага	§§320-322
			IX. Бусад	§§323-324

1.1 ХБНГУ-ын Худалдааны хууль

ХБНГУ-ын Худалдааны хууль нь худалдааны эрх зүйн субьектив онолд тулгуурладаг бөгөөд энэхүү онол хамгийн түрүүлж худалдаачин гэж хэнийг хэлэх вэ гэдгийг тодорхойлсноор Иргэний хуулиас Худалдааны хуулийг ялган хэрэглэх боломжийг олгож байдаг. Субьектив онол нь худалдааны хуулийг бүтээх дэлхий нийтийн сүүлийн үеийн чиг хандлага юм. Вьетнамын Худалдааны хуулийн 6-р зүйлд “Худалдаан эрхлэгч гэдэг нь хууль ёсны дагуу байгуулагдсан хуулийн этгээд болон бие даан тогтвортой аж ахуйн үйл ажиллагаа явуулж буй хувь хүн бөгөөд худалдааны бүртгэлд бүртгэгдсэн этгээдийг хэлнэ” гэж зааснаас үүнийг харж болно. Нөгөө талаас манай улсын иргэний хуулийг бүтээхэд

¹ <https://www.gesetze-im-internet.de/hgb/>

ХБНГУ-ын Иргэний хуулийг жишээ болгон судалсан байдаг тул тус улсын Худалдааны хуулийг судлах харьцуулан судлах нь Арилжааны хуулийг бүтэхэд системчлэлийн хувьд чухал ач холбогдолтой болно.

ХБНГУ-ын Худалдааны хууль/HGB;Handelsgesetzbuch / нь 1897 оны 5 сарын 10 өдөр худалдааны үйл ажиллагаа эрхэлдэг тодорхой этгээдүүд болон тодорхой эдийн засгийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулах **Иргэний хуулийн тусгай хууль** байдлаар батлагджээ. ХБНГУ-ын Худалдааны хуулийн онцлог нь хэлцэл байгуулах, дуусгавар болгох явдлыг хялбар, хурдан шуурхай болгох, хувийн хариуцлагын зарчим хууль зүйн тодорхой байдлыг чухалчлах, нээлттэй, ил тод байх зарчимд тугуурлах, итгэл үнэмшлийг хамгаалах болон олон улсын худалдааны стандартад нийцдэгт байдаг. ХБНГУ-ын Худалдааны хууль нь 1896 оны 8 сарын 18-ний өдөр батлагдсан ХБНГУ-ын Иргэний хуультай хамт 1900 оны 1 сарын 1-нээс эхлэн хэрэгжиж эхэлжээ.

Одоо хэрэгжиж буй ХБНГУ-ын Худалдааны хуулийн 1 дэх хэсэг Худалдаа эрхлэгчийн нийтлэг зохицуулалт, 2 дахь хэсэг нь Худалдааны компани болон нөхөрлөл, 3 дахь хэсэг нь Худалдааны нягтлан бодох бүртгэл, 4 дэх хэсэг нь Худалдааны хэлцэл, 5 дахь хэсэг нь Далайн худалдаа гэсэн бүтэцтэй байна.

ХБНГУ-ын Худалдааны хуулийн 1 дэх хэсэг болох Худалдаа эрхлэгчийн нийтлэг зохицуулалт нь дотроо дараах 9 бүлэгт хуваагдаж байна.

1-р бүлэг	Худалдаа эрхлэгч/ Kaufleute /
2-р бүлэг	Худалдааны бүртгэл; аж ахуйн нэгжийн бүртгэл/Handelsregister; Unternehmensregister/
3-р бүлэг	Худалдааны нэр буюу фирм/Handelsfirma /
4-р бүлэг	Худалдааны нягтлан бодох бүртгэл /Handelsbücher /
5-р бүлэг	Прокура болон худалдааны төлөөлөл /Prokura und Handlungsvollmacht /
6-р бүлэг	Туслах ажилтан, дадлагажигч /Handlungsgehilfen und Handlungslehrlinge /
7-р бүлэг	Худалдааны төлөөлөгч /Handelsvertreter /
8-р бүлэг	Худалдааны зуучлагч /Handelsmakler /
9-р бүлэг	Торгуулийн зохицуулалт / Bußgeldvorschriften /

1985 оны нэмэлт өөрчлөлтөөр Худалдааны нягтлан бодох бүртгэл гэсэн 4-р бүлэг хүчингүй болж, уг хуулийн **Худалдааны нягтлан бодох бүртгэл** гэсэн 3 дахь хэсэг болж бие даасан хэсэг болж өөрчлөгджээ.

Энэхүү 1 дэх хэсэгт Худалдааны хууль үйлчлэх этгээд болох “худалдаа эрхлэгч” гэх ойлголтын тухай тодорхойлохоос гадна Худалдааны бүртгэл; аж ахуйн нэгжийн бүртгэл, Худалдааны нэр гэх мэт худалдааны үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжтэй холбогдох үндсэн тогтолцоонуудын талаарх зохицуулалтууд тусгагджээ. Гэхдээ 6-р бүлэгт Туслах ажилтан, дадлагажигч гэсэн хөдөлмөрийн эрх зүйд хамаарах асуудал, мөн 7-р бүлэгт Худалдааны төлөөлөл, 8-р бүлэгт Худалдааны зуучлал гэсэн худалдааны хэлцэлд хамаарах асуудлыг хуульчилсан байна.

ХБНГУ-ын Худалдааны хуулийн 1 дэх хэсгийн хувьд 1989 оны нэмэлт өөрчлөлтөөр худалдааны төлөөлөлтэй холбоотой зохицуулалтыг шинэчилсэн найруулгын хэмжээнд өөрчилсөн байдаг. Түүнчлэн 1998 оны 6 сарын 22-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр Худалдааны хуулийн хамгийн суурь ойлголт болох “худалдаа эрхлэгч” гэх ойлголтыг үндсээр өөрчилсөн нэмэлт өөрчлөлт оржээ. Уг өөрчлөлтөөр “Зайлшгүй худалдаа эрхлэгч-Mußkaufmann” болон “Худалдаа эрхлэгч байх ёстой этгээд - Sollkaufmann” гэсэн

ойлголтуудыг нэгтгэж, Худалдааны үйл ажиллагаа(Handelsgewerbe) эрхэлж буй этгээд гэсэн урьдчилсон нөхцөлийн доор Заавал худалдаа эрхлэгч байх ёстой этгээд(**Ist kaufmann**) гэсэн ойлголтыг шинээр бий болгосон. Үүний улмаас **үндсэн худалдааны хэлцэлийг** аж ахуйн үйл ажиллагаа болгож явуулж буй эсэхээс хамааран “Зайлшгүй худалдаа эрхлэгч-mußkaufmann” болон “Худалдаа эрхлэгч байх ёстой этгээд - Sollkaufmann” гэж ангилдаг байдлыг 1998 оны энэхүү өөрчлөлтөөр халжээ. 1998 оны нэмэлт өөрчлөлтөөр шинээр Худалдааны үйл ажиллагаа(Handelsgewerbe) гэж юуг хэлэх талаар тус хуулийн 1-р зүйлийн 1.2 дахь хэсэгт “Худалдааны үйл ажиллагаа гэдэгт аж ахуйн үйл ажиллагааны төрөл, цар хүрээ нь худалдаа эрхлэгчийн байдлаар зохион байгуулагдан аж ахуйн үйл ажиллагаа явуулах шаардлагагүй гэж үзэхээс бусад аж ахуйн үйл ажиллагаанд хамаарах бүхий л тохиолдлыг ойлгоно 2” гэсэн тодорхойлолтыг хуульчилж өгсөн.

Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа нь Худалдааны хуулийн 1-р зүйлийн 1.2 дахь хэсэгт заасан худалдааны үйл ажиллагаанд хамаарахгүй байсан ч, тухайн аж ахуйн нэгж худалдааны нэрээ худалдааны бүртгэлд бүртгүүлсэн тохиолдолд түүний үйл ажиллагаа нь худалдааны үйл ажиллагаа болох боловч худалдааны бүртгэлд өөрийн худалдааны нэрээ бүртгүүлэх эсэх нь өөрөө шийдвэрлэх эрхтэй(Худалдааны хуулийн 2-р зүйл). Түүнчлэн хөдөө аж ахуй болон ойн аж ахуй эрхэлдэг этгээд нь түүний үйл ажиллагааны төрөл болон цар хүрээнээс авч үзвэл худалдаачин байдлаар зохион байгуулагдах замаар аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх шаардлагатай бол худалдааны бүртгэлд бүртгүүлж болно(Худалдааны хуулийн 3-р зүйл), бүртгүүлсэн тохиолдолд худалдааны үйл ажиллагаа явуулж байна гэж үзэгдсэн худалдаа эрхлэгчийн хувьд эрх зүйн харилцаанд оролцоно. Худалдааны бүртгэлд бүртгүүлэх эсэхээ шийдэх боломжтой эдгээр этгүүдүүд бүртгэгдсэн тохиолдолд Худалдаа эрхлэгч байж болох этгээд(**Kannkaufmann**) болдог.

Худалдааны хуулийн 6-р зүйлд зааснаар компанийг худалдааны үйл ажиллагаа явуулах эсэхээс үл хамааран түүний эрх зүйн байдалд үндэслэн худалдаа эрхлэгч гэж үзэн Худалдааны хуулиар эрх зүйн харилцааг нь зохицуулдаг. Компани нь Хэлбэрийн улмаас худалдаа эрхлэгч(**Formkaufmann**) болдог.

ХБНГУ-ын Худалдааны хуулийн 2 дахь хэсэг болох Худалдааны нөхөрлөлүүд болон далд хамтран ажиллах гэрээ/Handelsgesellschaften und stille Gesellschaft/ нь дотроо дараах 3 бүлэгт хуваагдаж байна.

1-р бүлэг	Нээлттэй худалдааны нөхөрлөл /Offene Handelsgesellschaft/ §§105-160
2-р бүлэг	Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл /Kommanditgesellschaft/ §§161-229
3-р бүлэг	Далд нөхөрлөл /Stille Gesellschaft/ §§230-237

ХБНГУ-д хамтран ажиллах гэрээний тулгуурлан бий болдог байгууллагыг хөрөнгийн нэгдэл(Kapitalgesellschaft) болон эрх зүйн этгээдүүдийн нэгдэл(Personengesellschaft) гэж 2 ангилдаг байна.

Хөрөнгийн нэгдэл (Kapitalgesellschaft) гэсэн төрөлд хуулийн этгээдийн эрх бүхий Хувьцаат компани (Aktiengesellschaft;AG), Хязгаарлагдмал хариуцлагатай компани (Gesellschaft mit beschränkter Haftung;GmbH), Хувьцаат хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл (Kommanditgesellschaft auf Aktien;KGA), Хязгаарлагдмал хариуцлагатай аж ахуй эрхлэгч компани (Unternehmergesellschaft (haftungsbeschränkt) зэрэг компаниуд

2 (2) Handels-gewerbe ist jeder **Gewerbebetrieb**, es sei denn, daß das Unternehmen nach Art oder Umfang einen in kaufmännischer Weise eingerichteten Geschäftsbetrieb nicht erfordert. (<http://www.gesetze-im-internet.de/hgb/BJNR002190897.html#BJNR002190897BJNG000300300>)

хамаардаг байна. Эдгээр компаниудын харилцааг ХБНГУ-ын Хувьцаат компанийн тухай хууль (AktG), Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн тухай хууль(GmbHG)-иар зохицуулагдаж байна.

Эрх зүйн этгээдүүдийн нэгдэл (Personengesellschaft) гэсэн төрөлд хуулийн этгээдийн эрхгүй нөхөрлөлүүд болох **Нээлттэй худалдааны нөхөрлөл (offene Handelsgesellschaft;OHG)**, Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл (Kommanditgesellschaft;KG) хамаардаг. Хэдийгээр уг хоёр нөхөрлөл нь хуулийн этгээдийн эрхгүй боловч эрх зүйн субъект болдог онцлогтой бөгөөд эрх зүйн харилцаа нь Худалдааны хуулиар зохицуулагддаг.

ХБНГУ-ын Худалдааны хуулийн 3 дахь хэсэг болох Худалдааны нягтлан бодох бүртгэл/ Handelsbücher / нь дотроо дараах 6 бүлэгт хуваагддаг.

1-р бүлэг	Худалдаа эрхлэгчдэд зориулсан нийтлэг зохицуулалт/ Vorschriften für alle Kaufleute / §§238-263
2-р бүлэг	Хөрөнгийн нэгдэл(Хувьцаат компани, Хувьцаат хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл, Хязгаарлагдмал хариуцлагатай компани) болон бусад тодорхой эрх зүйн этгээдүүдийн нэгдэлд хамаарах нөхвөр зохицуулалт /Ergänzende Vorschriften für Kapitalgesellschaften (Aktiengesellschaften, Kommanditgesellschaften auf Aktien und Gesellschaften mit beschränkter Haftung) sowie bestimmte Personenhandelsgesellschaften/ §§264-335
3-р бүлэг	Бүртгэгдсэн нөхөрлөлд зориулсан нөхвөр зохицуулалт/Ergänzende Vorschriften für eingetragene Genossenschaften/ §§336-339
4-р бүлэг	Зарим салбарын аж ахуй нэгжид зориулсан нөхвөр зохицуулалт/Ergänzende Vorschriften für Unternehmen bestimmter Geschäftszweige/ §§340-341y
5-р бүлэг	Хувийн тайлан гаргах зөвлөл ба зөвлөх/Private Rechnungslegungsgremium. Rechnungslegungsbeirat/ §§342-342a
6-р бүлэг	Нягтлан бодох бүртгэлийг хянах газар /Prüfstelle für Rechnungslegung/ §§342b-342e

Уламжлалт нягтлан бодох бүртгэлийн стандартыг Европын эх газрын нягтлан бодох бүртгэлийн стандарт болон Англо-саксоны нягтлан бодох бүртгэлийн стандарт гэж 2 ангилдаг байна. **Европын эх газрын нягтлан бодох бүртгэлийн стандартын** төлөөлөл болох орнууд нь Герман, Франц бөгөөд санхүүгийн байдлын тайлан(balance sheet)-д тулгуурлан үүрэг гүйцэтгүүлэгчидийг хамгаалахыг чухалчилдаг стандарт юм. Англи улс тэргүүтэй улсуудын баримталдаг **Англо-саксоны нягтлан бодох бүртгэлийн стандарт** нь орлогын тайлан()-г голчлон хөрөнгө оруулагчдыг хамгаалахыг чухалчилдаг стандарт юм.

ХБНГУ-ын нягтлан бодох бүртгэлийн тогтолцооны үндэс суурь нь Худалдааны 3 дахь хэсэг юм. 1985 оноос 30 гаруй жилийн хугаацаанд шинэчлэгдэж буй хэсэг гэж хэлж болно. Гол шинэчлэлүүд нь тус улсын улалмжлалт нягтлан бодох бүртгэлийн тогтолцоог Европын холбоо болон олон улсын стандартад нийцүүлэх зорилготой хийгдсэн байна.

1970-аад оны сүүл үеэс Европын хамтын нийгэмлэг(European Community) нь гишүүн улсуудынхаа нягтлан бодох бүртгэлийн стандартыг хооронд нь нийцүүлэх, нэгдмэл болгох зорилгоор 1978 оны 7 сард Ашгийн төлөөх компани дангаар гаргах

нягтлан бодох бүртгэлийн тайлагналтай холбоотой 4-р заавар³, 1983 оны 6 сард Групп компани буюу концерний гаргах нягтлан бодох бүртгэлийн тайлагналтай холбоотой 7-р заавар⁴, 1984 оны 12 сард Аудитын шалгууртай холбоотой 8-р заавар⁵-ыг тус тус батлан гаргасан байдаг. Европын холбооны эрх зүйн хэм хэмжээ нь гэрээ(treaty), журам(regulation), заавар(directive) гэсэн 3-н төрлөөр гардаг бөгөөд зааврын агуулга нь тогтоосон хугацаанд гишүүн улсын дотоодын хуулинд тусгагдаж байж сая үйлчилж эхэлдэг.

Европын хамтын нийгэмлэгийн 4-р заавар, 7-р заавар нь Англо-саксоны нягтлан бодох бүртгэлийн стандартын нөлөө их орсон байсан тул ХБНГУ эдгээр зааврыг дотоодын хууль болгон хуульчилахад нилээдгүй маргаан дагуулсан боловч Англи нягтлан бодох бүртгэлийн стандартын суурь зарчим болох **True and fair view;TFV** гэсэн зарчмыг **Die Grundsätze ordnungsmäßiger Buchführung;GoB** гэсэн 1965 оны Хувьцаат компаний тухай хуулиас хойшхи нягтлан бодох бүртгэлийн стандартын суурь үзэлтэй нийцэж байна гэж үзэн хүлээн зөвшөөржээ.

1985	Нягтлан бодох бүртгэлийн зааврын тухай хууль/Bilanzrichtlinien-Gesetz;BiRiLiG/	Уг хуулиар дээр дурдсан Европын хамтын нийгэмлэгийн 3 зааврын агуулгыг дотоодын хуулиар хуульчилж өгсөн ба мөн онд Худалдааны хуульд Нягтлан бодох бүртгэлийн тухай 3 дахь хэсгийг шинээр бий болгосныг өмнө дурдсан.
1998	Санхүүжилтыг хялбарчлах тухай хууль /Kapitalaufnahmeerleichterungsgesetz;KapAEG/	Хөрөнгийн биржид бүртгэлтэй концерн компанийн нягтлан бодох бүртгэлийн тайланг заавал ХБНГУ-ын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу бус олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нягтлан бодох бүртгэлийн стандартыг хэрэглэж болохыг хүлээн зөвшөөрсөн байна.
1998	Аж ахуйн нэгж дэх удирдлага, ил тод байлдыг хангах тухай хууль/Gesetz zur Kontrolle und Transparenz im Unternehmensbereich;KonTraG/	Худалдааны хуулийн 297-р зүйлийн 297.1 дэх хэсэг болон 342, 342а-р зүйлийг шинээр бий болгосон. Хөрөнгийн биржд бүртгэлтэй концернийн санхүүгийн тайлангийн агуулгыг өргөтгөн Германы уламжлалт санхүүгийн тайлагналд байгаагүй мөнгөн гүйлгээний тайлан, салбарын тайланг хавсралтаар санхүүгийн тайланд тусгахын хуульчилж өгсөн байна.
2000	Хөрөнгийн нэгдлийн компаниудын зааврын тухай хууль /Kapitalgesellschaften-und Co.Richtlinie-Gesetz;	Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нягтлан бодох бүртгэлийн стандартыг хэрэглэж болох субъектын хүрээг өргөтгөсөн.

3 Fourth Council Directive 78/660/EEC of 25 July 1978 based on Article 54 (3) (g) of the Treaty on the annual accounts of certain types of companies.

4 Seventh Council Directive 83/349/EEC of 13 June 1983 based on the Article 54 (3) (g) of the Treaty on consolidated accounts.

5 EIGHTH COUNCIL DIRECTIVE - QUALIFICATIONS OF PERSONS RESPONSIBLE FOR CARRYING OUT THE STATUTORY AUDITS OF ACCOUNTING DOCUMENTS (84/253/EEC)

	KapCoRiLiG/	
2002	Ил тод, нийтэд нээлттэй байдлыг хангах тухай хууль/Gesetz zur weiteren Reform des Aktien- und Bilanzrechts zu Transparenz- und Publizität; TransPug/	Худалдааны 297-р зүйлийн агуулгыг шинэчлэн найруулж концернийн санхүүгийн тайлангийн агуулгыг тодорхойлсон.
2004	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиудыг шинэчлэх тухай хууль /Bilanzrechtsreformgesetz; BilReG/	Хөрөнгийн биржид хувьцаагаа санал болгох гэж буй концернийн нягтлан бодох бүртгэлийн тайлан олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартыг хэрэглэх талаар хуульчилсан
2009	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиудыг орчин үежүүлэх тухай хууль Bilanzrechtsmodernisierungsgesetz; BilMoG	Нягтлан бодох бүртгэлийн эрх зүйн зохицуулалтыг бүхэлд нь олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэх зорилготой шинэчлэлийг хэрэгжүүлсэн байна.

1999 оны 1 сарын 1 нэгнээс Европын холбоо еврог нэвтрүүлсэнтэй зэрэгцэн нягтлан бодох бүртгэлийн стандартын нэгдмэл байдлыг хангах үүднээс Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандарт(International Accounting Standards)-ыг баримтлах болжээ.

ХБНГУ-ын Худалдааны хуулиас 1937 онд Хувьцаат компани тухай хууль бие даасан хууль болж салсан, 1950 онд Хоршоо болон Вексель, чекийн тухай бие даасан хууль болж салсан учраас Худалдааны хуулийн зохицуулалт “хөндий, хоосон” болох шинжтэй болж ирсэн боловч 1985 онд ийнхүү шинээр Худалдааны хуульд 102 зүйлээс бүрдэх Нягтлан бодох бүртгэлийн талаар том хэсэг бий болгосон нь чиг хандалгагыг өөрчилсөн хэрэг болжээ.

ХБНГУ-ын Худалдааны хуулийн 4 дэх хэсэг болох Худалдааны хэлцэл /Handelsgeschäfte/ нь дотроо дараах 4 бүлэгт хуваагддаг.

1-р бүлэг	Нийтлэг зохицуулалт / Allgemeine Vorschriften / §§343-372
2-р бүлэг	Худалдааны худалдах худалдан авах гэрээ/ Handelskauf / §§373-382
3-р бүлэг	Худалдааны комиссын гэрээ/ Kommissionsgeschäft / §§383-406
4-р бүлэг	Тээвэрлэлт/ Frachtgeschäft / §§407-452d
5-р бүлэг	Тээвэр зуучийн гэрээ/ Speditionsgeschäft / §§453-466
6-р бүлэг	Хадгалалтын гэрээ/ Lagergeschäft / §§467-475h

ХБНГУ-ын Худалдааны хуулийн энэхүү хэсэг нь 19-р зууны үеийн худалдааны нөхцөл байдлыг хамгийн ихээр тусгасан хэсэг гэж үздэг. 1998 оны 6 сарын 25-нд Тээвэрлэлтийн гэрээтэй холбоотой зохицуулалтад шинэчилсэн найруулга хийсэн байна. Энэхүү өөрчлөлтөөс өмнө тээвэрлэлтийн харилцаатай холбоотой олон салангид хууль оршин байсан ба агуулга нь давхардал ихтэй, тухайн үеийн нөхцөл байдалд тохирохгүй болж иржээ. Худалдааны хууль дахь тээвэрлэлтийн гэрээний зохицуулалт ач холбогдол муутай байсан учраас цэгцэлж, орчин үеийн нөхцөл байдалд тохируулан өөрчилсөн байна. Түүнчлэн олон улсын гэрээний агуулгад нийцүүлэх, хэм хэмжээний агуулгыг диспозитив шинжтэй болгох гэсэн санаанд тулгуурлан шинэчлэлийг өрнүүлсэн байна.

Өмнө дурдсанчлан Худалдааны хуулийн 3 дахь хэсгийн адилаар ХБНГУ-н эрх зүйн зохицуулалтанд Европын холбооны эрх зүйн зохицуулалтын нөлөө их орж байгаа бөгөөд

1986 оны 12-р сард Европын хамтын нийгэмлэгээс Худалдааны төлөөлөгчтэй холбоотой зааврыг батлан гаргасан бөгөөд 1989 оны Худалдааны хуулийн нэмэлт өөрчлөлтөөр уг зааврын агуулгын дагуу худалдааны төлөөлөгчтэй холбоотой хэсгийг шинэчлэн найруулсан байна.

ХБНГУ-ын Худалдааны хуулийн 5 дахь хэсэг болох Далайн худалдаа/Seehandel/ нь дотроо дараах 11 бүлэгт хуваагддаг.

1-р бүлэг	Усан онгоц тээвэрт холбогдох этгээд/ Personen der Schifffahrt / §§476-480
2-р бүлэг	Тээвэрлэлтийн гэрээ/ Beförderungsverträge / §§481-552
3-р бүлэг	Усан онгоц түрээслэх гэрээ/ Schiffsüberlassungsverträge / §§553-569
4-р бүлэг	Усан онгоцны ослын байдал/ Schiffsnotlagen / §§570-595
5-р бүлэг	Хөлөг онгоцны үүрэг гүйцэтгүүлэгч/ Schiffsgläubiger / §§596-604
6-р бүлэг	Хөөн хэлэлцэх хугацаа/ Verjährung / §§605-610
7-р бүлэг	Хариуцлагыг хязгаарлах ерөнхий зохицуулалт/ Allgemeine Haftungsbeschränkung / §§611-617
8-р бүлэг	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зохицуулалт/ Verfahrensvorschriften / §§618-619
9-р бүлэг	Хүчингүй болсон
10-р бүлэг	Хүчингүй болсон

1.2 ЯПОН УЛСЫН ХУДАЛДААНЫ ХУУЛЬ

Япон улс нь бусад улсын сайн туршлагыг өөрийн орны онцлогт нийцүүлэн авч ашиглагдаараа алдартай билээ. Энэ үүднээс авч үзвэл европын орнуудад хөгжиж ирсэн худалдааны эрх зүйн тогтолцоог өөрийн орны эрх зүйн системд хэрхэн буулгаж, хэрэгжүүлж байгаа талаар авч үзэх нь харьцуулсан эрх зүйн чухал ач холбогдолтой.

Япон улсын Худалдааны хууль нь анх Мэйжигийн 23 (1890) онд Германы эрдэмтэн Херман Ройслер/Hermann Roesler/-ийн төсөлд үндэслэн батлагдсан байдаг. Гэвч хэрэгжиж эхлэх хугацааг нь сунгасаар түүний зөвхөн нэг хэсэг (компани, вексел, дампууралтай холбоотой зохицуулалтууд) нь л Мэйжигийн 26 (1893) онд хэрэгжиж эхэлсэн. Түүний дараагаар Мэйжигийн 32 (1899) дугаар онд хуучин Худалдааны хууль хэрэгжиж эхлэлгүй хүчингүй болж шинэ Худалдааны хууль батлагджээ. Тус Худалдааны хууль нь хэд хэдэн удаа өөрчлөлт орсон боловч одоог хүртэл хүлээн зөвшөөрөгдсөн хэвээр хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Япон улсын Худалдааны хууль нь ерөнхий анги, худалдааны хэлцэл, далайн худалдаа гэсэн 3 үндсэн хэгээс бүрдэнэ.

Япон улсын худалдааны хууль анх батлагдахдаа 5 хэсэгтэй байжээ. Үүнд 1 дэх хэсэг нь Ерөнхий анги, 2 дахь хэсэг нь Компани, 3 дахь хэсэг нь Худалдааны хэлцэл, 4 дэх хэсэг Вексель, 5 дахь хэсэг нь Далайн худалдаа байсан. 1932 онд Векселийн тухай бие даасан хууль батлагдсанаар вексэлийн тухай зохицуулж байсан Худалдааны хуулийн 4 дэх хэсгийн 1-3 дахь бүлэг хүчингүй болж, 1933 онд Чекийн тухай бие даасан хууль батлагдаж чекийн талаар зохицуулж байсан Худалдааны хуулийн 4 дэх хэсгийн 4 дэх бүлэг хүчингүй болсноор, Худалдааны хуулийн 4 дэх хэсэг бүхэлдээ хүчингүй болж, Худалдааны хууль нийт 4 бүлэгтэй үлджээ. Үүний дараагаар 2005 онд Компанийн тухай бие даасан хууль батлагдаж, компанийн талаар зохицуулж байсан Худалдааны хуулийн 2 дахь хэсэг бүхэлдээ хүчингүй болжээ. 2008 онд Даатгалын тухай бие даасан хууль батлагдсанаар Худалдааны хуулийн даатгалын гэрээтэй холбоотой зохицуулалт хүчингүй болжээ. Ийнхүү Япон улсын Худалдааны хууль нь 3 хэсэгтэй болж үлдсэн бөгөөд хэсэг бүрийн агуулгыг нь танилцуулъя.

Япон Улсын Худалдааны хуулийн 1 дэх хэсэг нь дотроо 7 бүлэгтэй байна.

1-р бүлэг	Нийтлэг үндэслэл/通則/ §§1-3
2-р бүлэг	Худалдаа эрхлэгч/商人/ §§4-7
3-р бүлэг	Худалдааны бүртгэл/商業登記/§§8-10
4-р бүлэг	Худалдааны нэр/商号/§§11-18
5-р бүлэг	Худалдааны нягтлан бодох бүртгэл/商業帳簿/§§19
6-р бүлэг	Худалдааны ажилтан/商業使用人/ §§21-26
7-р бүлэг	Худалдааны төлөөлөл/代理商/27-31

Япон Улсын Худалдааны хуулийн 2 дахь хэсэг нь дотроо 9 бүлэгтэй байна.

1-р бүлэг	Нийтлэг үндэслэл/総則/ §§501-523
2-р бүлэг	Худалдах худалдан авах гэрээ/売買/§§524-528
3-р бүлэг	Тооцоо нийлэх гэрээ/交互計算/ §§529-534
4-р бүлэг	Далд хамтран ажиллах гэрээ /匿名組合/ §§535-542
5-р бүлэг	Худалдааны зуучлал /仲立営業/§§543-550
6-р бүлэг	Худалдааны комисс/問屋営業/§§551-558
7-р бүлэг	Тээвэр зуучлал/運送取扱営業/§§559-568
8-р бүлэг	Тээвэрлэлтийн гэрээ/運送営業/§§569-594
9-р бүлэг	Хадгалалтын гэрээ/寄託/§§595-683

Япон Улсын Худалдааны хуулийн 3 дахь хэсэг нь дотроо 8 бүлэгтэй байна.

1-р бүлэг	Усан онгоц/船舶/ §§684-707
2-р бүлэг	Усан онгоцны ахмад/船長/§§708-736
3-р бүлэг	Далайн тээврийн тусгай зохицуулалт/海上物品運送に関する特則/ §§737-787
4-р бүлэг	Далай дахь осол /船舶の衝突/ §§788-791
5-р бүлэг	Ослын тусламж/海難救助 /§§792-807
6-р бүлэг	Хамтын хохирол хүлээх тогтолцоо/共同海損/§§808-814
7-р бүлэг	Далайн худалдааны даатгал/海上保険/§§815-841
8-р бүлэг	Далайн худалдаа дахь барьцааны эрх/船舶先取特權及び船舶抵当權/§§842-850


1.3 ВЬЕТНАМ УЛСЫН ХУДАЛДААНЫ ХУУЛЬ

Вьетнам улс 1986 онд зах зээлийн эдийн засгийн тогтолцоо руу шилжсэн бөгөөд Япон улсын ЖАЙКА-гийн техникийн туслалцаатайгаар зах зээлийн эдийн засагт тохирсон эрх зүйн системийг бүрдүүлж чадсан орон юм. Вьетнамын Худалдааны хууль нь шинэ үеийн худалдааны хууль тул 21-р зууны худалдааны хууль ямар байх талаар дүр төрхийг бидэнд харуулна гэж үзэж байна. Нөгөө талаас Вьетнам улс социалист эрх зүйн тогтолцоотой орон байсан тул эрх зүйн уламжлалын хувьд манай улстай нийтлэг тал олонтой юм. Иймд Вьетнамын Худалдааны хуулийг шинэ үеийн хууль, мөн манай улстай адил социалист эрх зүйн тогтолцоотой байсан гэдэг талаас нь харьцуулан судлах ач холбогдолтой гэж үзлээ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХУДАЛДААНЫ ХУУЛИЙН ЗАРЧИМ

Худалдааны хуулийн зарчмыг ерөнхий ангийн болон хэлцлийн гэж 2 хэсэгт хуваан авч үзэж болно.

2.1 ХУДАЛДААНЫ ХУУЛИЙН ЕРӨНХИЙ АНГИЙН ЗАРЧИМУУД



Ашгийн төлөөх зарчим.

Худалдаа эрхлэгчийн үйл ажиллагаа нь ашгийн төлөөх зорилгыг агуулдаг бөгөөд үүний тулд худалдаа эрхлэгч нь аль болох олон тооны ажрилжааг зохих байдлаар хийхийг зорьдог. Иймээс олон удаагийн их хэмжээтэй, дахин давтагдан хийгдэх арилжааны харилцааг шуурхай, найдвартай явуулахын тулд Худалдааны хуулийн ерөнхий ангид арилжааны шуурхай, баталгаатай байдлыг хангах заалтуудыг тусгаж өгдөг. Түүнчлэн худалдаа эрхлэгчийн зүй ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор өрсөлдөхгүй байх үүрэг зэрэг агуулгыг Худалдааны хуулийн ерөнхий ангид заадаг.

Хэлцлийн баталгаат байдлын зарчим .

Худалдааны хуулийн ерөнхий ангийн хувьд хэлцлийн баталгаат байдлын зарчим нь **гадаад идрэлд тулгуурлах зарчим** болон **нийтэд ил тод байх зарчим**ыг авч хэрэгжүүлснээр хангагддаг.

Гадаад илрэлд тулгуурлах зарчим/ger. Rechtsscheintheorie, анг. Estoppel/

Арилжааг хурдан шуурхай явуулахын тулд арилжааны харилцаанд гадаад илрэлд итгэж болох боломжтой байх шаардалгатай бөгөөд хэлцлийн баталгаат байдлыг хангахын тулд гадаад илрэл нь бодит үнэнтэй нийцэхгүй тохиолдолд гадаад илрэлд итгэсэн этгээдийг хамгаалах ёстой.

Нийтэд ил тод байх зарчим

Арилжааны харилцаанд чухал мэдээллийг нээлттэй болгохын тулд Худалдааны хуулийн ерөнхий ангид худалдаа эрхлэгчтэй холбоотой төрөл бүрийн мэдээллийг нийтэд мэдэгдэх арга хэрэгсэл болгож худалдааны бүртгэлийн тогтолцоог хуульчилж өгдөг байна.

ХБНГУ-ын Худалдааны хууль⁶

§ 15 [Бүртгэлийг нийтэд ил болгох]

(1) Арилжааны бүртгэлд бүртгүүлбэл зохих үйл баримтыг бүртгүүлээгүй буюу нийтэд ил болгоогүй этгээд энэ мэдээллийг энэ талаар мэдээгүй гуравдагч этгээдийн эсрэг ашиглаж үл болно.

Худалдаа эрхлэгчийн ашиг сонирхлыг хамгаалах зарчим

Худалдаа эрхлэгч нь бусдыг авч ажиллуулах тохиолдолд худалдаа эрхлэгчийн ашиг сонирхолыг хамгаалах үүднээс “өрсөлдөхгүй байх үүрэг”-ийг тодорхой этгээдүүдэд оноосон байдаг. Түүнчлэн худалдааны үйл ажиллагаагаа шилжүүлсэн этгээд нь шилжүүлж авсан этгээдтэй өрсөлдөхгүй байх үүргийг оноосон байна. Худалдааны нэрийг хуулиар хамгаалж байгаа нь үүний нэг жишээ болно.

ХБНГУ-ын Худалдааны хууль⁷

§ 60 [Өрсөлдөх хориг агуулсан хуулийн зохицуулалт]

(1) Туслах ажилтан нь арилжаа эрхлэгчийн зөвшөөрөлгүй худалдаа эрхлэх ёсгүй бөгөөд тухайн салбарт өөрийн болон бусдын зардлаар худалдаа хийж үл болно.

(2) Арилжаа эрхлэгч нь туслах ажилтныг ажилд авах үед худалдаа эрхэлдэг болохыг мэдэж байсан боловч үйл ажиллагаагаа зогсоохыг шаардаагүй бол худалдаа эрхлэхийг зөвшөөрсөн гэж үзнэ.

Нийтийн ашиг сонирхлыг хамгаалах

Худалдаа эрхлэгчийн чөлөөт үйл ажиллагааг боломжит хэмжээнд дэмжихийн зэрэгцээ олон нийт эрх ашгийг мөн хангах шаардлагатай. Олон нийтийг төөрөгдүүлэхгүй байх үүднээс компани хэлбэр, төрөл тодорхой байх, худалдааны бүртгэл нээлттэй байх зэргийг үүнд дурдаж болно.


Харилцагчийн хувийн шинж чанар ач холбогдолгүй байх

Худалдаа эрхлэгчийн хувьд олон тоогоор хийгдэж буй арилжааны харилцаанд харилцагч талын хувийн шинж чанар ач холбогдолгүй болж ирдэг.

2.2 ХУДАЛДААНЫ ХУУЛИЙН ТУСГАЙ АНГИ БУЮУ ХЭЛЦЛИЙН ЗАРЧМУУД

⁶ Б.Буянхишиг “ХБНГУ-ын Худалдааны хуулийн” орчуулга 2018 он

⁷ Б.Буянхишиг “ХБНГУ-ын Худалдааны хуулийн” орчуулга 2018 он



Ашгийн төлөөх зарчим.

Худалдаа эрхлэгчийн олон тоогоор, дахин давтагдан хийгдэх хэлцлийг шуурхай, найдвартай явуулахын тулд Худалдааны хуульд хэлцлийг хэлбэршүүлэх, хурдан шуурхай болгох, хэлцлийн баталгаат байдлыг хангах зохицуулалт оруулахын зэрэгцээ, худалдаа эрхлэгчийн санхүүжилтийн хурдан шуурхайн болгох талаар эрх зүйн зохицуулалтыг оруулж өгдөг. Мөн ашгийн төлөөх зарчмыг шууд хангах зориулалттай зохицуулалтыг оруулдаг байна. Тухайлбал Япон улсын Иргэний болон Худалдааны хуулийн зохицуулалтыг зэрэгцүүлэн авч үзвэл доорх ялгаа харагдаж байна.

№	ГЭРЭЭ БАЙГУУЛСНААР ҮҮСЭХ ШААРДАХ ЭРХҮҮД	ХУДАЛДААНЫ ХУУЛЬ	ИРГЭНИЙ ХУУЛЬ
1	Хөлс шаардах эрх 報酬請求権	§512.1. Худалдаачин нь өөрийн аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд бусдад өмнөөс хэлцэл хийсэн бол зохих хэмжээгээр хөлсөө шаардаж болно.	§648.1.Итгэмжлэгдсэн этгээд нь гэрээндээ тохиролцоогүй бол итгэмжлэл олгосон этгээдээс хөлсөө шаардах боломжгүй. Энэ заалт нь хэлцлээс бусад ажил даалгах гэрээ/§656.1/, эд хөрөнгө хадгалах гэрээ /§665.1/-д нэгэн адил үйлчлэхээр заагдсан.

2	Хүү шаардах эрх 消費貸借の利息請求権	§513.1.Худалдаачид хооронд мөнгө зээлүүлсэн бол зээлдүүлэгч нь хуульд заасан хүүг шаардаж болно.	§587.1. Талуудын нэг нь төрөл, чанар, хэмжээний адил зүйлийг буцаан өгөхөөр тохиролцож, нөгөө талаас мөнгө болон бусад эд зүйлийг хүлээн авснаар зээлийн гэрээний үр дагавар үүснэ. Зээлийн гэрээ нь хүүтэй болон хүүгүй байж болно.
3	Төлбөрийн хүү шаардах эрх 立替金の利息請求権	§513.2.Худалдаачин нь өөрийн бизнесийн хүрээнд бусдын өмнөөс мөнгөн төлбөр гүйцэтгэсэн бол тухайн төлбөр гүйцэтгэсэн өдрөөс хойш хуульд заасан хүүг шаардах эрхтэй.	Иргэний хуульд уг агуулгыг тусгаж өгөөгүй байна.
4	Худалдааны хэлцэл дэх хүүгийн хэмжээ 商事法定利率	§514.1.Худалдааны хэлцлийн дагуу үүссэн үүргийн хуульд заасан хүүгийн хэмжээ нь жилийн 6% байна.	§404.1. Хүү бий болох шаардах эрхийн тухай өөрөөр тохиролцоогүй бол тухайн хүүгийн хэмжээ жилийн 5% байна.

Хэлцлийг хэлбэршүүлэх, хурдан шуурхай болгох зарчим/Хялбарчлах/

Ердийн үед хэлцэл бүрийн агуулга, хэлбэрийг өөр өөрөөр буюу чөлөөтэй тодорхойлох боломжтой боловч, арилжааг олон тоогоор, хурдан шуурхай явуулахын тулд тодорхой нэг агуулга, хэлбэрийг тогтон, үүний дагуу хэлцлүүдийг хийх нь зохистой байдаг. Аж ахуй эрхлэгч нар гэрээний стандарт нөхцөл хэрэглэж буй нь үүнийг нэг жишээ юм.

Худалдааны хуульд хэлцэл хурдан шуурхай хийгдэх байдлыг хангах зорилгоор гэрээ байгуулах процессыг хөнгөвчлөх, гэрээний тусгай төрлүүд дээр эрх, үүрэг үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болох явдлыг хурдан шуурхай болгох зохицуулалтыг оруулдаг байна. Тухайлбал ХБНГУ болон Япон улсын Худалдааны хуулийн зохицуулалтыг жишээ болгон харвал дараах онцлогтой байна.

№	Агуулга	ХБНГУ-ын хууль	Худалдааны Япон улсын Худалдааны хууль
1	ХХАГ-ний харилцаанд гэрээний зүйлийг нэн даруй хянаж шалгаж авах үүрэг	§ 377 Шалгах, мэдэгдэх үүрэг (1) Худалдан авалт нь хоёр талын хувьд арилжааны хэлцэл бол худалдан авагч нь барааг худалдагч талаас нийлүүлсэн даруй хэвийн аж ахуйн үйл ажиллагааны явцад хянан шалгах, доголдол илэрвэл худалдагчид нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.	§526.1.Худалдаачин хооронд худалдах худалдан авах гэрээ байгуулсан тохиолдолд худалдан авагч нь тухайн гэрээний зүйлийг хүлээн авсан үеэс хойшлуулалгүй тухайн зүйлийг хянан шалгах ёстой. §526.2.Өмнөх заалтад тусгагдсаны дагуу худалдан авагч нь гэрээний зүйлд хянан шалгалт хийж доголдол байгааг эсвэл тоо хэмжээ дутуу байгааг илрүүлсэн бол нэн даруй худалдагчид энэ тухай мэдэгдлээ илгээгүй бол тухайн доголдол эсвэл тоо, хэмжээ дутуу шалтгаанаар гэрээнээс татгалзах эсвэл хариу төлбөрийг багасгах мөн хохирол шаардах боломжгүй. Гэрээний зүйлд нэн даруй илрүүлэх боломжгүй доголдол

				байгаа бол худалдан авагч нь 6 сарын дотор доголдлыг илрүүлбэл нэгэн адил авч үзнэ.
2	Худалдан авагч хүлээн авах хугацаа хэтрүүлсэн тохиолдолд худалдагч гэрээний зүйлийг хадгалах болон өөртөө туслах зорилгоор худалдах талаарх худалдагчийн эрх	§ 373 Худалдан авагч хүлээн авах үүргийн гүйцэтгэлийн хугацаа хэтрүүлэх (1) Худалдан авагч бараа хүлээн авах үүргийн гүйцэтгэлийн хугацааг хэтрүүлсэн бол худалдагч нь барааг худалдан авагчийн эрсдэл, зардлаар нийтийн агуулах эсвэл бусад найдвартай газар хадгалуулахаар шилжүүлж болно. (2)Түүнчлэн тэрээр урьдчилан сануулсны эцэст барааг нийтийн дуудлага худалдаанд оруулж болно; бараа нь биржийн болон зах зээлийн тогтсон ханштай бол урьдчилан сануулсны эцэст барааг гар дээрээс ийм худалдаа эрхлэх зөвшөөрөл бүхий арилжааны төлөөлөгчөөр эсвэл нийтийн дуудлага худалдаа эрхлэх эрх бүхий этгээдээр дамжуулан тухайн үеийн ханшаар худалдаж болно. Бараа нь муудах эрсдэлтэй эсвэл өөр аюул нүүрлэсэн бол урьдчилан сануулах шаардлагагүй; урьдчилан сануулаад үр дүнд хүрэхгүй бол энэ зохицуулалт нэгэн адил үйлчилнэ.	§524.1 Худалдаачин хооронд худалдах, худалдан авах гэрээ байгуулсан тохиолдолд худалдан авагч гэрээний зүйлийг хүлээн авахаас татгалзсан эсвэл хүлээн авах боломжгүй бол худалдагч нь гэрээний зүйлийг хадгалуулах эсвэл зохих хугацаа тогтоон хүлээн авахыг шаардсаны дараа дуудлага худалдаагаар гэрээний зүйлийг борлуулж болно. Энэ тохиолдолд худалдагч нь гэрээний зүйлийг хадгалуулсан эсвэл дуудлага худалдаагаар худалдах гэж байгаа бол хойшлуулалгүй худалдан авагчид энэ тухай мэдэгдлээ илгээх үүрэгтэй. §524.2. Муудах зэрэг бусад шалтгаанаар үнэ нь буурч болзошгүй байгаа зүйлийг өмнөх заалтад заасан мэдэгдлийг хийлгүйгээр дуудлага худалдаагаар худалдаж болно. §524.3.Өмнөх заалтын дагуу гэрээний зүйлийг худалдсан бол худалдагч нь үнийг хадгалуулна. Гэхдээ үнийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн хариу төлбөртөө тооцож авахад саад болохгүй	

Хэлцлийн баталгаат байдлын зарчим

Хэлцэл хурдан, шуурхай хийгдэх байдлыг хангахын тулд худалдаа эрхлэгчийн итгэлийг хамгаалах, хэлцлийн баталгаат байдлыг хамгаалах зохицуулалтыг хуульчлах шаардлага бий болдог. Тухайлбал, гэрээний саналтай хамт илгээсэн эд зүйлийг хадагалах үүрэг, гэрээний зүйлийн доголдол, тоо хэмжээ дутсаны улмаас гэрээг цуцалсан тохиолдолд гэрээний зүйлийг хадгалах үүрэг гэх мэтийг дурдаж болно.

Худалдаа эрхлэгчийн санхүүжилтийг найдвартай болгох

Худалдаа эрхлэгчийн аж ахуйн үйл ажиллагааг цааш авч явах, хөгжүүлэлтэнд санхүүжилт чухал ач холбогдолтой байдаг. Санхүүжилтийн хувьд хөрөнгө оруулалт гэх аргаа байхаас гадна, зээл нь мөн санхүүжилтийн арга болдог. Иймээс зээлийн харилцааг найдвартай болгох үүднээс хэд хэдэн этгээд хамтран үүрэг гүйцэтгэх, баталгаа гаргагч хамтран үүрэг гүйцэтгэх, баталгаат барьцаа зэрэг тогтолцоонуудыг хуульчилдаг байна.

Худалдагчийн эрхийг хамгаалах

Худалдааны хэлцлийн хурдан шуурхай байдлыг хангах хэрэгцээ, шаардлагын улмаас тогтворгүй, тодорхойгүй арилжааны харилцааг даруй шийдвэрлэх ёстой гэх мэт “худалдагчийн эрх ашиг”-ийг хамгаалахын тулд иргэний эрх зүйн ерөнхий зарчмыг засварладаг байна.

Худалдаа эрхлэгчийн итгэлийг хамгаалах

Худалдаа эрхлэгчийн итгэлийг хамгаалвал тэр хэмжээгээр хэлцэл хурдан шуурхай, найдвартай явагддаг эхэлдэг.

Хариуцлагыг хүндрүүлэх, хөнгөвчлөх

Иргэний эрх зүйн ерөнхий зарчим болох гэм буруугийн зарчим нь талууд урьдчилан харах боломжтой байсан нөхцөл байдлын улмаас үүссэн хохиролыг нөхөн төлүүлдэг боловч худалдааны эрх зүйд хэлцлийн онцлогоос хамааран нэг талын хүлээх хариуцлагыг хүндрүүлэх болон хөнгөвчлөх тохиолдол байдаг байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. АГУУЛГЫН ХАРЬЦУУЛАЛТ

	Сэдэв	Судалах агуулга
1	Худалдааны хуулийн зорилго, зорилт	Худалдааны хуулийн зорилго, зорилтыг харьцуулан судлах
2	Худалдаачин	Худалдаачиныг хэрхэн тодорхойлох, ойлголт, ангилалт, төрөл харьцуулан судлах
3	Худалдааны ажилтан	Худалдааны ажилтны тодорхойлолт, түүний хүлээх үүрэг, эдлэх эрхийг харьцуулан судлана.
4	Худалдааны харилцаанд үүсэх нийтлэг үүрэг	Худалдааны харилцаанд оролцогч талуудад үүсэх нийтлэг үүргийг харьцуулан судална.
5	Худалдааны бүртгэлтэй холбоотой асуудал	1. Бүртгэлтгүүлэх элемент (заавал болон сайн дурын) 2. Бүртгэлийн үр дагавар 3. Хуурамч бүртгэл зэргийн талаар тусгасан эсэх
6	Худалдааны нэр	1. Арилжааны нэр сонгох зарчим 2. Арилжааны нэр шилжүүлэх зэргийн талаар тусгасан эсэх
	Худалдааны үйл ажиллагааг худалдах, шилжүүлэх асуудал	Худалдааны үйл ажиллагааг худалдах, шилжүүлэх асуудал, түүнийг дагалдан үүсэх өрсөлдөхгүй байх үүргийн тухай харьцуулан судлана.
7	Худалдааны эрх зүй дэх хөөн хэлэлцэх	1. Нэр томъёоны хүрээнд хөөн хэлэлцэх хугацаа эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа хоёрын аль нь оновчтой эсэх 2. Хөөн хэлцэх хугацааны талаар тусгай зохицуулалт оновчтой болсон эсэх
8	Худалдааны харилцаанд төлөөлөх	Худалдааны эрх зүй дэх төлөөллийн хэлбэр, төрөл, тусгай зохицуулалтыг харьцуулан судлах
9	Худалдааны үйл ажиллагаа	Худалдааны үйл ажиллагааны ойлголт, түүний

		төрөл, хэлбэрийг харьцуулан судална.
10	Худалдааны хэлцлийн нийтлэг зохицуулалт - Гэрээ байгуулах - Үүргийн гүйцэтгэл - Үүрэг зөрчих - Үүрэг дуусгавар болох	Худалдааны хууль дахь гэрээний нийтлэг зохицуулалтуудыг харьцуулан судлана. Үүнд - Гэрээ байгуулах санал, түүний хариу болон хурдан шуурхай, хялбар байдлаар гэрээ байгуулах арга, хэлбэр - Худалдааны хуульд зааснаар үүсэх шаардах эрх, тухайлбал хүү шаардах эрхийн тухай асуудал, хүүгийн хэмжээний тухай асуудал, хөлс шаардах эрхийн тухай асуудал гэх мэт - Гэрээ байгуулах зардал - Хэлцлийн баталгаат байдлыг хангах асуудал, тухайлбал саатуулан барих эрх, батлан даалтын гэрээ, хамтран үүрэг гүйцэтгэх, барьцаа, үл маргах журам гэх мэт асуудал - Худалдаачин мэргэжлийн этгээдийн хувьд хүлээх анхаарал болгоомжтой байх үүрэг
11	Гэрээний тусгай төрлүүд	Сонгон авсан гадаад орны Худалдааны хуулиудуудад гэрээний тусгай төрлүүдийг харьцуулан судлана.
12	Худалдааны хуулиар зохицуулагдаж буй хуулийн этгээд	Худалдааны хуульд тусгагдсан хуулийн этгээдийн нийтлэг зохицуулалтыг харьцуулан судлана.
13	Худалдааны нягтлан бодох бүртгэл	Худалдааны хуульд тусгагдсан нягтлан бодох бүртгэлийн суурь зарчмуудыг харьцуулан судлана.
14	Иргэн болон худалдааны хуулийн харилцан хамаарал	Иргэн болон худалдааны хуулийн харилцан хамаарал, эрх зүйн хэм хэмжээний эрэмбийн асуудлыг харьцуулан судлана.
15	Бусад асуудал	Өрсөлдөөн, худалдааны маргаан шийдвэрлэх гэх мэт бусад асуудлыг харьцуулан судлана.

3.1 ХУДАЛДААНЫ ХУУЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Энэхүү судалгааны 1 дэх хэсэгт авч үзсэнчлэн зарим орны Худалдааны хуулиас зарим агуулга нь бие даасан хууль болон батлагдан гарч, Худалдааны хуулиар зохицуулагдах харилцааны агуулга багасаж байгаа талаар дурдсан билээ.

Тиймээс худалдааны хуулийн зорилго, зорилт, зохицуулалх зүйлийн хүрээнд эхлээд авч үзэх ёстой асуудал нь бусад орны Худалдааны хуульд томоохон байр суурийг эзэлдэг “Далайн худалдааны” эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлага бий эсэх бөгөөд манай оронд энэ талын харилцаа төдийлөн хөгжөөгүй тул энэ агуулга хасагдана. Мөн түүнчлэн бусад Худалдааны хуульд бас нийлээдгүй том байр суурийг эзэлдэг нөхөрлөл болон компанийн эрх зүйн зохицуулалт манай орны хувьд бие даасан хуулиудаар хөгжиж ирсэн тул мөн хасагдах юм. Бусад орны жишиг ч мөн компани болон нөхөрлөлийн зохицуулалтыг Худалдааны хуулиас гаргаган бие даан хөгжүүлэх чиг хандалга

ажиглагдаж байна. Түүнчлэн худалдааны данс тооцоо, нягтлан бодох бүртгэлийн асуудал нь манай орны хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиар зохицуулагдаж, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг хэрэгжүүлж буй тул Худалдааны хуулиар төдийлөн нарийвчлан зохицуулах шаардлагагүй болов уу.

Ингээд аваад үзэхээр Худалдааны эрх зүйн ерөнхий ангийн зохицуулалт, худалдааны хэлцлийн нийтлэг үндэслэл, худалдааны хэлцлийн тусгай төрөл гэсэн 3-н төрлийн агуулгыг зохицуулсан хэм хэмжээг Худалдааны хууль батлах тохиолдолд бий болгох шаардлага үүсэх ба энэ хүрээнд худалданы хуулийн зорилго, зорилт тодорхойлогдоно.

№	Улс	Худалдааны хуулийн зохицуулалтын агуулга
1	ХБНГУ	зохицуулалт байхгүй
2	Япон	1.1 Худалдаачны аж ахуйн үйл ажиллагаа, худалдааны хэлцэл болон бусад худалдааны асуудлын тухайд өөр хуулиар тусгайлан зохицуулснаас бусад тохиолдолд энэ хуулийг хэрэглэнэ.
4	Вьетнам	1.1 Вьетнамын социалист бүгд найрамдах улсын нутаг дэвсгэр дотор явуулж буй худалдааны үйл ажиллагааг энэ хуулиар зохицуулна. 1.2 Вьетнамын социалист бүгд найрамдах улсын нутаг дэвсгэр дотор худалдаа эрхлэгчийг нэг талаа болгосон ашгийн төлөө бус үйл ажиллагааны хувьд ашгийн төлөө бус үйл ажиллагаа явуулж буй этгээд нь энэ хуулийг хэрэглэхийг сонгосон тохиолдолд энэ хуулийг хэрэглэнэ.

Япон улсын Худалдааны хуулийн зохицуулалтын хүрээ нь аж ахуйн үйл ажиллагаанд холбогдох зохицуулалт, худалдааны хэлцэлтэй холбоотой зохицуулалтын хүрээнд хуулийн зорилго зорилт тодорхойлогдож байна.

Зөвлөмж:


- Монгол Улсын хувьд худалдааны үйл ажиллагаатай холбоотой институтуудыг бий болгох, худалдааны хэлцлийн нийтлэг үндэслэл, худалдааны хэлцлийн тусгай төрлийн талаарх зохицуулалтын хүрээнд худалдааны хуулийн зорилго, зорилтыг тодорхойлох нь зүйтэй байна.
- Худалдааны хуулийг бүтээхдээ Иргэний хууль, Өрсөлдөөний хууль, Хөдөлмөрийн хууль, Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хууль болон бусад аж ахуйн харилцааг зохицуулж байдаг хууль тогтоомжтой хэрхэн уялдуулах тал дээр анхаарал хандуулах шаардлагатай.

3.2 ХУДАЛДААНЫ ЭРХ ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭГ ХЭРЭГЛЭХ ЭРЭМБЭ


Хувийн эрх зүйн харилцаанд оролцогчдын хооронд үүссэн маргааныг аль хуулийг хэрэглэж шийдвэрлэх ёстой вэ гэдэг нь сонирхол татсан асуудал болно.

Япон улсад худалдааны эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх эрэмбийг тогтоохдоо дараах байдлаар тогтоодог байна.

Юун түрүүнд бичмэл худалдааны эрх зүйн эх сурвалжийг хэрэглэнэ. Ингэхдээ дараах дарааллаар хэрэглэдэг байна.



Дараа нь бичмэл бус заншлын хэм хэмжээг хэрэглэнэ. Худалдааны заншлын эрх зүйн хэм хэмжээ Иргэний хуульд тухайн харилцааг зохицуулсан заалт байгаа эсэхээс үл хамааран тэргүүн ээлжинд хэрэглэгдэнэ. Худалдааны заншлын эрх зүйн хэм хэмжээнд хүрэхгүй ч худалдааны заншил мөн Иргэний хуулиас тэргүүн ээлжинд хэрэглэгдэнэ.



Эцэст нь тухайн маргаан бүхий харилцааны талаар худалдааны заншлын эрх зүйн хэм хэмжээ болон худалдааны заншил тогтоогдохгүй бол Иргэний хуулийг хэрэглэнэ.

№	Улс	Худалдааны хуулийн зохицуулалтын агуулга
1	ХБНГУ	Зохицуулалт байхгүй
2	Япон	1.1 Худалдаачны аж ахуйн үйл ажиллагаа, худалдааны хэлцэл болон бусад худалдааны асуудлын тухайд өөр хуулиар тусгайлан зохицуулснаас бусад тохиолдолд энэ хуулийг хэрэглэнэ./§§1.1/ 1.2 Худалдааны харилцаанд энэ хуулиар зохицуулаагүй харилцааг худалдааны заншлын дагуу шийдвэрлэнэ, худалдааны заншил байхгүй бол Иргэний хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.
4	Вьетнам	4.1 Худалдааны үйл ажиллагааг энэ хууль болон бусад холбогдох хуулиар зохицуулна. 4.2 Бусад хуулиар тодорхой худалдааны үйл ажиллагааг тусгайлан зохицуулсан бол тухайн хуулийг зохицуулалтыг хэрэглэнэ. 4.3 Худалдааны үйл ажиллагааны талаар энэ хууль болон бусад хуульд зохицуулалт байхгүй тохиолдолд Иргэний хуулийн зохицуулалтыг хэрэглэнэ. 3.3 “Худалдааны үйл ажиллагаан дахь заншил” гэдэг нь тадуудын хооронд бий болсон урт хугацааны туршид хэрэглэгдсэн тодорхой агуулга бүхий тогтсон хэм хэмжээ бөгөөд тухайн худалдааны үйл ажиллагаан дахь талуудын эрх, үүргийг тогтоосон гэж хүлээн зөвшөөрөгдөхүйц зүйлийг хэлнэ. 3.4 “Худалдааны заншил” гэж тодорхой нутаг дэвсгэр, орон нутаг эсвэл худалдааны салбар дахь худалдааны үйл ажиллагаанд өргөн тархсан тодорхой агуулга бүхий заншил бөгөөд тухайн худалдааны үйл ажиллагаан дахь талуудын эрх, үүргийг тогтоосон гэж хүлээн зөвшөөрөгдөхүйц зүйлийг хэлнэ.

Зөвлөмж:

- Монгол Улсын Иргэний хуулийн 2-р зүйлийн 2.1 дэх хэсэгт заасан “Иргэний хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ”, 3-р зүйлийн 3.3 дахь хэсэгт “Монгол Улсын Үндсэн хууль, энэ хуулиас бусад хууль хоорондоо зөрчилдвөл тухайн асуудлыг илүү нарийвчлан зохицуулсан хуулийн, тийм хууль байхгүй бол сүүлд хүчин төгөлдөр болсон хуулийн заалтыг хэрэглэнэ” гэх заалтуудын агуулгыг шинэчлэн найруулах. Учир нь Худалдааны хууль батлагдах тохиолдолд Монгол Улсын Үндсэн хуульд нийцэх ёстой нь гарцаагүй боловч Иргэний хуульд нийцэх шаардлагатай эсэх нь гол асуудал юм. Иргэний хууль нь хувийн эрх зүйн харилцааны ерөнхий хууль бол, Худалдааны хууль нь хувийн эрх зүйн харилцаанаас арилжааны эрх зүйн харилцааг зааглан, тусгайлан зохицуулж буй тусгай хууль гэж дээрх орнуудад үзэж буй тул энэ системчлэлийг нь дагах нь зөв болов уу. Өөрөөр хэлбэл Иргэний хууль болон Худалдааны хууль хоорондоо зөрчилдвөл аж ахуйн шинжтэй харилцаанд Худалдааны хуулийг тэргүүн ээлжинд хэрэглэх эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.
- Вьетнам улсын Худалдааны хуулийг аваад үзвэл “Худалдааны үйл ажиллагаан дахь заншил”, “Худалдааны заншил” гэсэн 2 ойлголтыг хэрэглэж байх бөгөөд тодорхой хэмжээнд ялгаатай байна. Манай улсын Иргэний хуулийн 198-р зүйлийн 198.6 дахь хэсэгт “талуудын хооронд тогтсон практик”, “ажил хэргийн хүрээнд тогтсон заншил” гэсэн ойлголтыг хэрэглэсэн байдаг. Энэ нь зөвхөн тодорхой нутаг дэвсгэрт тогтсон заншлаас гадна зөвхөн талуудын хооронд тогтсон практик, заншил мөн чухал ач холбогдолтойг илтгэж буй тул худалдааны хууль бүтээхдээ анхаарах ёстой асуудал юм.

3.3 ХУДАЛДАА ЭРХЛЭГЧ ГЭХ ОЙЛГОЛТЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Аливаа хууль тогтоомжийг бүтээхдээ хэнд чиглэсэн мөн ямар төрлийн харилцааг зохицуулах эрх зүйн хэм хэмжээг бий болгохоо шийдэх шаардлагатай болдог. Ингэхдээ хууль тогтоомжийн бүтэц нь эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх субьектэд тулгуурласан бүтэцтэй байх уу эсвэл эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх харилцаа болох үйлдэл, эс үйлдэхүйд илүү тулгуурласан бүтэцтэй байх уу аль эсвэл субьект болон харилцаа аль аль нь холимог байдлаар(eclecticism) хууль тогтоомжийн бүтцийг бий болгох гэсэн 3 үндсэн хандлага байна.

ХБНГУ-ын хувьд худалдаа эрхлэгчийг тодорхойлох байдлаар Худалдааны хуулийн хэрэглэх хүрээг тодорхойлсон байна.

Япон улсын хувьд Худалдааны төрөлжсөн хуулийн бүтэц нь 3 дахь хандлагын дагуу субьект болон үйлдэл, эс үйлдэхүйн аль алинд тулгуурлажээ.

№	Улс	Худалдааны хуулийн зохицуулалтын агуулга	
1	ХБНГУ	Заавал худалдаа эрхлэгч байх ёстой	1.3 Энэ хуулинд заасан худалдаа эрхлэгч гэдэгт худалдааны үйл ажиллагаа эрхэлж буй

		этгээд(Ist kaufmann)	этгээдийг ойлгоно. 1.4 Худалдааны үйл ажиллагаа гэдэгт аж ахуйн үйл ажиллагааны төрөл, цар хүрээ нь худалдаа эрхлэгчийн байдлаар зохион байгуулагдан аж ахуйн үйл ажиллагаа явуулах шаардлагагүй гэж үзэхээс бусад аж ахуйн үйл ажиллагаанд хамаарах бүхий л тохиолдлыг ойлгоно.
		Худалдаа эрхлэгч байж болох этгээд(Kannkaufmann)	2.1 Тухайн аж ахуйн үйл ажиллагаа нь энэ хуулийн §1-ийн 2-т заасан аж ахуйн үйл ажиллагаанд хамаарахгүй боловч аж ахуй эрхлэгч нь өөрийн худалдааны нэрээ худалдааны бүртгэлд бүртгүүлсэн тохиолдолд тухайн аж ахуйн үйл ажиллагааг энэ хуульд заасан худалдааны үйл ажиллагаа гэж үзнэ. Энэхүү аж ахуй эрхлэгч нь худалдаа эрхлэгчийн худалдааны нэрийн бүртгэлд хэрэглэх заалтын дагуу бүртгүүлж болох боловч бүртгүүлэх үүрэг хүлээхгүй.. Ийнхүү бүртгүүлсэний дараа энэ хуулийн §1.2-т заасан нөхцөл бүрдсэнээс бусад тохиолдолд тухайн аж ахуй эрхлэгчийн хүсэлтээр түүний худалдааны нэрийг бүртгэлээс хасч болно. 1.3 Хөдөө аж ахуй болон ойн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд энэ хуулийн §1 үйлчлэхгүй. 1.4 Хөдөө аж ахуй болон ойн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд түүний төрөл, цар хүрээ нь худалдаа эрхлэгчийн байдлаар зохион байгуулагдан аж ахуйн үйл ажиллагаа явуулах шаардлагатай тохиолдолд энэ хуулийн §2-ыг хэрэглэнэ. Энэ тохиолдолд худалдааны бүртгэлд худалдааны нэрээ бүртгүүлсний дараа худалдааны нэрийг бүртгэлээс хасахад үйлчлэх ерөнхий зохицуулалтыг баримтална. 1.5 Хөдөө аж ахуй болон ойн аж ахуйн үйл ажиллагаатай эдгээр чиглэлийн дагавар үйл ажиллагааг холбосон бол уг дагавар үйл ажиллагаанд энэ зүйлийн 1 ба 2 дахь мөрийн зохицуулалт үйлчилнэ.
		Хэлбэрийн улмаас худалдаа эрхлэгч болох этгээд(Formkaufmann)	6.1 Худалдаа эрхлэгчид хамаарах зохицуулалт нь худалдааны байгууллагуудад/ Handelsgesellschaften/ нэгэн адил үйлчилнэ. 6.2 Аж ахуйн нэгжийн зорилгоос үл хамааран энэ хуулиар худалдаа эрхлэгч болсон байгууллага нь §1.2-т заасан нөхцөл хангагдаагүй байсан ч эрх, үүрэгт нөлөөлөхгүй.

2	Япон	Жинхэнэ худалдаачин (固有の商人)	4.1 Энэ хуулийн хүрээнд худалдаачин гэдэг нь өөрийн нэрээр худалдааны хэлцлийг үйл ажиллагаагаа болгож буй этгээдийг хэлнэ.
		Худалдаачин гэж үзэгдэх этгээдийг (擬制商人)	4.2 Дэлгүүр түүнтэй адилтгах байгууламжаар бараа бүтээгдэхүүн борлуулах үйл ажиллагаа явуулдаг этгээд болон уул уурхай үйл ажиллагаа эрхэлдэг этгээд нь худалдааны хэлцлийг бизнесээ болгодоггүй этгээд байсан ч түүнийг худалдаачин гэж үзнэ.
		Хэлбэрийн улмаас худалдаачин болох (形態商人)	Компанийн тухай хуулийн 5-р зүйл.
		Жижиг худалдаа эрхлэгч(小商人)	7.1 Хууль зүйн яамнаас тогтоосон журмын дагуу үйл ажиллагааны эргэлтийн хөрөнгийн хэмжээ 500,000 иенээс хэтрэхгүй бол түүнийг жижиг худалдаа эрхлэгч гэнэ.
		Насанд хүрээгүй худалдаа эрхлэгч (未成年者登記)	5.1 Насанд хүрээгүй этгээд нь өмнөх зүйл заасан аж ахуйн үйл ажиллагаа явуулах бол бүртгүүлэх шаардалгатай.
		Эрх зүйн чадамжгүй худалдаа эрхлэгч (後見人登記)	6.1 Асран хамгаалагч нь асран хамгаалуулагчийн өмнөөс 4-р зүйлд заасан аж ахуйн үйл ажиллагаа явуулах бол бүртгүүлэх шаардалгатай. 6.2 Асран хамгаалагчийн төлөөлөх эрхэд тавьсан хязгаарлалт нь үүнийг мэдээгүй гуравдагч этгээдийн эрсэг ашиглагдахгүй.
3	Вьетнам	Худалдаачин бус этгээдэд худалдааны хууль хэрэглэгдэх тохиолдол	Худалдааны хуулийн 501-р зүйлд заасан объектив худалдааны хэлцэлийг худалдаа эрхэлдэггүй этгээд хийсэн ч худалдааны хууль хэрэглэгддэг.
		6.1 Худалдаа эрхлэгч нь хууль ёсны дагуу байгуулагдсан хуулийн этгээд болон бие даан, байнгын худалдааны үйл ажиллагаа явуулж буй хувь хүн бөгөөд худалдааны бүртгэл хийлгэсэн этгээдийг хэлнэ. 3.1 Худалдааны үйл ажиллагаа гэж ашгийн төлөө үйл ажиллагааг хэлэх ба бараа бүтээгдэхүүн борлуулах, үйлчилгээ үзүүлэх, хөрөнгө оруулалт, худалдааны үйл ажиллагааг сурталчлах болон бусад ашгийн төлөө үйл ажиллагааг хэлнэ.	

Ашгийн төлөө хуулийн этгээд худалдаа эрхлэгч болох тухай

Компани гэх мэт ашгийн төлөө хуулийн этгээд нь ашгийн төлөө зорилгоор байгуулагдаж буй гэсэн эрх зүйн байдлаасаа улбаалаад автоматаар худалдаа эрхлэгч болдог зохицуулалт нийтлэг байдлаар ажиглагдаж байна.

Чөлөөт мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэгчийг худалдаа эрхлэгч гэж үздэггүй тухай

Аж ахуйн үйл ажиллагаа гэдэгт чөлөөт мэргэжлийн үйл ажиллагаа хамаардаггүй. Тухайлбал өмгөөлөгч, эмч, архитектерын үйл ажиллагааг хамааруулдаггүй нь нийтлэг

байна.


Хувь хүн болон бусад этгээд худалдаа эрхлэгч болох тухай асуудал

ХБНГУ-ын хувьд худалдаа эрхлэгчийг тодорхойлж буй суурь ойлголт нь худалдааны үйл ажиллагаа(Handelsgewerbe) гэх ойлголт байх бөгөөд Худалдааны хуулийн 1-р зүйлийн 1.2 дахь хэсэгт уг ойлголтын агуулгыг тодорхойлж өгсөн байна.

ХБНГУ-ын Худалдааны хуулийн онцлог нь уг хуулийн 2-р зүйлд заасны дагуу ашгийн төлөө аж ахуйн үйл ажиллагаа явуулж буй этгээдүүд худалдаа эрхлэгчээр бүртгүүлэх боломжийг ямар нэгэн хязгаарлалт тавилгүйгээр нээж өгсөн байна.

Нөгөө талаас ХБНГУ-ын Худалдааны хуулийн 5-р зүйлд “Худалдааны нэрээ худалдааны бүртгэлд бүртгүүлсэн тохиолдолд тухайн бүртгэлийг ашиглан эрхээ хэрэгжүүлэх гэж буй этгээдийн эсрэг тухайн худалдааны нэрийн хүрээнд явуулсан аж ахуйн үйл ажиллагааг худалдааны үйл ажиллагаа биш гэж эсэргүүцэл гаргах боломжгүй” гэж хуульчилж өгсөн нь худалдааны хэлцлийг үндсэн болон дагалдах гэж ялгах шаардлагагүй болгож худалдааны нэрээр хийгдэж бүхий л хэлцэлд Худалдааны хууль ямар нэг маргаангүйгээр хэрэглэгдэх боломжийг олгожээ.

Япон Улсын Худалдааны хуулийг хэрэглэхэд худалдааны хэлцэл, худалдаачин гэх ойлголтуудын хоорондын харилцан хамаарлыг доорх хүснэгтэд харууллаа.



Дээрх хүснэгтийг тайлбарлавал Япон Улсын Худалдааны хуулийн §501 /Объектив худалдааны хэлцэл (絶対的商行為)/ болон §502 /Аж ахуйн шинжтэй худалдааны хэлцэл (營業的商行為) /-р зүйлд заасан хэлцлүүд нь худалдааны үндсэн хэлцэл (基本的商行為) гэж нэрлэгддэг бөгөөд эдгээр хэлцлийг үндсэн үйл ажиллагаагаа болгож аж ахуй эрхэлдэг этгээд нь *жинхэнэ худалдаачин* (固有の商人) болно. Энэ талаар Худалдааны хуулийн 4-р зүйлийн 4.1 дэх хэсэгт “Энэ хуулийн хүрээнд худалдаачин гэдэг нь өөрийн нэрээр худалдааны хэлцлийг үйл ажиллагаагаа болгож буй этгээдийг хэлнэ” гэж хуульчилж өгсөн. Өөрөө хэлбэл энэхүү заалт нь худалдааны хэлцлийн эрх зүйн онолд суурилсан буюу үндсэн худалдааны хэлцлийг бизнесээ болгож буй этгээд нь худалдаачин байна гэсэн тайлбарт хүргэдэг. Жинхэнэ худалдаачны үйл ажиллагаа нь аж үйлдвэрийн хоёрдогч, гуравдагч хэв шинж⁸-тэй байдаг.

Мөн объектив худалдааны хэлцэл нь тухайн хэлцлийн объектив шинжээсээ шалтгаалан худалдааны хэлцэл болдог. Өөрөөр хэлбэл уг хэлцэл нь ашгийн төлөөх шинж өндөртэй учраас тухайн хэлцлийг хийж буй этгээд нь худалдаачин мөн эсэх, бизнесийн хувьд хийгдэж буй эсэхээс үл хамааран шууд худалдааны хэлцэл болох тул уг хэлцэлд Худалдааны хуулийг шууд хэрэглэдэг.

Үүний дараагаар Худалдааны хуулийн 4-р зүйлийн 4.2 дахь хэсэгт “Дэлгүүр түүнтэй адилтгах байгууламжаар бараа бүтээгдэхүүн борлуулах үйл ажиллагаа явуулдаг этгээд болон уул уурхай үйл ажиллагаа эрхэлдэг этгээд нь худалдааны хэлцлийг бизнесээ болгодоггүй этгээд байсан ч түүнийг худалдаачин гэж үзнэ” гэж хуульчилж *худалдаачин гэж үзэгдэх этгээдийг* (擬制商人) тодорхойлж өгсөн. Энд худалдаачин гэж үзэгдэх этгээд нь худалдааны хэлцлийг бизнесээ болгодоггүй буюу худалдааны бус хэлцлийг бизнесээ болгодог болохыг анхаарах хэрэгтэй. Худалдаачин гэж үзэгдэх этгээдийн бизнес нь аж үйлдвэрийн анхдагч хэв шинжтэй байдаг. Гэвч худалдаачин гэж үзэгдэх этгээдийн бизнесээ болгож буй хэлцлийг дор дурдах хуучин худалдааны хуулийн 523-р зүйлтэй адил байдлаар худалдааны үндсэн хэлцэл нэгэн адил үзэж Худалдааны хуулийг хэрэглэх ёстой гэсэн нийтлэг үзэл байдаг.

Худалдааны төрөлжсөн хуулийн 4-р зүйлийн 4.1/*жинхэнэ худалдаачин*/, 4.2/*худалдаачин гэж үзэгдэх этгээд*/-т заасан худалдаачны бизнесийнхээ төлөө хийж байгаа хэлцэл нь 503-р зүйлийн 503.1 дэх хэсэгт “Худалдаачин нь өөрийн аж ахуйн үйл ажиллагааныхаа төлөө хийж буй хэлцэл нь худалдааны хэлцэл болно” гэж заасны дагуу худалдааны хэлцэл болдог. Энэ нь дагалдах худалдааны хэлцэл(付随的商行為) гэж нэрлэгддэг. Уг тохиолдолд худалдаачин хийж байгаа учраас л худалдааны хэлцэл болж байгаа тул худалдаачны эрх зүйн онолд суурилсан зохицуулалт болохыг харж болно. Иймд “худалдаачин гэж үзэгдэх этгээд”-ийн бизнесээ болгож буй хэлцэлд худалдааны хууль хэрэглэгдэхгүй ч түүний бизнесийнхээ төлөө хийж буй хэлцэлд худалдааны хууль хэрэглэгдэхээр хуульчилснаас гадна худалдаачин гэж үзэгдэх этгээд нь худалдааны төрөлжсөн хууль дахь худалдаачин гэх ойлголтын нэг төрөл тул тус хуулийн ерөнхий ангийн зохицуулалтууд жинхэнэ худалдаачны нэгэн адил үйлчлэхээр зохицуулагдсан.

⁸ Аж үйлдвэрийн хэв шинж

Анхдагч (үйлдвэрийн түүхий эд, материаллыг бэлтгэн нийлүүлэх)

Хоёрдогч (түүхий эд, материалаар бүтээгдэхүүн үйлдвэрлэх)

Гуравдагч (хэрэглэгчдэд бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэх)

Дөрөвдөгч (хэрэглэгчийн шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг судлах, шинээр нэвтрүүлэх)

Мөн 2005 онд батлагдсан Компанийн тухай хуулийн 5-р зүйлд компани нь аж ахуйн нэгжийн сонгодог хэлбэр тул хэлбэрийн улмаас худалдаачин (形態商人) гэж нэрлэгдэн, түүний хийж буй бүхий л хэлцэл нь худалдааны хэлцэл байхаар Компанийн хуульд тусгагдсан. 2005 оноос өмнө Худалдааны хуулиар Компанийн харилцааг зохицуулж байсан ба худалдааны бус хэлцлийг бизнесээ болгодог компани нь *худалдаачин гэж үзэгдэх этгээд* байсан ч тухайн үеийн худалдааны хуулийн 523-р зүйлд уг төрлийн Компанийн бизнес болгож буй хэлцлийг үндсэн худалдааны хэлцэл гэж үзэн Худалдааны хууль нэгэн адил үйлчлэх(mutatis mutandis) зохицуулалт байсан тул Компани хууль батлагдахаас өмнө ч Компанийн хийх бүхий л хэлцэлд худалдааны хуулийн зохицуулалт хэрэглэгддэг байжээ.

Насанд хүрээгүй этгээд худалдаа эрхлэгч болох тухай

Хувь хүний хувьд худалдаа эрхлэгч мөн эсэх нь Япон Улсын Худалдааны хуулийн 4-р зүйлд заасан худалдаа эрхлэгч болох урьдчилсан нөхцөлийг хангах эсэх нь гол асуудал байдаг боловч, мөн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх чадамжийн асуудал яригддаг.

Аж ахуйн үйл ажиллагаа явуулах чадамжийн асуудал нь Иргэний хуулийн нийтлэг хэм хэмжээгээр зохицуулагдана. Иргэний хуулийн 6-р зүйлийн 1 дэх хэсэгт “Нэг болон олон төрлийн аж ахуйн үйл ажиллагаа явуулахыг хууль ёсны төлөөлөгч нь зөвшөөрсөн бол насанд хүрээгүй этгээд нь тухай аж ахуйн үйл ажиллагааныхаа хүрээнд эрх зүйн чадамжтай гэж үзэгдэнэ” хэмээн заажээ.

Худалдааны хуулийн 5-р зүйлд зааснаар насанд хүрээгүй худалдаа эрхлэгч заавал бүртгүүлэх шаардлагатай байна. Насанд хүрээгүй этгээдийн эцэг, эх, асран хамгаалагч нь тодорхой худалдааны үйл ажиллагааг хязгаарлаж болох ч хэлцлийн үнийн дүн, хэлцлийн төрлийг хязгаарлах боломжгүй, хязгаарлахыг хориглосон байдаг байна.

Худалдаа эрхлэгчийн асран хамгаалагчийн тухай

Хувь этгээдийн эрх зүйн чадварыг хязгаарлахыг хоргилдог тул хэдийгээр эрх зүйн чадамжгүй ч гэсэн худалдааны үйл ажиллагаанаас эрх олж авч, үүрэг хүлээх боломжтой юм. Энэ тохиолдолд эрх зүйн чадамжгүй этгээдийн өмнөөс түүний асран хамгаалагч аж ахуйн үйл ажиллагааг удирдан явуулна.

Жижиг худалдаа эрхлэгчийн тусгай зохицуулалтын тухай

Худалдаа эрхлэгч мөн боловч аж ахуйн үйл ажиллагаанд зарцуулж буй хөрөнгө нь жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар 500 мянган иенээс хэтрэхгүй бол жижиг худалдаа эрхлэгч гэж үздэг байна. Жижиг худалдаа эрхлэгч нь насанд хүрээгүй худалдаа эрхлэгчийн бүртгэл, худалдаа эрхлэгчийн асран хамгаалагчийн бүртгэл, худалдааны бүртгэл, худалдааны нэрийн бүртгэл, худалдааны нэрийг шилжүүлэх бүртгэл, худалдааны нэрийг шилжүүлэн авсан этгээд нь шилжүүлэн өгсөн этгээдийн үүргийг хариуцахгүй талаарх бүртгэл, нягтлан бодох бүртгэл, эрх баригч (прокурис)-ийн бүртгэлтэй холбоотой зохицуулалт хэрэглэгдэхгүй байхаар хуульчилж өгжээ.

Гэхдээ худалдааны нэртэй холбоотой гуравдагч этгээдийг хамгаалах зохицуулалт болон бусдын худалдааны нэрийг хамгаалах зохицуулалтууд жижиг худалдаа эрхлэгчид хэрэглэгдэнэ. Мөн жижиг худалдаа эрхлэгч нь хэдийгээр эрх баригчийг бүртгүүлэх боломжгүй ч худалдааны үйл ажиллагаандаа эрх баригчийг томилон ажиллуулах боломжтой.

Дүгнэлт

Монгол Улсын Өрсөлдөөны тухай хуулийн 4-р зүйлийн 4.1.3 дахь хэсэгт “**аж ахуй эрхлэгч**” гэж Монгол Улсад бүртгэлтэй, **аж ахуй эрхэлж байгаа** ашгийн төлөө болон ашгийн төлөө бус хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага, хувь хүнийг хэлнэ гэж тодорхойлжээ. Энэ тодорхойлолт нь ХБНГУ-ын Худалдааны хуулийн 1-р зүйлийн 1 дэх хэсэгт “Энэ хуулинд заасан худалдаа эрхлэгч гэдэгт худалдааны үйл ажиллагаа эрхэлж буй этгээдийг ойлгоно” гэж зааснаас төдийлөн ялгаатай байдал ажиглагдахгүй байна.

Монгол Улсын хувьд бизнесийн харилцаанд дараах этгээдүүд оролцох боломжтой.

№	Субъект	Худалдаа эрхлэгч болох эсэх
1	Хувиараа бизнес эрхлэгч	Худалдааны үйл ажиллагаа явуулж эхэлснээр худалдаа эрхлэгч болох тохиолдол. Энэ тохиолдолд худалдааны бүртгэлд бүртгүүлэх шаардалгагүй. Худалдааны бүртгэлд худалдаа эрхлэгчээр бүртгүүлснээр худалдаа эрхлэгч болох тохиолдол
2	Компани	Ашгийн төлөө хуулийн этгээдийн хувьд үүсгэн байгуулагдснаар худалдаа эрхлэгч болно.
3	Нөхөрлөл	Ашгийн төлөө хуулийн этгээдийн хувьд үүсгэн байгуулагдснаар худалдаа эрхлэгч болно.
4	Хоршоо	Манай улсад хоршоог Иргэний хуулиар ашгийн төлөө бус хуулийн этгээдийн ангилалд хамруулдагч бусад улс оронд ашгийн болон ашгийн төлөө бус хуулийн этгээдийн аль алинд хамаарахгүй дундын хуулийн этгээд гэж үздэг байна. Хоршоог худалдаа эрхлэгч гэж үзэх, түүний хийж буй хэлцлийг худалдааны хэлцэл гэж үзэх эсэх нь хуулийн тайлбар, тухайн орны онцлогоос хамааралтай байна. Манай орны хувьд худалдаа эрхлэгч гэж үзэхгүй байх шалтгаан төдийлөн ажиглагдахгүй байх тул хоршоог худалдаа эрхлэгч гэж үзэх нь хууль хэрэглээг хялбарчлах, эрх зүйн харилцааг тодорхой болгох давуу талтай гэж үзэж байна.
5	Холбоо /төрийн бус байгууллага/	Төрийн бус байгууллага нь нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгын зэрэгцээ худалдааны үйл ажиллагаа явуулах боломжтой.
6	Төрийн байгууллага, албан газар	Төр нийтийн ашиг сонирхлыг хангахын тулд аливаа арга хэмжээ хэрэгжүүлж болох бөгөөд үүний нэг нь аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх байж болох тул худалдаа эрхлэгч болно.
7	Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар	Төр нийтийн ашиг сонирхлыг хангахын тулд аливаа арга хэмжээ хэрэгжүүлж болох бөгөөд үүний нэг нь аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх байж болох тул худалдаа эрхлэгч болно.
8	Улсын төсөвт үйлдвэрийн газар	Төр нийтийн ашиг сонирхлыг хангахын тулд аливаа арга хэмжээ хэрэгжүүлж болох бөгөөд үүний нэг нь аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх байж болох тул худалдаа эрхлэгч

		болно.
9	Шашны байгууллага	Шашны байгууллага нь гишүүддээ ноогдол ашиг тараахгүй л бол худалдааны үйл ажиллагаа явуулах боломжтой.
10	Нийтийн эрх зүйн хуулийн этгээд	Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх байж болох тул худалдаа эрхлэгч болно.
11	Сан	Сан нь ноогдол ашиг тараахгүй тул нийтийн сайн сайхны төлөөх үйл ажиллагаагаа дэмжих зорилгоор аж ахуйн үйл ажиллагаа явуулж болно.

Зөвлөмж:

- Монгол Улс бизнэс эрхлэгчийн үйл ажиллагааны онцлогт тохирсон, тусгайлан зохицуулах хэм хэмжээг нэгтгэн кодефикачлахдаа “Худалдааны хууль” гэсэн уламжлалт нэрийг авч хэрэглэх нь зүйтэй.
- Хуулийн хэрэглэх хүрээг тодорхойлохдоо субъектив онолд тулгуурлах. Учир нь энэхүү онолд тулгуурлах нь хуулийг хэрэглэхэд амар болгоно. Аливаа хийдэл гарахаас сэргийлнэ.
- Худалдааны хуулийн субъектийн ерөнхий нэр нь “худалдаачин” байх уу “аж ахуй эрхлэгч” байх уу гэх сонголт байх бөгөөд одоо хэрэгжиж буй Иргэний хуульд аж ахуй эрхлэгч гэж хэрэглэж байх тул “аж ахуй эрхлэгч” гэх нэр томъёог хэрэглэх нь зүйтэй байна. Нөгөө талаас худалдаачин гэх нэр томъёо нь орчин үеийн аж ахуй харилцаанд хэрэглэхэд хэт явцуу ойлголт гэж үзэгдэх болжээ.
- Аж ахуйн үйл ажиллагаа гэдэгт юуг ойлгох талаар тодорхойлолт өгөх
- Аж ахуй эрхлэгчийг заавал аж ахуй эрхлэгч болох, аж ахуй эрхлэгч гэж үзэх, сайн дураар аж ахуй эрхлэгч болох гэж ангилах
- Насанд хүрээгүй этгээд нь худалдааны үйл ажиллагаа явуулах тохиолдолд заавал бүртгүүлэх тогтолцоог бий болгох.
- Эрх зүйн чадамжгүй худалдаа эрхлэгчийн асран хамгаалагчийг бүртгэх тогтолцоог бий болгох
- Жижиг худалдаа эрхлэгчийн хувьд бүртгүүлэх шаардлагагүй байхаар хуульчлах

3.4 ХУДАЛДААНЫ БҮРТГЭЛ

Худалдааны харилцааг хөнгөвчилдөг гол зүй бол худалдааны бүртгэл юм. Худалдааны бүртгэл нь худалдааны харилцаан дахь эрх зүйн үйчлэл бүхий тодорхой үйл баримтын ил тод жагсаалт юм. Энэхүү албан мэдээлэл нь тухайн худалдаа эрхлэгчдэд хамаарах тодорхой үйл баримт найдвартай болохыг гэрээний нөгөө талд батлан харуулах зорилготой⁹.

№	Улс	Худалдааны хуулийн зохицуулалтын агуулга
1	ХБНГУ	8.1 Худалдааны бүртгэлийг шүүхээс цахим хэлбэрээр хөтөлнө. 9.1 Аливаа этгээд худалдааны бүртгэлийн агуулга, үүнд бүртгүүлэхээр

⁹ Ханс Кристоф Григолайт “Арилжааны эрх зүйн үндсэн зарчим” Хууль дээдлэх ёс сэтгүүл, 2018 он, №3, 87 дахь тал

		өгсөн бичиг баримтыг зөвхөн мэдээлэл авах зорилгоор үзэхийг зөвшөөрнө. 10.1 Шүүх нь худалдааны бүртгэл дэх мэдээллийг мужийн хууль эрх зүйн асуудал хариуцсан захиргааны дээд байгууллагаас тогтоосон цахим мэдээлэл, харилцаа холбооны системээр дамжуулан тодорхой хугцааны дотор мэдээнэ. Энд тус хуулийн §9.1-ийн 4, 5 дугаар өгүүлбэрийг хэрэглэнэ. Хуульд өөрөөр заагаагүй бол бүртгэлийг бүхэлд нь нийтэд ил болгоно. 15.1 Худалдааны бүртгэлд бүртгүүлбэл зохих үйл баримтыг бүртгүүлээгүй буюу нийтэд ил болгоогүй этгээд энэ мэдээллийг энэ талаар мэдээгүй гуравдагч этгээдийн эсрэг ашиглаж үл болно. Гэхдээ гуравдагч этгээд нь бүртгүүлэх ёстой үйл баримтын талаар мэдэж байсан тохиолдолд энэ заалт үйлчлэхгүй. 15.2 Үйл баримтыг бүртгэлд тусгаж, нийтэд ил болгосон бол гуравдагч этгээдийн эсрэг энэ тухай эсэргүүцлийг гаргаж болно. Энэ нь гуравдагч этгээд дээрх үйл баримтын талаар мэдээгүй, мэдэх боломжгүй байсан тохиолдолд бүртгэлийг ил болгосноос хойш 15 өдрийн дотор хийсэн хэлцэлд үл хамаарна. 15.3 Бүртгүүлбэл зохих мэдээллийг буруу ташаа нийтэд хүргэсэн бол энэ талаар үнэнийг мэдээгүй гуравдагч этгээд нь холбогдох этгээдийн эсрэг ил болгосон үйл баримтыг ашиглаж болно. Гэхдээ гуравдагч этгээд нийтэд ил болгосон агуулгыг буруу гэдгийг мэдэж байсан бол энэ заалт үйлчлэхгүй. 12.1 Худалдааны бүртгэлд бүртгүүлэх хүсэлтийг нийтээр гэрчлүүлсэн хэлбэрээр цахимаар ирүүлнэ. Бүртгэл хийлгэхтэй холбоотой итгэмжлэлд дээрх хэлбэрийн шаардлага хамаарна. Итгэмжлэлийн оронд Холбооны Нотариатын тухай хуулийн §21.3-ын дагуу нотариатын олгосон гэрчилгээг ирүүлж болно. Аль нэг талын хууль ёсны эрх залгамжлагч нь нийтээр гэрчлүүлсэн баримт бичгээр эрх залгамжлалаа нотолно. 12.2 Баримт бичгийг цахим хэлбэрээр ирүүлэх ёстой. Эх хувь эсвэл энгийн хуулбарыг ирүүлэх, эсвэл баримт бичигт бичгийн хэлбэрийн шаардлага тавьсан бол цахим хэлбэрээр илгээх хангалттай; нотариатаар гэрчлүүлсэн эсвэл нийтээр баталгаажуулсан хуулбар ирүүлэх ёстой бол энгийн электрон гэрчилгээ (Баримт гэрчлүүлэх тухай хуулийн §39а-д) хавсаргасан баримт бичгийг хамт дамжуулна.
2	Япон	8.1 Худалдааны хуулийн 1 дэх хэсэгт зааснаар бүртгүүлбэл зохих агуулгыг тухайн этгээдийн хүсэлтээр Худалдааны үйл ажиллагааны бүртгэлийн тухай хуульд заасны дагуу худалдааны бүртгэлд бүртгэнэ. 9.1 Худалдааны хуулийн 1 дэх хэсэгт зааснаар бүртгүүлбэл зохих агуулгыг бүртгүүлээгүй бол тухайн үйл баримтыг мэдээгүй гуравдагч этгээдэд эсэргүүцэл гаргах боломжгүй. Бүртгүүлсэн байсан ч гуравдагч этгээд зохих шалтгаанаар бүртгэл байсныг мэдээгүй бол мөн адил байна. 9.2 Санаатай болон болгоомжгүйн улмаас буруу ташаа агуулгыг

		бүртгүүлсэн этгээд нь тухайн агуулгыг буруу ташаагаар шалтаглан үүнийг мэдээгүй гуравдагч этгээдийн эсрэг эсэргүүцэл гаргах боломжгүй. 10.1 Худалдааны хуулийн 1 дэх хэсэгт зааснаар бүртгүүлсэн агуулгад өөрчлөлт гарсан эсхүл тухайн агуулга хүчингүй болсон бол бүртгүүлсэн этгээд нэн даруй өөрчлөлтийг бүртгүүлэх эсхүл хүчингүй болсон бүртгэлийг хийлгэх үүрэгтэй.
3	Вьетнам	7.1 Худалдаа эрхлэгч хуульд заасны дагуу худалдааны бүртгэлд бүртгүүлэх үүрэгтэй. Харин бүх худалдаа эрхлэгч худалдааны бүртгэлийн өмнө ч гэсэн энэ хууль болон холбогдох хуулийн дагуу тухайн худалдаа эрхлэгчийн явуулах бүхий л худалдааны үйл ажиллагаандаа хариуцлага хүлээнэ.

ХБНГУ-ын Худалдааны хуулийн 8-16-р зүйл хүртэл худалдааны бүртгэлийн харилцааг зохицуулж байна. Худалдааны бүртгэлийн харилцааг анх 1861 оны Германы нийтлэг худалдааны хууль(Allgemeines Deutsches Handelsgesetzbuch; ADHGB)-ийн 12-14-р зүйлийн хүрээнд зохицуулж байжээ. Уг хуулийн 12-р зүйлд худалдааны бүртгэлийг худалдааны шүүх хөтлөн явуулах тухай, 13-р зүйлд худалдааны бүртгэлийн агуулга нэн даруй нийтэд зарлагдаж байх тухай заалт байсан бөгөөд бүртгэлийн процессын талаарх заалт нь холбооны мужуудын өөрсдийн эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдахаар байжээ. Одоогийн худалдааны зохицуулалт мөн бүрэн төгс биш бөгөөд Компанийн хууль гэх мэт бусад хуулиар нөхвөр зохицуулалт хийгдэж байна. Худалдааны бүртгэлийн талаар сүүлийн үед хийгдсэн шинэчлэлийг 2007 оны Цахим худалдааны бүртгэл, хоршооны бүртгэл, аж ахуй нэгжийн бүртгэлийн тухай хууль (Gesetz über elektronische Handelsregister und Genossenschaftsregister sowie das Unternehmensregister;EHUG), 2008 оны Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн тухай хуулийг шинэчлэх, эрх урвуулан ашиглах явдлаас сэргийлэх тухай хууль (Gesetz zur Modernisierung des GmbH-Rechts und zur Bekämpfung von Missbräuchen;MoMiG) гэсэн хуулиудаар дамжуулан өрнүүлжээ. ХБНГУ-ын Худалдааны хуулийн 8-р зүйлийн 8.1 дэх хэсэгт зааснаар худалдааны бүртгэлийг шүүхээс хөтлөн явуулахаар заасан тул Шүүх байгуулах хууль(Gerichtsverfassungsgesetz)-ийн дагуу дүүргийн шүүх(Amtsgericht) хөтлөн явуулдаг байна.

Худалдааны бүртгэлийн агуулгыг заавал бүртгүүлэх болон бүртгүүлж болох гэж ангилдаг. Заавал бүртгүүлэх үйл баримтад нь худалдаа эрхлэгчийн худалдааны нэр, прокура олгосон болон хүчингүй болгосон, худалдааны аж ахуйн нэгжийг байгуулсан болон татан буулгасан тухай зэрэг мэдээлэл багтдаг байна.


Мэдээллийг үүргийн дагуу болон сайн дураар бүртгүүлэхийн үр нөлөө нь гуравдагч этгээдийн хувьд тодорхой нөхцөлд тухайн үйл баримтыг хамгийн сүүлд бүртгэлд тусгасан агуулгаар бодит нөхцөл байдал мэт тооцогддогт оршино¹⁰. Худалдааны бүртгэлийн үр дагавар нь Худалдааны хуулийн 15-р зүйлд заажээ. 1 дэх хэсэгт зааснаар бүртгүүлээгүй, нийтэд ил болгоогүй үйл баримтыг **бүртгүүлэх үүрэг хүлээсэн этгээд** нь тухайн үйл баримтыг мэдээгүй гуравдагч этгээдийн эсрэг эсэргүүцэл болгож гаргаж тавих боломжгүй, 2 дахь хэсэгт зааснаар бүртгүүлсэн нийтэд ил болгосон үйл баримтын хувьд

¹⁰ Ханс Кристоф Григолайт “Арилжааны эрх зүйн үндсэн зарчим” Хууль дээдлэх ёс сэтгүүл, 2018 он, №3, 87 дахь тал

зарчмын хувьд эсэргүүцэл гаргаж болно. 3 дахь хэсэг нь буруу үйл баримт нийтэд ил болсон бол гурагдагч этгээд нь тухайн үйл баримтыг ишлэж болохыг зөвшөөрсөн байна.

ХБНГУ-ын Худалдааны хуулийн 12-р зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар худалдааны бүртгэлд бүртгэл хийлгэх хүсэлтийг цахим хэлбэрээр гэрчүүлэн гаргах ёстой бөгөөд 12-р зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар бүртгүүлэх хүсэлт болох хавсралт баримт бичгийг аль альнийг нь цахих хэлбэрээр ирүүлэх ёстой байна. Ингэхийн тулд эхлээд бүртгүүлэх хүсэлтийг бичгээр үйлдэн, хүлсэт дээрх хүсэлтийн гаргагчийн гарын үсгийн нотариатчаар гэрчлүүлэн, Нотариатын тухайн 39а-р зүйлд заасны дагуу нотариатч нь цахим хэлбэрт оруулан хүсэлтийг гаргадаг байна. Хүсэлтийг цахим хэлбэрээр гаргахдаа ASCII, Unicode, RTF, Adobe PDF, Microsoft Word, XML, TIFF гэсэн өргөтгөлүүдийг ашиглаж гаргадаг байна.

Мөн түүнчлэн Худалдааны хуулийн 10-р зүйлийн дагуу шүүхээс нийтэд мэдээллэх, 9-р зүйлийн дагуу бүртгэлийн мэдээлэлтэй танилцах нь бүгд цахимаар явагддаг байна. www.handelsregister.de веб хуудаасаар дамжин худалдааны бүртгэлтэй танилцах боломжтой.



Япон улсын Худалдааны хуульд худалдааны бүртгэлийн харилцааг зохицуулж буй тус хуулийн 8-10-р зүйлүүд нь маш ерөнхий агуулга бүхий зохицуулалт байх бөгөөд дэлгэрэнгүй байдлаар Худалдааны үйл ажиллагааны бүртгэлийн тухай хуульд дэлгэрэнгүй зохицуулсан байна. Япон улсын Худалдааны үйл ажиллагааны бүртгэлийн тухай хуулийн 1 дүгээр зүйлд “Тус хууль нь Худалдааны тухай хууль, Компанийн тухай хууль болон бусад хуулийн заалтад үндэслэн заавал бүртгүүлэх нөхцөлийг нээлттэй болгохын тулд бүртгэлийн системийг хуульчилснаар худалдааны нэр, компанитай харилцах итгэлийг хадгалах мөн **хэлцлийн баталгаатай байдлыг хангах болон хурдан шуурхай явуулах зорилготой**” гэж заасан. Уг хуулийн 6-р зүйлд дараах 9 төрлийн бүртгэл хөтөлдөг тухай заажээ. Үүнд:

2. Худалдааны нэрийн бүртгэл/商号登記簿/
3. Насанд хүрээгүй худалдаа эрхлэгчийн бүртгэл/未成年者登記簿/
4. Худалдаа эрхлэгчийн асран хамгаалагчийн бүртгэл/後見人登記簿/

5. Прокуристийн бүртгэл/支配人登記簿/
6. Хувцаат компани бүртгэл/株式会社登記簿/
7. Бүх гишүүд нь бүрэн хариуцлага хүлээдэг компанийн бүртгэл/合名会社登記簿/
8. Зарим гишүүд нь хязгаарлагдмал хариуцлага хүлээдэг компанийн бүртгэл/合資会社登記簿/
9. Бүх гишүүд нь хязгаарлагдмал хариуцлага хүлээдэг компанийн бүртгэл/合同会社登記簿/
10. Гадаадын компанийн бүртгэл/外国会社登記簿/

Худалдаа эрхлэгчийн худалдааны үйл ажиллагаа нь олон тоогоор, дахин давтагдах байдлаар явагддаг тул олон тооны харилцагч гарч ирдэг. Худалдаа эрхлэгч буюу аж ахуйн нэгжийн дотоодод гаргасан шийдвэрийн дунд харилцагч этгээдтэй хийх хэлцэлд нөлөөлөх асуудал цөөнгүй боловч хэлцлийн нөгөө тал үүнийг судлах явдал нь худалдааны хэлцэл хурдан шуурхай байх, олон тоогоор хийгдэх шаардлагад нийцэхгүйн зэрэгцээ худалдаа эрхлэгчийн зүгээс арилжаа хийх бүрдээ нөгөө талдаа тухай бүр мэдэгдэх ёстой төвөгтэй байдал үүсгэдэг. Ийм учраас **хэлцэлд чухал нөлөөтэй асуудлыг нийтэд ил болгосноор** олон нийт буюу хэлцлийн харилцагч талын хувьд худалдаа эрхлэгчийн дотоод асуудлыг судлах тээг бэрхшээл буурах, урьдчилан харах боломжгүй хохиролоос сэргийлэх боломжтой болно. Мөн олон нийт буюу хэлцлийн харилцагч тал олон нийтэд ил болгосон агуулгыг мэдэж байгаа гэж тооцогдох учраас аж ахуйн нэгжийн хувьд мөн ашигтай тал ихтэй.

Иймд Япон улсад хэлцлийн баталгаат байдал болон түргэн шуурхай байдалд дэмжлэг болох зорилгоор Худалдааны үйл ажиллагааны бүртгэлийн тогтолцоог бий болгож, төрийн байгууллага болох улсын бүртгэлийн газар бүртгэх ажиллагааг явуулж, бүртгэлтэй холбоотой мэдээллийг хураамж төлсөн хэн бүхэнд олж авахад нээлттэй болгосон байна.

Япон улсын хувьд худалдааны бүртгэлийн агуулгатай <https://www1.touki.or.jp/operate/index.html> гэсэн вэб хуудсаар дамжуулан олон нийт таницлах боломжтой байдаг байна.



Бүртгэлээс олж авах боломжтой мэдээлэл нь тухайбал компани бол дараах байдлаар харагддаг байна.

2015/10/05 08:40 現在の情報です。

東京都△△△△区□□□一丁目1番15号
株式会社○○機器

会社法人等番号	△△△△-△△-△△△△△△	
商 号	株式会社 ○○機器	
本 店	東京都△△△△区□□□一丁目1番15号	
公告をする方法	官報に掲載している	
会社成立の年月日	平成23年6月30日	
目的	1. 電子機器の部品製造 2. 電子機器の販売	
発行可能株式総数	800株	
発行済株式の総数 並びに種類及び数	発行済株式の総数 200株	
資本金の額	金1000万円	
株式の譲渡制限に 関する規定	当会社の株式は、株主総会の承認がなければ譲渡することができない	
役員に関する事項	取締役 登 記 一 郎	平成○○年○○月○○日就任 平成○○年○○月○○日登記
	取締役 登 記 二 郎	平成○○年○○月○○日就任 平成○○年○○月○○日登記
	取締役 登 記 三 郎	平成○○年○○月○○日就任 平成○○年○○月○○日登記
	東京都△△△△区□□□一丁目34番1号 代表取締役 登 記 一 郎	平成○○年○○月○○日就任 平成○○年○○月○○日登記
	東京都△△△△区□□□一丁目34番1号 代表取締役 登 記 二 郎	平成○○年○○月○○日就任 平成○○年○○月○○日登記
登記記録に関する 事項	設立 平成23年 6月30日登記	

*下線のあるものは抹消事項であることを示す。

Үүнд:

- Компанийн дугаар
- Компанийн нэр буюу худалдааны нэр
- Хаяг
- Мэдээлэл хүргэх арга
- Үүсгэн байгуулагдсан он сар
- Зорилго буюу үйл ажиллгааны чиглэл
- Нэрлэсэн хувьцааны тоо
- Гаргасан хувьцаа
- Хөрөнгийн хэмжээ мөнгөн дүнгээр
- Хувьцааг шилжүүлэхийг хязгаарласан заалт
- ТУЗ-ийн гишүүд

-Гүйцэтгэх удирдлага

-Бүртгүүлсэн он сар гэсэн мэдээллийг тодорхой хэмжээний хураамж төлөөд хэн ч бай танилцах боломжтой байна.

Манай улсын шинэчилэн найруулсан Улсын бүртгэлийн ерөнхий хууль 2018 оны 6-р сард батлагдсан бөгөөд эхсэлсэн бөгөөд энэ хуулийн 12-р зүйлийн 12.2.3 дахь хэсэгт “хуулийн этгээдийн нэр, хаяг, регистрийн дугаар, төрөл, хэлбэр, үйл ажиллагааны чиглэл, улсын бүртгэлд бүртгэсэн огноо, үүсгэн байгуулагчийн нэр, тэдгээрийн тоо, хувьцаа эзэмшигчийн нэр, итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээдийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хуулийн этгээд өөрчлөн байгуулагдсан эсэх, хэлбэр, оноосон нэр өөрчлөгдсөн, татан буугдсан талаарх мэдээлэл” гэсний дагуу <http://opendata.burtgel.gov.mn/> хуулийн этгээдийн дараах мэдээллийг авах боломжтой байна.

opendata.burtgel.gov.mn/lesinfo/2077108						
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРГЭЖҮҮЛЭГЧ АГЕНТАГ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР НҮҮР ХҮҮДАС НЭЭЛТТЭЙ МЭДЭЭЛЭЛ						
Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэл						
Үндсэн мэдээлэл						
Регистрийн дугаар	Оноосон нэр	Бүртгэсэн огноо	Хэлбэр	Төрөл	Хувьцаа эзэмшигч, гишүүний тоо	Хуулийн этгээдийн хаяг
2077108	Сүү	2007.07.17	ХК	Ашгийн төлөө	275	Улаанбаатар, Сонгинохайрхан, 29-р хороо, үйлдвэрчний эвлэл.
Хувьцаа эзэмшигч, гишүүний мэдээлэл						
Д/д	Ангилал	Улсын нэр	Эцэг/эх/-ийн нэр	Нэр	Бүртгэсэн огноо	
1	Иргэн	Mongol	Дагвадорж	Ганбаатар	2010.12.20	
2	Иргэн	Mongol	Базардорж	Түвшинтөгс	2007.07.17	
3	Иргэн	Mongol	-	Бусад	2007.07.17	
4	Иргэн	Mongol	Дагвадорж	Жаньян	2007.07.17	
Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий албан тушаалтан, эрх барих этгээдийн мэдээлэл						
Д/д	Албан тушаал	Улсын нэр	Эцэг/эх/-ийн нэр	Нэр	Бүртгэсэн огноо	
1	Гүйцэтгэх захирал	Mongol	Мангбаяр	Мангхай	2018.10.15	
Үйл ажиллагааны чиглэлийн мэдээлэл						
Д/д	Үйл ажиллагааны код	Үйл ажиллагааны чиглэл			Бүртгэсэн огноо	
1	1050	Сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа			2007.07.17	
2	4923	Сүүний тээврийн үйлчилгээ			2007.07.17	

Энэхүү шинэчлэл нь манай улс хэдийгээр худалдааны хууль байхгүй хэдий ч бусад орны худалдааны хуулиар худалдааны бүртгэлийн агуулгыг олон нийтэд ил болгох гэсэн үзэл баримтлалтай нэг агуулгатай байгаа нь тун дэвшилттэй үйлдэл болохын зэрэгцээ Худалдааны хуультай болох тохиолдолд худалдааны бүртгэлийн үндэсийг аль хэдий нь тавьжээ гэж хэлж болохоор байна.

Дүгнэлт

Худалдааны бүртгэлийн гол зорилго нь нь тухайн худалдаа эрхлэгчдэд хамаарах тодорхой үйл баримт найдвартай болохыг гэрээний нөгөө талд батлан харуулах


зорилготой байна. Түүнчлэн худалдааны бүртгэлд итгэсэн гуравдагч этгээдийг хамгаалах зорилготой бөгөөд хэлцлийн баталгаат байдлыг хангахад гол чиг үүрэг гүйцэтгэж байна.

Зөвлөмж:

- Хувь худалдаа эрхлэгч худалдааны бүртгэл хийлгэх боломжтой тогтолцоог бий болгох
- Манай улсад хуулийн этгээдийн бүртгэлийн тодорхой мэдээллийг олон нийтэд нээлттэй байгаа боловч хангалтгүй байгаа бөгөөд тухайлбал хөрөнгийн хэмжээний талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох шаардлагатай байна.
- Түүнчлэн нээлттэй болгосон мэдээллэд итгэсэн гуравдагч этгээдийн ашиг сонирхолыг хамгаалах эрх зүйн үр дагавар бүхий зохицуулалт бий болгох шаардалгатай.

3.5 ХУДАЛДААНЫ НЭР

Худалдааны нэр нь аж ахуй нэгжийн субъект болох худалдаа эрхлэгчийн бизнесийн үйл ажиллагаандаа хэрэглэж буй нэр боловч урт удаан хугацааны туршид хэрэглэх явцад тухайн бизнесийн үйл ажиллагааг илэрхийлэх нэр болж хувирдаг онцлогтой. Худалдааны нэр нь бас бусдын итгэлийг татах чиг үүрэгтэй бөгөөд олон нийт худалдааны нэрийн ард байх худалдаа эрхлэгчээс илүүтэй худалдааны нэрэнд итгэх нь илүү болж ирдэг байна. Энэ тохиолдолд тухайн худалдааны нэрийг ашиглаж буй худалдаа эрхлэгчийн тухайн нэрээс үүдэх хэрэглэгчийн татах чадвар зэрэг эдийн засгийн ашиг сонирхлыг хамгаалах шаардлага гарч ирнэ. Иймээс худалдааны нэрийг эд хөрөнгө гэж үзэн түүнийг өвлүүлэх, шилжүүлэх, гадны халдлагаас хамгаалах зэрэг эрх зүйн хамгаалалт шаардлагатай болдог. Нөгөө талаас худалдааны харилцаанд оролцох боломжтой олон нийтийг төөрөгдөхүйц худалдааны нэрний улмаас хохирол амсахаас урьдчилан сэргийлэх шаардлагатайгаас гадна худалдааны эрхлэгч худалдааны нэр сонгоходоо гуравдагч этгээдэд төвөг саад, хор уршигаас учруулахаас зайлсхийх шаардлагатай болно.




Худалдааны нэр нь нэр учраас авиа дуудлага бүхий үсгээр илэрхийлэгдсэн байх ёстой.

№	Улс	Худалдааны хуулийн зохицуулалтын агуулга
1	ХБНГУ	17.1 Арилжааны нэр гэдэгт түүний үйл ажиллагаа явуулж буй, мөн гарын үсгээ доор нь зурж буй нэрийг ойлгоно. 17.2 Худалдаачин дээрх нэрийн дор нэхэмжлэл гаргах, энэ нэрээрээ хариуцагчаар татагдах боломжтой. 18.1 Арилжааны нэр буюу фирм нь худалдаачныг тодорхойлох, бусдаас ялгах чадвартай байх ёстой. 18.2 Энэ нэр нь тухайн харилцаанд оролцогсдод чухалд тооцогдох бизнесийн нөхцөл байдлын талаар төөрөгдүүлэхэд хүргэх мэдээлэл агуулах ёсгүй. Бүртгэл эрхэлж буй шүүхийн өмнө гагцхүү илт төөрөгдүүлэх магадлал бүхий тохиолдлыг хянан хэлэлцэнэ. 19.1 Энэ хуулийн §§21, 22, 24, эсвэл бусад хуулийн заалтуудын дагуу тухайн фирмийн үйл ажиллагааг үргэлжлүүлэн явуулах нөхцөлд ч гэсэн дараахй нэмэлтийг тусгана. 2Үүнд: 1.дангаар арилжаа эрхлэгчийн хувьд „бүртгэгдсэн худалдаачин“ буюу энэ нэр томъёоны нийтэд ойлгомжтой товчилсон хэлбэрийг, тухайлбал „e.K.“, „e.Kfm.“ эсвэл „e.Kfr.“; 2.нээлттэй арилжааны компанийн хувьд „нээлттэй арилжааны компани“ эсвэл тухайн нэрийн нийтэд ойлгомжтой товчилсон хэлбэрийг; 3.хязгаарлагдмал түншлэлийн хувьд „хязгаарлагдмал түншлэл“ гэсэн нэр томъёо буюу энэ нэрийн нийтэд ойлгомжтой товчилсон хэлбэрийг тус тус хамаарна. 19.2 Нээлттэй хувьцаат компани эсвэл хязгаарлагдмал түншлэлд хувь хүн биеэр хариуцлага хүлээхгүй бол энэ хуулийн §§21, 22, 24 буюу бусад хууль тогтоомжийн дагуу арилжааны нэрийг үргэлжлүүлэн

		ашиглаж байгаа ч хариуцлагын хязгаарлагдсан тухай тэмдэглэгээг тусгана. 23.1 Арилжааны нэрийг эрхэлж буй арилжааны үйл ажиллагаанаас ангид захиран зарцуулж үл болно. 29.1 Худалдаачин бүр өөрийн арилжааны нэр, үндсэн үйл ажиллагаа явуулах оффисын байрлах газар, дотоодын хаягийг харъяа дүүргийн арилжааны бүртгэлд шүүхэд бүртгүүлнэ. 30.1 Шинэ ААН-ийн нэрийг бүр тухайн газар эсвэл нэг суурин газар оршин байгаа арилжааны бүртгэлд бүртгүүлсэн эсвэл хоршоодын бүртгэлд бүртгэгдсэн бүх ААН-ээс ялгах боломжтой байх ёстой. 30.2 Өмнө нь бүртгүүлсэн худалдаачинтай ижил нэртэй, овог, нэр нь ижил байсан ч энэ л нэршлийг ашиглахыг хүсвэл тэрээр өмнөх бүртгэлтэй нэрээс түүний арилжааны нэрийг тод ялгахуйц нэмэлт ашиглана. 30.3 Хэрэв тухайн салбар байгуулагдсан суурин газар буюу салбартай аль нэгэн ижил тооны бүртгэлтэй компани байгаа бол 2 дахь хэсгийн заалтыг харгалзан салбарыг нэмж оруулна. 30.4 Салбар байгуулсан газар, орон нутгийн засаг захиргааны нэгжид ижил нэр бүхий арилжаа эрхлэгч бүртгэгдсэн бол салбар нэгжийн нэр дээр энэ зүйлийн §2-т заасны дагуу нэмэлт ашиглана. 30.5 Мужийн засгийн газрууд нь хөрш зэргэлдээ газар, засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжүүдийг энэ зүйлийн хүрээнд нэг нэгж мэтээр тооцох тухай зохицуулж болно.
2	Япон	11.1 Худалдаа эрхлэгч(Компани болон Гадаадын компанид үл хамаарна.) нь өөрийн нэр, овог болон бусад нэршлийг ашиглан өөрийн худалдааны нэрээ болгож болно. 11.2 Худалдаа эрхлэгч нь өөрийн худалдааны нэрээ бүртгүүлж болно. 12.1 Аливаа этгээд зүй бус зорилгоор бусад худалдаа эрхлэгчид андуурагдаж болзошгүй нэршил эсвэл худалдааны нэр хэрэглэхийг хориглоно. 12.2 Өмнөх заалтыг зөрчих нэршил эсвэл худалдааны нэр хэрэглэснээр аж ахуйн үйл ажиллагааны ашиг сонирхол зөрчигдсөн, эсвэл зөрчигдөж болзошгүй байгаа худалдаа эрхлэгч нь өөрийнхөө аж ахуйн үйл ажиллагааны ашиг сонирхолыг зөрчсөн этгээд эсвэл зөрчиж болзошгүй этгээдийн эсрэг тухайн зөрчлөө зогсоох эсвэл зөрчлөөс урьдчилан сэргийлэхийг шаардах эрхтэй. 13.1 Өмнөх зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн этгээдийг нэг сая иенээс илүүгүй хэмжээгээр торгоно. 14.1 Өөрийн худалдааны нэрийг ашиглуулж худалдааны үйл ажиллагаа эсвэл аж ахуйн үйл ажиллагаа явуулахыг бусад зөвшөөрсөн худалдаа эрхлэгч нь түүний худалдааны үйл ажиллагаа гэж андууран нөгөө худалдааны нэрийг нь ашиглаж буй этгээдтэй хэлцэл хийсэн этгээдийн өмнө нөгөө этгээдтэйгээ хамтран тухайн хэлцлээс үүссэн үүргийг гүйцэтгэх хариуцлага хүлээнэ. 15.1 Худалдаа эрхлэгч худалдааны нэрээ худалдааны үйл ажиллагаа шилжүүлэх эсвэл худалдааны үйл ажиллагаа зогсоосон тохиолдолд л

		шилжүүлж болно. 15.2 Өмнөх заалтын дагуу худалдааны нэрээ шилжүүлэхэд бүртгүүлээгүй бол гуравдагч этгээдийн эсрэг эсэргүүцэл гаргах боломжгүй.
3	Вьетнам	Худалдааны хуулинд тодорхой зохицуулалт байхгүй

Онолын хувьд худалдааны нэр сонгох эрхийг дараах гурван үндсэн ангилалд хуваадаг.



Худалдааны нэр шударга байх зарчим гэдэг нь худалдааны нэр тухайн худалдаачны нэр, худалдааны үйл ажиллагаа, үйл ажиллагаа явуулж буй газар нутаг зэрэгтэй тохирсон байх ёстой бөгөөд худалдааны нэрийг шилжүүлэх, өв залгамжлуулах зэргийг зөвшөөрдөггүй. Харин худалдааны нэр чөлөөтэй байх зарчим нь ямар нэгэн хязгаарлалт байхгүй. Харин холимог зарчмын хувьд худалдаачны нэр нь үйл ажиллагааны төрөлтэй зохицсон байхыг шаардах боловч үйл ажиллагаагаа шилжүүлэх, бэлэглэх, өв залгамжлуулах, худалдаачны овог нэр өөрчлөгдөх, үйл ажиллагааны төрлөө өөрчлөх зэрэгт өмнөх худалдааны нэрээ үргэлжлүүлэн ашиглахыг зөвшөөрдөг онцлогтой.

Манай Улсын хувьд хуулийн этгээдийн худалдааны нэрийн талаар тодорхой зохицуулалт оршин байна. Тэр дундаа хуулийн этгээдийн нэрийг сонгоход чөлөөтэй байх зарчим үйлчилж байна гэж хэлж болохоор байна.

№	Агуулга	Зохицуулалт
1	Хуулийн этгээдийн хувьд ХХК, ХК гэх мэт хэлбэрээ нэрэндээ тусгах ёстой.	Иргэний хуулийн 27-р зүйлийн 27.1 дэх хэсэг “Хуулийн этгээд өөрийн нэртэй байна. Хуулийн этгээдийн нэр нь түүний зохион байгуулалт, эрх зүйн хэлбэрийг тусгасан байна.”
2	Банк ХХК гэх мэт	Иргэний хуулийн 27-р зүйлийн 27.2 дахь хэсэг “Хуульд

	хуулийн этгээдийн төрлөө тусгах ёстой.	заасан бол хуулийн этгээдийн төрлийг заасан нэртэй байна.
3	Худалдааны нэрд тавьж буй хязгаарлалт	Иргэний хуулийн 27-р зүйлийн 27.3 дахь хэсэг “Хуулийн этгээдийн нэр өөр хуулийн этгээдийн нэртэй давхардсан буюу бусдыг төөрөгдүүлэхээр ижил, төсөөтэй байж болохгүй”.
4	Худалдааны нэрийг хууль бусаар ашигласны улмаас үүсэх хохирлыг шаардах эрх	Иргэний хуулийн 27-р зүйлийн 27.4 дэх хэсэг “Хуулийн этгээдийн нэрийг бусад этгээд хууль бусаар ашиглахыг хориглоно. Энэ заалтыг зөрчсөн этгээд бусдад учруулсан гэм хорыг энэ хуулийн 497 дугаар зүйлд заасан журмын дагуу арилгана”.
5	Нэрээ бүртгүүлэх үүрэг	Иргэний хуулийн 27-р зүйлийн 27.5 дахь хэсэг “Хуулийн этгээд нэрээ хуульд заасан журмын дагуу бүртгүүлнэ”.
6	Худалдааны нэрийг хамгаалах	Иргэний хуулийн 27-р зүйлийн 27.6 дахь хэсэг “Хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг хамгаалахад энэ хуулийн 21 дүгээр зүйлийн заалт нэгэн адил хамаарна”

Хэрэв худалдааны нэрийг хууль бусаар ашигласан, хэрэглэгчийг төөрөгдүүлэхүйц нөхцөлийг бүрдүүлсэн бол худалдаа эрхлэгч нь тухайн хууль бус үйлдлийг зогсоолгох, түүнээс учирсан хохирлыг нөхөн төлүүлэхийг шаардах эрхтэй.

Худалдааны нэрийг ашиглуулах

Худалдааны нэрийг ашиглуулах гэдэг нь бусад этгээд (худалдааны тэмдэг ашиглагч)-д өөрийн худалдааны нэрийг ашиглан аж ахуйн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох явдлыг ойлгоно.

ХБНГУ-ын Худалдааны хуулийн 23-р зүйлд 23.1 дэх хэсэгт “Арилжааны нэрийг эрхэлж буй арилжааны үйл ажиллагаанаас ангид захиран зарцуулж үл болно” гэж үйл ажиллагаанаасаа ангид худалдааны нэрийг ашиглуулахыг хориглосон байна. Харин Япон улсын хувьд Худалдааны хуулийн 14-р зүйлийн 14.1 дэх хэсэгтээ “Өөрийн худалдааны нэрийг ашиглуулж худалдааны үйл ажиллагаа эсвэл аж ахуйн үйл ажиллагаа явуулахыг бусдад зөвшөөрсөн худалдаа эрхлэгч нь түүний худалдааны үйл ажиллагаа гэж андууран нөгөө худалдааны нэрийг нь ашиглаж буй этгээдтэй хэлцэл хийсэн этгээдийн өмнө нөгөө этгээдтэйгээ хамтран тухайн хэлцлээс үүссэн үүргийг гүйцэтгэх хариуцлага хүлээнэ” гэж заасан байна.

Өөрөөр хэлбэл, худалдааны нэрээ ашиглахыг зөвшөөрсөн худалдаа эрхлэгч буюу компани (худалдааны нэрээ ашиглуулагч) нь тухайн худалдааны нэрийг өөр бусад этгээд ашиглан аж ахуйн үйл ажиллагаа явуулж байгаа талаар мэдээгүйгээс болж төөрөгдсөн этгээд (худалдааны нэр ашиглуулагчийн хувьд гуравдагч этгээд болно)-ийн өмнө тухайн хэлцлийн үр дүнд хүлээсэн үүргийг худалдааны нэр ашиглагчтай хамтран биелүүлэх хариуцлага хүлээнэ гэсэн үг.

Япон улсын хувьд худалдааны нэртэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг Худалдааны хууль, Компанийн хууль, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулиар бий болгосон байдаг. Өмнө нь жижиг худалдаа эрхлэгч нь худалдааны нэр ашиглах боломжгүй байснаар жижиг худалдаачны бизнесийн үйл ажиллагаандаа ашиглаж буй оноосон нэр нь худалдааны нэрэнд тооцогддоггүй байсан боловч Худалдааны хуулийн өөрчлөлтөөр жижиг худалдаачны хувьд ч худалдааны нэр ашиглах эрхтэй (Худалдааны

хууль 11.1) болсон ч түүнийгээ бүртгүүлэх эсэх нь худалдаа эрхлэгчийн сонголтын асуудал юм. (Худалдааны хууль 11.2.)

Худалдааны хуулийн 11-р зүйлийн 11.1 дэх хэсэгт Компани болон Гадаадын компанид үл хамаарна гэсэн заалт оруулсанч Компанийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.1 дэх хэсэг, 5-р зүйлд зааснаар компанийн нэр нь худалдааны нэр болдог. Нэг аж ахуйн үйл ажиллагаанд нэг худалдааны нэр гэсэн зарчим үйлчилнэ. Хуулийн этгээдийн хувьд хуулийн этгээдийн нэр нь худалдааны нэр болох тул олон төрлийн аж ахуйн үйл ажиллагаа явуулсан ч нэг л худалдааны нэртэй байна. Харин хувь хүн нэг худалдааны нэрээр олон төрлийн худалдааны үйл ажиллагаа явуулахын зэрэгцээ худалдаа үйл ажиллагаа бүртгээ тусад нь худалдааны нэртэй байж болдог байна.

Дүгнэлт

Худалдааны нэрийг хамгаалах тогтолцоо бий болгох зайлшгүй шаардлагатай. Манай улсад мөн хуулийн этгээдийн хүрээнд хуулийн этгээдийн нэрийг хамгаалах тогтолцоо бий боловч хангалттай бус байна. Хувь аж ахуй эрхлэгчийн хувьд худалдааны нэрээ бүртгүүлэх боломжгүй. Иргэний хуулийн 20-р зүйлийн 20.3 дахь хэсэгт “Иргэний нэрийг эрх бүхий байгууллагад бүртгүүлнэ. **Иргэний эрх, үүргийг иргэн өөрийн нэрээр олж авч хэрэгжүүлнэ.** Гагцхүү хуульд заасан нөхцөл, журмын дагуу **зохиомол нэр** хэрэглэж болно” гэж заасны дагуу хувь этгээд зохиомол нэр хэрэглэж болохыг Иргэний хуулиар зөвшөөрсөн боловч худалдааны харилцаанд иргэн зохиомол нэрээр эрх, үүрэг олж авах тухай хуульчилсан зохицуулалт одоогоор байхгүй байна.

Монгол Улсын Иргэний хуулийн 333-р зүйлийн 333.1 дэх хэсэгт “Франчайзийн гэрээгээр эрх шилжүүлэгч нь **өөрийн фирмийн нэр**, бараа буюу ажил, үйлчилгээний тэмдэг, бүтээгдэхүүний загвар, баглаа, боодол, түүнчлэн ажил хэргийн удирдлагын тогтолцоо, төлөвлөлт, харилцаа холбоо, бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ олж авах үндсэн чиглэл зэрэг эдийн бус хөрөнгийг ашиглуулахаар тогтоосон журмаар бүрдүүлсэн лицензийг эрх хүлээн авагчид олгох, эрх хүлээн авагч нь эрх шилжүүлэгчийн боловсруулсан тогтолцоо, хамтын ажиллагааны хөтөлбөрийн дагуу үйл ажиллагаа явуулж, түүнд зохих шагнал, хураамж, эсхүл орлогын тодорхой хувийг төлөх үүргийг тус тус хүлээнэ” гэж заасан нь худалдаа эрхлэгч өөрийн фирмийн нэрээ бусдад шилжүүлж болох талаар хуульчилсан байна. Гэвч нэрээ шилжүүлэх тохиолдолд үүсэх үр дагаврын талаар зохицуулаагүй байна.

Зөвлөмж

- Хувь худалдаа эрхлэгч өөрийн нэрээс гадна бусад зохиомол нэрээр худалдааны үйл ажиллагаа явуулах боломжийг бүрдүүлэх
- Худалдааны нэрийг хууль бусаар ашиглах тохиолдолд зөрчлийн хуулиар шийтгэх тогтолцоог бий болгох
- Худалдааны нэрийг бусдад шилжүүлж ашиглуулах тохиолдолд үүсэх харилцааг зохицуулах, гуравдагч этгээд хохирохоос сэргийлэх
- Худалдааны эрхлэгчийн гишүүнчлэлийн бүтэц өөрчлөгдөхөд худалдааны нэртэй холбоотой үүсэх харилцааг зохицуулах

3.6 ХУДАЛДААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ШИЛЖҮҮЛЭХ

Худалдааны үйл ажиллагаагч шилжүүлэх гэдэг нь тодорхой аж ахуйн үйл ажиллагааны төлөө зохион байгуулагдсан, бие даан үйл ажиллагаа явуулах чиг үүрэг

бүхий хөрөнгийг бүгдийн эсвэл зарим хэсгийг нь шилжүүлэхийг хэлэх бөгөөд шилжүүлж буй аж ахуй эрхлэгч нь тухайн хөрөнгөөр эрхэлж байсан аж ахуйн үйл ажиллагааг дахин явуулж аж ахуйн үйл ажиллагааг шилжүүлж авсан этгээдтэй өрсөлдөхгүй байх үүрэг хүлээдэг байна.

№	Улс	Худалдааны хуулийн зохицуулалтын агуулга
1	ХБНГУ	21.1 Хэрэв тухайн фирмийн үйл ажиллагаа эрхлэгч эсвэл хувь нийлүүлэгч өөрчлөгдөөгүй, гагцхүү түүний нэр өөрчлөгдсөн бол тухайн фирмийг хуучин нэрээр үргэлжлүүлж болно. 22.1 Өмнө эхлүүлсэн бизнесийн үйл ажиллагааг гэрээ хэлцэл болон өвлөх зорилгоор залгамжлан үргэлжлүүлж байгаа бол фирм нь өмнөх эзэмшигчийн нэртэй байсан ч өмнөх эзэмшигч эсвэл түүний өвлөгч зөвшөөрсөн нөхцөлд фирмийн үйл ажиллагааг хуучин нэрээр явуулах бөгөөд эрх залгамжлалыг нэмэлт хэлбэрээр тусгах боломжтой. 22.2 Узуфрукт, түрээс буюу түүнтэй адилтгах эрх зүйн харилцааны үндсэн дээр арилжааны хэлцэл хийгдсэн бол эдгээр зохицуулалтыг төсөөтэй хэрэглэнэ. 24.1 Арилжаа эрхлэгч нэмэгдсэн, арилжааны компанид хувь нийлүүлэгч нэмэгдсэн эсвэл үүнээс гарсан ч уг өөрчлөлтөөс үл хамааран фирмийг хуучин эзний нэрээр үргэлжлүүлэн явуулж болно. 24.2 Арилжааны нэр нь тусгагдсан хувь нийлүүлэгч гарсан тохиолдолд хуучин нэрээр үйл ажиллагааг үргэлжлүүлэхийн тулд түүний эсвэл өв залгамжлагчдын зөвшөөрөл шаардлагатай. 25.1 Арилжаа эрхлэгчтэй хэлцэл хийх замаар түүнийг амьд байхад нь фирмийн үйл ажиллагааг шилжүүлэн авч, хуучин фирмийг хэвээр нь эсвэл эрх залгамжлалыг ил болгосон нэмэлтийн хамт үргэлжлүүлэн ажиллуулж буй этгээд нь өмнөх арилжаа эрхлэгчийн аж ахуйн үйл ажиллагааны явцад хүлээсэн үүргийг хариуцна. Өмнөх аж ахуй эрхлэгч болон түүний өв залгамжлагчид нь фирмийг үргэлжлүүлэхийг зөвшөөрсөн бол хуучин үүрэг гүйцэтгэгчдийн эсрэг үүссэн байсан шаардах эрхүүдийг эрх залгамжлагчид шилжсэнд тооцно. 25.2 Дээрхийг өөрчилсөн тохиролцоо нь гагцхүү арилжааны бүртгэлд бүртгэгдэж, нийтэд ил болсон эсвэл шаардлага шилжүүлэгч болон илжүүлэн авагчийн аль нэг нь гуравдагч этгээдэд мэдэгдсэн өхцөлд л гуравдагч этгээдийн хувьд хүчин төгөлдөр болно. 25.3 Хэрэв хуучин нэрийг үргэлжлүүлэн аваагүй бол арилжааны үйл ажиллагааг шилжүүлэн авсан этгээд нь хуучин өр төлбөрийг гагцхүү онцгой шалтгаан бий нөхцөлд хариуцах ба ялангуяа шинэ аж ахуй эрхлэгч үүргийг гүйцэтгэх тухайгаа арилжааны заншилд нийцэх хэлбэрээр мэдэгдсэн нөхцөлд хариуцлага хүлээнэ.
2	Япон	16.1 Худалдааны үйл ажиллагаагаа шилжүүлсэн худалдаа эрхлэгч нь талууд өөрөөр тохиролцоогүй бол нэг хот, тосгоны дэвсгэр дотор болон хил залгаа хот, тосгоны нутаг дэвсгэрт худалдааны үйл ажиллагаагаа шилжүүлсэн өдрөөс 20 жилийн хугацаанд тухайн худалдааны үйл ажиллагаагаа явуулахыг хориглоно. 16.2 Худалдааны үйл ажиллагаагаа шилжүүлсэн этгээд нь тухайн худалдааны үйл ажиллагааг явуулахгүй тухай тусгайлан тохиролцсон


	тохиолдолд тухайн тохиролцоо нь худалдааны үйл ажиллагаагаа шилжүүлсэн өдрөөс 30 жилийн хугацаанд хүчинтэй байна. 16.3 Өмнөх 2 заалтыг үйл харгалзан худалдааны үйл ажиллагаагаа шилжүүлсэн этгээд нь шударга буй зорилго агуулан тухай худалдааны үйл ажиллагаа явуулж болохгүй. 17.1 Худалдааны үйл ажиллагааг шилжүүлэн авсан этгээд нь шилжүүлэн өгсөн этгээдийн худалдааны нэрийг үргэлжлүүлэн хэрэглэх тохиолдолд шилжүүлэн авсан этгээд нь шилжүүлэн өгсөн этгээдийн худалдааны үйл ажиллагаанаас үүссэн үүргийг гүйцэтгэх хариуцлага хүлээнэ. 17.2 Өмнөх заалт нь худалдааны үйл ажиллагааг шилжүүлсэний дараа нэн даруй шилжүүлэн авсан этгээд нь шилжүүлэн өгсөн этгээдийн үүргийг гүйцэтгэх хариуцлага хүлээхгүй тухай бүртгэл хийлгэсэн тохиолдолд хэрэглэгдэхгүй. Худалдааны үйл ажиллагааг шилжүүлсэний дараа нэн даруй шилжүүлэн авсан этгээд болон шилжүүлэн өгсөн этгээдээс гуравдагч этгээдэд хандан энэ тухай мэдэгдсэн тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсан гуравдагч этгээдэд нэгэн адил үйлчилнэ. 17.3 Шилжүүлэн авсан этгээд нь 1 дэх заалтын дагуу шилжүүлэн өгсөн этгээдийн үүргийг гүйцэтгэх хариуцлага хүлээх тохиолдолд шилжүүлэн өгсөн этгээдийн хариуцлага нь худалдааны үйл ажиллагааг шилжүүлсэн өдрөөс 2 жилийн дотор шаардлага гаргаагүй үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьд уг хугацаа өнгөрснөөр дуусгавар болно. 17.4 1 дэх заалтад заасан тохиолдолд шилжүүлэн өгсөн этгээдийн худалдааны үйл ажиллагаанаас үүссэн шаардах эрхийн тухайд шилжүүлэн авсан этгээд үүргийн гүйцэтгэлийг хүлээн авсан бол үүрэг гүйцэтгэгч мэдээгүй бөгөөд илт мэдэх боломжтой байгаагүй бол үүргийн гүйцэтгэл хүчинтэй байна. 18.1 Шилжүүлэн авсан этгээд нь шилжүүлэн өгсөн этгээдийн худалдааны нэрийг үргэлжлүүлэн хэрэглэхгүй байх тохиолдолд ч шилжүүлэн өгсөн этгээдийн худалдааны үйл ажиллагаанаас үүссэн үүргийг гүйцэтгэх тухай олон нийтэд мэдээлсэн бол шилжүүлсэн этгээдийн үүрэг гүйцэтгүүлэгч нь шилжүүлэн авсан этгээдээс үүргийн гүйцэтгэлийг шаарагдах эрхтэй. 18.2 Шилжүүлэн авсан этгээд нь өмнөх заалтын дагуу шилжүүлсэн этгээдийн үүргийг гүйцэтгэх хариуцлага хүлээх тохиолдолд шилжүүлэн өгсөн этгээдийн хариуцлага нь өмнөх заалтад тусгагдсан олон нийтэд мэдээлсэн өдрөөс 2 жилийн дотор шаардлага гаргаагүй үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьд уг хугацаа өнгөрсөнөөр дуусгавар болно. 18².1 Шилжүүлэн өгсөн этгээд нь шилжүүлэн авсан этгээдэд шилжихгүй үүргийн үүрэг гүйцэтгүүлэгчид хохирол учирахыг мэдсээр байж худалдааны үйл ажиллагаагаа шилжүүлсэн тохиолдолд тухайн үүрэг гүйцэтгүүлэгч нь шилжүүлэн авсан этгээдийн эсрэг шилжүүлсэн хөрөнгийн үнийн дүнгээр тухай үүргийн гүйцэтгэлийг шаардаж болно. Гэхдээ шилжүүлэн авсан этгээд нь худалдааны үйл ажиллагааны шилжүүлэлт хүчинтэй болсон үед өмнөх үүрэг гүйцэтгүүлэгчид хохирол учруулах үйл баримтын талаар мэдээгүй бол энэ заалт үйлчлэхгүй.
--	--

		18².2 Шилжүүлэн авсан этгээд нь өмнөх заалтын зохицуулалтын дагуу өмнөх заалтад тусгагдсан үүргийг гүйцэтгэх хариуцлага хүлээх тохиолдолд тухайн хариуцлага нь шилжүүлэн өгсөн этгээд өмнөх үүрэг гүйцэтгүүлэгчид хохирол учруулахыг мэдээд худалдааны үйл ажиллагааг шилжүүлснийг мэдсэн үеэс 2 жилийн дотор шаардлага гаргаагүй өмнөх үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьд уг хугацаан өнгөрснөөр дуусгавар болно. Худалдааны үйл ажиллагааны шилжүүлэл хүчинтэй болсон өдрөөс 20 жил өнгөрвөл мөн адил байна. 18².3 Шилжүүлэн өгсөн этгээдийг дампууруулах ажиллагаа эхлүүлэх шийдвэр гарсан эсвэл дахин хөрөнгөжүүлэх шийдвэр гарсан бол өмнөх үүрэг гүйцэтгүүлэгч нь шилжүүлэн авсан этгээдмйн эсрэг 1 дэх заалтын дагуу шаардлага гаргах эрхээ хэрэгжүүлэх боломжгүй.
4	Вьетнам	Худалдааны хуулинд тодорхой зохицуулалт байхгүй.

Худалдааны үйл ажиллагааг шилжүүлэхэд үүсдэг гол асуудал нь худалдааны үйл ажиллагааг шилжүүлсэн этгээд шилжүүлэн авсан этгээдийг өрсөлдөхийг хязгарлах явдал байдаг.

3.7 ХУДАЛДААНЫ АЖИЛТАН

Худалдаа эрхлэгч нь аж ахуйн үйл ажиллагаагаа явуулахад олон тооны хүний нөөц шаардлагатай болох бөгөөд ажилтанууд дундаасаа өөрийг нь төлөөлөх эрх бүхий этгээдийг томиолж ажиллуулах шаардлагатай болдог. Худалдаа эрхлэгчийн худалдааны үйл ажиллагаанд тусалж буй этгээдийг томоор нь дараах байдлаар 2 ангилж болох бөгөөд худалдааны ажилтантай холбоотой дараах 4 төрлийн төлөөлөгчийн асуудал яригддаг байна.



№	Улс	Худалдааны хуулийн зохицуулалтын агуулга
1	ХБНГУ	§ 48 [Прокура олгох, нэгдсэн прокура] (1) Худалдааны төлөөллийг гагцхүү арилжаа эрхлэгч эсвэл түүний хууль ёсны төлөөлөгч олгох ба ингэхдээ бодитоор хүсэл зоригоо илэрхийлсэн

		байх ёстой. (2) Худалдааны бүрэн эрхт төлөөллийг хэд хэдэн этгээдэд (нэгдсэн прокура) олгож болно. § 53 [Бүрэн эрх олгосон, хүчингүй болгосон тухай бүртгүүлэх] (1) 1Арилжаа эрхлэгч нь прокура олгосон тухайгаа бүртгэлд мэдэгдэнэ. Үүнийг нэгдсэн хэлбэрээр олгосон бол дээрхийн нэгэн адил бүртгүүлнэ. § 54 [Итгэмжлэлээр төлөөлөх бүрэн эрх олгох] (1) Прокура олгоогүй ч худалдааны үйл ажиллагааг эрхлэх, үүнд хамаарах тодорхой төрлийн хэлцлүүд эсвэл тодорхой үйлдэл хийх зорилгоор төлөөлөх бүрэн эрх олгосон бол энэхүү бүрэн эрх нь тухайн бизнесийн үйл ажиллагааг явуулах эсвэл тухайн хэлцлийг хийхэд шаардлагатай бүх эрх зүйн үйл хөдлөлийг хамарна. (2) Бүрэн эрх бүхий төлөөлөгч нь гагцхүү тухайлан заасан нөхцөлд л үл хөдлөх хөрөнгө захиран зарцуулах, барьцаалах, векселийн үүрэг хүлээх, зээл авах, шүүхэд хандах эрхтэй байна. (3) Төлөөлөх бүрэн эрхийг дээрхээс бусад тохиолдолд хязгаарласан бол энэ талаар мэдэж байсан эсвэл мэдвэл зохих нөхцөлд л гуравдагч этгээдийн эсрэг үйлчилнэ.
2	Япон	20.1 Худалдаа эрхлэгч нь итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээдийг томилж, худалдааны үйл ажиллагааг эрхлүүлж болно. 21.1 Итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээд худалдаа эрхлэгчийг төлөөлөн тухайн худалдааны үйл ажиллагаатай холбогдох бүхийл шүүх дэх болон шүүхээс гадуур хэлцлийг хийх бүрэн эрхтэй байна. 21.2 Итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээд нь бусад ажилтныг томилох, чөлөөлөх эрхтэй байна. 21.3 Итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээдийн төлөөлөх бүрэн эрхийг хязгаарласан нь үүнийг мэдээгүй гуравдагч этгээдэдийн эсрэг ашиглагдахгүй. 22.1 Худалдаа эрхлэгч нь итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээдийг томилсон бол бүртгүүлэх ёстой. Итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээдийн төлөөлөх бүрэн эрх дуусгавар болсон үед мөн адил байна. 23.1 Итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээдэд худалдаа эрхлэгч зөвшөөрөөгүй бол дараах үйлдлийг хийхийг хориглоно. 23.1.1 Өөрийн худалдааны үйл ажиллагаа эрхлэх 23.1.2 Өөрийн болон гуравдагчийн төлөө худалдаа эрхлэгчийн худалдааны үйл ажиллагаанд хамаарах худалдаа эрхлэх 23.1.3 Бусад худалдаа эрхлэгч, компани, гадаад компанийн ажилтан болох 23.1.4 Компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, болон ажил үүргийг хэрэгжүүлэх гишүүн болох 23.2 Итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээд нь өмнөх заалтын зохицуулалтыг зөрчиж тус заалтын 2 дахт дугаарт заасан үйлдлийг хийсэн бол тухайн үйлдлийн улмаас итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээд болон гуравдагч этгээд олсон ашгийн мөнгөн дүнг худалдаа эрхлэгчид учирсан хохирол гэж тооцно. 24.1 Худалдаа эрхлэгчийн худалдааны үйл ажилалгааг гол хариуцаж

		этгээд гэж харагдах нэршил хэрэглэж буй ажилтан нь тухайн худалдааны үйл ажиллагаатай холбоотой бүхий л шүүхээс гадуур хэлцлийг хийх эрх бүхий этгээд гэж үзэгдэнэ. Гэхдээ харилцагч тал төлөөлөх эрхгүй тухай мэдэж байсан бол энэ заалт үйлчлэхгүй. 25.1 Худалдаа эрхлэгч худалдааны үйл ажиллагаанд холбогдох тодорхой төрлийн болон тодорхой асуудлаар итгэмжлэл олгогдсон ажилтан нь тухайн асуудалтай холбоотой бүхий л шүүхээс гадуурх үйлдлийг хийх эрх хэмжээтэй байна. 25.2 Өмнөх заалтад дурдсан ажилтны төлөөлөх эрх хэмжээг хязгаарласан нь үүнийг мэдээгүй гурагдагч этгээдийн эсрэг ашиглагдахгүй. 26.1 Бараа, бүтээгдэхүүний худалдаа эрхлэх зорилго бүхий дэлгүүрийн ажилтан нь тухайн дэлгүүрт байгаа бараа, бүтээгдэхүүнийг худалдаалах эрх хэмжээтэй гэж үзэгдэнэ. Гэхдээ харилцагч этгээд нь түүнийг төлөөлөх эрхгүй тухай мэдэж байсан бол энэ заалт үйлчлэхгүй.
4	Вьетнам	Тодорхой зохицуулалт байхгүй

Манай улсын Иргэний хуулийн 29-р зүйлийн 29.5 дахь хэсэгт “Салбар, төлөөлөгчийн газрын **эрх баригчид** үйл ажиллагаагаа хуулийн этгээдээс олгосон итгэмжлэлийн үндсэн дээр явуулна”, 64-р зүйлийн 64.2.1 дэх хэсэгт “итгэмжлэлд төлөөлүүлэгч гарын үсэг зурсан байх, хуулийн этгээдийн итгэмжлэлд **эрх баригч** гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарсан байх” гэх мэтчилэн эрх баригч гэх ойлголтыг хуульчилж өгсөн байна.

Мөн Компанийн тухай хуулиар гүйцэтгэх удирдлага нь итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй байдаг.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХУДАЛДААНЫ ХЭЛЦЭЛ

Эндээс худалдааны хэлцлийг дараах байдлаар ангилж буйг харж болно.

№	АЖ АХУЙН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛГОЖ БУЙ ХЭЛЦЭЛ /act as its business/ 営業としてする行為		АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫХАА ТӨЛӨӨ ХИЙЖ БУЙ ХЭЛЦЭЛ /act for its business/ 営業のためにする行為
	Худалдааны үндсэн хэлцэл(基本的商行為)	Худалдааны бус хэлцэл(非商行為・民事行為)	Дагалдах худалдааны хэлцэл(付属的商行為)
1	Объектив худалдааны хэлцэл	Иргэний эрх зүйн хэлцэл	Худалдааны үндсэн хэлцлээс гадна худалдааны үйл ажиллагааг дэмжих, туслах чанартай иргэний эрх зүйн хэлцлүүд хамаарна.
2	Аж ахуйн шинжтэй худалдааны хэлцэл		

Ийнхүү хэлцлийг аж ахуйн үндсэн үйл ажиллагаа болгож буй болон аж ахуйн үйл ажиллагааныхаа төлөө хийж буй гэж ангилах ба аж ахуйн үндсэн үйл ажиллагаа болгож буй хэлцэл нь худалдааны үндсэн хэлцэл болон худалдааны бус хэлцэл гэж ангилагддаг. Худалдааны хэлцэл нь объектив худалдааны хэлцэл, аж ахуйн шинжтэй худалдааны хэлцэл, дагалдах худалдааны хэлцэл гэсэн үндсэн 3 төрөлд ангиллагддаг. Эхлээд объектив худалдааны хэлцэлийн талаар дэлгэрүүлж авч үзье. Объектив худалдааны хэлцэлийн үндсэн шинж нь дээр дурдсанчлан худалдаачин эсэхээс үл хамааран уг хэлцэлийг хийж буй этгээдэд Худалдааны хууль хэрэглэгдэнэ.

№	ХУДАЛДААН Ы ХЭЛЦЭЛ	ХУДАЛДААНЫ ХУУЛИЙН ЗААЛТ	ТУХАЙЛБАЛ
1	Объектив худалдааны хэлцэл 絶対的商行為	§501.1.Ашиг олж дамжуулан худалдах хүсэл зорилготойгоор ¹¹ хөдлөх хөрөнгө, үл хөдлөх хөрөнгө түүнчлэн үнэт цаасыг төлбөртэйгөөр олж авах эсхүл олж авсан зүйлээ дамжуулан худалдахаар хийж буй хэлцэл 投機購買	Жижиглэн худалдаа, Бөөний худалдаа, Үйлдвэрлэл, Угсралт, Үйлдвэрлэгчийн түүхий эдийн худалдан авалт
		§501.2.Бусдаас худалдан авах хөдлөх хөрөнгө эсхүл үнэт цаасыг ханган нийлүүлэх гэрээ ¹² болон түүний гүйцэтгэлийг хангах зорилгоор төлбөртэйгөөр гэрээний зүйлийг олж авах хэлцэл 投機売却	Ирээдүйд эд хөрөнгө худалдан авах, Захиалгат худалдаа
		§501.3.Бирж дээр хийгдэх худалдаа 取引所でする取引	Үнэт цаасны арилжаа ¹³ Бүтээгдэхүүний арилжаа ¹⁴
		§501.4.Вексель зэрэг бусад арилжааны үнэт цаастай холбогдох хэлцэл 手形など商業証券に関する行為	Үнэт цаас олгох, Үнэт цаасыг шилжүүлэх, Үүрэг гүйцэтгэгч болохоо батлах гэх мэт

¹¹ 投機- SPECULATION - Тодорхой хөрөнгийг үнэ буурсан үед нь худалдан авч, үнэ нь өсөхөөр худалдан үнийн зөрүүнээс ашиг олохыг зорьж буй үйлдэл. Энэ нь 投資 - INVESTMENT - аж ахуйн нэгжийн ирээдүйд олох ашгийн төлөө түүний байгууламж болон технологид хөрөнгө оруулахаас ялгагддаг байна. Харин хөдөө аж ахуй, далайн гаралтай түүхий эд, ургамал бэлтгэн, эсвэл ашигт малтмал олборлон худалдаж буй хэлцэл нь төлбөртэйгөөр олж авсан зүйлээс дамжуулан худалдаж буй гэсэн шинж байхгүй тул худалдааны хэлцэлд хамаарахгүй.

¹² Нийлүүлэлтийн гэрээ (供給契約)- Гэрээ байгуулсны дараа тодорхой хугацаанд гэрээний зүйлийн өмчлөх эрх шилжүүлэх гэсэн агуулгатай хариу төлбөртэй гэрээг хэлнэ.

¹³ 金融商品取引法 - Financial Instruments and Exchange Act – 1948 онд батлагдсан Үнэт цаасны арилжааны хууль 2007 оны нэмэлт өөрчлөлтөөр нэр нь өөрчлөгдөн Санхүүгийн бүтээгдэхүүний арилжааны хууль болжээ.

¹⁴ 商品先物取引法 - Commodity Derivatives Act – 1950 онд батлагдсан Бүтээгдэхүүний биржийн хууль/ Commodity Exchange Act / нь 2009 онд нэрээ өөрчлөн Бүтээгдэхүүний деривативын арилжааны хууль болсон.

Япон улсын худалдааны хуульд эдгээр хэлцэлийг яагаад объектив худалдааны хэлцэл гэж авч үзсэн бэ гэдгийг тодруулахын тулд дундад зуунд Европд худалдааны эрх зүй үүсч хөгжсөн үеийг авч үзэх шаардалгатай болдог. Тухайн үеийн Европын нийгэм газар тариалангийн үйлдвэрлэл дээр тогтож байсан бөгөөд энэ үед тухайн үеийг хүртлэх нийгмээс ялгагдах нэгэн онцлог бий болсон нь газар тариалангийн үйлдвэрлэлд технологийн дэвшил гарсантай холбоотойгоор газар тариалангийн үйлдвэрлэл харьцангуй тогтворжиж ирсэн ба тодорхой хэмжээнд илүүдэл гарах болж, уг илүүдэлийг худалдан борлуулах үйл ажиллагаа бий болсон нь тухайн үеийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндэс болжээ¹⁵. Энгээд уг төрлийн худалдан борлуулах үйл ажиллагаа явагдаж эхэлснээр газар тариалангийн үйлвэрлэлийн бүтээгдэхүүн гэлтгүй олон төрлийн бүтээгдэхүүн худалдан борлуулагдах болж бараа таваарын гүйлгээн/эргэлт/-д оролцох (財貨の流通媒介) үйл ажиллагаа нийгэмд төлөвшин, илүүдэл үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний гүйлгээнд байнгын оролцож буй этгээд болох худалдаачид нь нийгмийн нэг давхаргыг бүрдүүлэх болжээ¹⁶.

Бараа таваарын гүйлгээн/эргэлт/-д оролцох гэдэг нь эд барааг бусдаас хямдаар худалдан авч өндөр үнэтэй борлуулах юм¹⁷. Энэ нь 501-р зүйлд заасан объектив худалдааны хэлцэлтэй агуулга нэг юм. Худалдааны хууль дахь худалдах худалдан авах гэрээ нь Иргэний хуульд заасан худалдах худалдан авах гэрээнээс ялгагдах онцлог нь худалдан авсан эд зүйлээ дахин худалдан борлуулах заамаар ашиг олох явдал бөгөөд уг шинж тус хэлцэл объектив байдлаар ашгийн төлөөх хэлцэл болохыг нь харуулдаг. Энэ нь дундад зууны Европын нийгэм дэх хүмүүсийн ойлголтод ашиг олох явдал нь бараа таваарын гүйлгээнд оролцох гэж ойлгож байснаас эхтэй билээ¹⁸.

Худалдааны хуулийн §501.1 болон §501.2-ын гол ялгаа бол §501.1 нь төлбөртэйгөөр гэрээний зүйлийг олж аваад дамлан худалддаг бол, §501.2 нь эхлээд тодорхой бараа таваарыг ханган нийлүүлэхээр тохироод, дараа нь тухайн ханган нийлүүлэх гэж буй зүйлээ төлбөртэйгөөр олж авдагт байдаг. Өөрөөр хэлбэл бараа таваарыг худалдах болон худалдан авах дараалал нь өөр төдий билээ.


Энд тухайлбал Худалдааны хуулийн 501-р зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг авч үзвэл худалдаачин нь ашиг олохын тулд 2 төрлийн хэлцэл хийх шаардлагатай болж буйг анхаарах хэрэгтэй.

¹⁵ 大塚 英明ほか『商法総則・商行為法』7頁(有斐閣アルマ、第2版、2008年)

¹⁶ Мөн тэнд.

¹⁷ 大塚 英明ほか『商法総則・商行為法』11頁(有斐閣アルマ、第2版、2008年)

¹⁸ Мөн тэнд.



Дээрх хүснэгтэд дурдсан худалдан авах болон худалдан борлуулах хэлцэл аль аль нь Худалдааны хуульд заасан худалдах худалдан авах гэрээ болно. Үүний дараагаар аж ахуйн шинжтэй худалдааны хэлцэлийн талаар авч үзье. Бараа таваарын гүйлгээнд оролцохоос гадна бараа таваарын эргэлтийг дэмжих, туслах чиг үүрэг бүхий үйл ажиллагаанаас мөн ашиг олох болж худалдааны хэлцэлийн хүрээ өргөжсөн байна.

Худалдааны хуулийн 502-р зүйлийн 1 дэх хэсэгт “Дор дурдсан хэлцэлийг аж ахуйн үндсэн үйл ажиллагаа болгон хийх тохиолдолд худалдааны хэлцэл болно. Харин зөвхөн цалин хөлс олох зорилгоор эд зүйлийг үйлдвэрлэх, эсвэл ажил үүрэг гүйцэтгэж буй этгээдийн үйлдэлд энэ хамаарахгүй” гэж хуульчилжээ.

№	ХУДАЛДААН Ы ХЭЛЦЭЛ	ХУДАЛДААНЫ ХУУЛИЙН ЗААЛТ	ТУХАЙЛБАЛ
1	Аж ахуйн шинжтэй худалдааны хэлцэл 営業的商行為	§502.1.1.Түрээслүүлэх хүсэл зорилготойгоор хөдлөх хөрөнгө, үл хөдлөх хөрөнгийг төлбөртэйгөөр олж авах аль эсвэл түрээслэх, олж авсан аль эсвэл түрээсэлсэн зүйлээ түрээслүүлэх гэж буй хэлцэл	Барилга орон сууц, машин, ном, хувцас гэх мэт төрөл бүрийн эд хөрөнгө хөлслөх түрээслэх арилжаа
		§502.1.2.Бусдад хийж өгч буй үйлдвэрлэл эсхүл угсралт холбоотой хэлцэл	Харилцагч этгээдээсээ түүхий эд авах эсвэл зардлыг нь гаргуулах байдлаар цэвэрлэгээ, захиалгаар үйлдвэрлэл явуулах гэх мэт ¹⁹
		§502.1.3.Цахилгаан болон хий нийлүүлэхтэй холбогдох	Цахилгаан нийлүүлэх ²⁰ Хий нийлүүлэх ²¹

¹⁹ Үйлдвэрлэл эсхүл угсралт хийснийхээ хариуд авах төлбөрийг зорилгоо болгоно.

²⁰電気事業法- Electricity Business Act – 1964 онд батлагдсан Цахилгаан түгээх үйл ажиллагааны хуулиар нэмэлт зохицуулалт хийгддэг.

²¹ガス事業法- Gas Business Act – 1954 онд батлагдсан Шатах хий түгээх үйл ажиллагааны хуулиар мөн нэмэлт зохицуулалт хийгддэг.

	хэлцэл	
	§502.1.4.Тээвэрлэлттэй холбоотой хэлцэл	Хүн болон ачааг хуурай замын, агаарын, усан буюу далайгаар тээвэрлэлт хийх
	§502.1.5.Ажил гүйцэтгэх болон ажилтан илгээх	Газар шорооны ажил гүйцэтгэх, Барилга барих, Усан онгоц барих гэх мэт, Ажилтан илээх ²²
	§502.1.6.Хэвлэл, мэдээлэл, зураг авахтай холбогдох хэлцэл	Бүх төрлийн хэвлэлийн үйл ажиллагаа
	§502.1.7.Зочид цуглуулах зорилготой үзвэр, үйлчилгээ	Зочид буудал, театр, хоолны болон цэнгээний газар, гоо сайхны, нийтийн халуун усны газар, тоглоомын парк, спортын талбай гэх мэт олон тооны хүн цугларч үзвэр, үйлчилгээ авах боломжтой газар ажиллуулах
	§502.1.8.Вальют арилжаа зэрэг банкны явуулах арилжаа	Зээлийн болон мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа явуулдаг банк байх шаардлагатай ба барьцаалан зээлдүүлэх болон банк бус санхүүгийн үйл ажиллагаа явуулдаг этгээдийн үйл ажиллагаа үүнд хамаарахгүй.
	§502.1.9. Даатгал	Амь насны болон хохирлын даатгалын үйл ажиллагаа ²³ явуулдаг хувьцаат компани хамаарна. Харин нийгмийн даатгал, харилцан даатгалын ²⁴ үйл ажиллагаа хамаарахгүй.
	§502.1.10.Хадгалалтын үйл ажиллагаа эрхлэх	Бусдын эд хөрөнгийг хадгалах үйл ажиллагаа
	§502.1.11.Зуучлал болон комиссын үйл ажиллагаатай холбогдох хэлцэл	Худалдааны зуучлал болон комиссын үйл ажиллагаа

²²労働者派遣事業法- Manpower Dispatching Business Act / 労働者派遣事業の適正な運営の確保及び派遣労働者の就業条件の整備等に関する法律- Act for Securing the Proper Operation of Worker Dispatching Undertakings and Improved Working Conditions for Dispatched Workers / - 1985 онд батлагдсан Ажилтан илгээх хуулиар мөн нэмэлт зохицуулалт хийгддэг.

²³保険法- Insurance Act- 2008 онд өмнөх Худалдааны хуулиар зохицуулагдаж байсан даатгалын харилцааг бие даасан хууль болгон шинэчлэн найруулсан.

²⁴相互保険 - mutual insurance- Даатгалын хамрагдсан этгээдийг гишүүнээ болгож гишүүдээсээ бүрдэх даатгалын компани байгуулж гишүүддээ зориулж даатгалын үйл ажиллагаа явуулдаг даатгалын хэлбэр. 保険業法 - Insurance Business Act – 1939 онд батлагдан, 1995 онд шинэчилсэн найруулга хийгдсэн хуулиар зохицуулагддаг.

	§502.1.12.Худалдааны хэлцэлд төлөөлөх үйл ажиллагаа эрхлэх	Худалдааны төлөөллийн үйл ажиллагаа
	§502.1.13.Хөрөнгө итгэмжлэх үйл ажиллагаа эрхлэх	Хөрөнгө итгэмжлэх үйл ажиллагаа ²⁵

Дээрх хүснэгтэд аж ахуйн шинжтэй худалдааны хэлцэлийг жагсаалтын зарчмын дагуу хязгаарлагдмал хүрээнд тодорхойлсон байх бөгөөд яагаад эдгээр хэлцэлийг аж ахуйн шинжтэй худалдааны хэлцэл гэж үзсэн бэ? гэсэн асуулт гарч ирнэ.

Өргөн уудам нутаг дэвсгэрийн хүрээнд бараа таваарын арилжаа хийгдэхтэй зэрэгцэн нэн тэргүүнд бодитоор тулгарах асуудал нь төлбөр тооцооны хэрэгсэл болон хэл ярианы ялгаатай байдал юм.

Төлбөр тооцооны ялгаатай байдлыг даван туулах арга зам нь валют солих үйл ажиллагаа байсан бөгөөд уг үйл ажиллагааны хүрээнд аажмаар мөнгөний хуримтлал бий болж, банкны үйл ажиллагааны (§502.1.8) эх үндсийг тавьжээ.

Хэлний бэрхшээлийг шийдвэрлэх арга зам нь орчуулагч, төлөөлөгч оролцуулан арилжааг хийх байсан бөгөөд эдгээр этгээдүүд нь яваандаа мэргэжлийн хэлцэл хийх чадвартай этгээдүүд болж ирсэн ба бараа таваарын арилжаанд зуучлалын үйл ажиллагаа гүйцэтгэдэг этгээд (§502.1.12) нь ийнхүү бие даан ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах болжээ.

Түүнчлэн бараа таваарын эргэлт явагдахыг дагалдан бараа таваарыг тээвэрлэх (§502.1.4), хадгалах үйл ажиллагаа (§502.1.10), бараа таваарыг худалдан авах, борлуулах ажиллагааг хөнгөвчлөх худалдааны комиссын үйл ажиллагаа (§502.1.11), бараа таваар аливаа эрсдэлийн улмаас үнэ цэнээ алдахаас урьдчилан сэргийлэх даатгалын үйл ажиллагаа (§502.1.9) зэрэг төрөл бүрийн үйл ажиллагаа бий болон, бараа таваарын гүйлгээнд оролцох явдлыг дэмжих орчныг бүрдүүлэн, эдгээр нь бие даасан ашгийн төлөөх үйл ажиллагаа болон явагдах болжээ²⁶.

Гэхдээ зөвхөн бараа таваарын гүйлгээтэй холбон худалдааны эрх зүйн харилцааг тайлбарлах нь өнөө үед хэт явцуурсан хандлага болох билээ. Зөвхөн бараа таваарын гүйлгээ гэлтгүйгээр өөр төрлийн үйл ажиллагаа явуулсан ч гол нь яаж хийхээсээ хамаараад ашиг олох боломжтой юм. Өөрөөр хэлбэл объектив байдлаар өөртөө ашгийн төлөөх шинж агуулсан хэлцэл биш ч аж ахуйн зохион байгуулалтаар аливаа хэлцлийг хийвэл ямар ч хэлцэл худалдааны хэлцэл болох боломжтой гэж орчин үед үзэх болжээ.

Тухайлбал Худалдааны хуулийн §502.1.3-т зааснаар цахилгаан болон хий нийлүүлэхтэй холбогдох хэлцэл нь Худалдааны хуулийн §501.2-т заасан бэлтгэн нийлүүлэх гэрээнээс тусдаа аж ахуйн шинжтэй худалдааны хэлцэл байхаар хуульчилсан. Учир нь цахилгаан болон хий нийлүүлэгч нь бусдаас худалдан авч дамжуулан худалдах гэхээсээ ихэнх тохиолдолд өөрсдийн үйлдвэрлэсэн зүйлээ худалдаж буй тул объектив худалдааны хэлцэл болохгүй юм. Хэдийгээр объектив худалдааны хэлцэл биш ч дахин давтан, тогтвортой байдлаар аж ахуйн зохион байгуулалтаар хийж буй тул худалдааны хэлцэлд хамааруулсан байна.

²⁵信託業法- Trust Business Act - 1922 онд батлагдаж 2004 онд шинэчилсэн найруулга хийгдсэн Хөрөнгө итгэмжлэх үйл ажиллагааны тухай хуулиар мөн нэмэлт зохицуулалт үйлчилдэг.

²⁶大塚 英明ほか『商法総則・商行為法』12頁(有斐閣アルマ、第2版、2008年)

Мөн Худалдааны хуулийн §502.1.2-т зааснаар бусдад хийж өгч буй үйлдвэрлэл эсхүл угсралттай холбоотой хэлцэл нь аж ахуйн шинжтэй худалдааны хэлцэл байхаар хуульчилсан. Бусдаас түүхий эд, материал худалдан авч бүтэгдэхүүн үйлдвэрлэн худалдан борлуулж буй хэлцэл нь угаас Худалдааны хуулийн §501.1-т заасан хэлцэлд хамаардаг. Харин харилцагч этгээдээсээ түүхий эд авах эсвэл зардлыг нь гаргуулах байдлаар үйлдвэрлэл, засвар, усралт явуулах нь өмнө дурдсан объектив худалдааны хэлцэлд хамаарахгүй ч, тухайн харилцагчаас авсан эд зүйл дээрээ нэмэлт үнэ цэнийг бий болгох, үүнийгээ байнга, тогтвортой эрхлэх замаар ашиг олохыг зорьж буй тул аж ахуйн шинжтэй худалдааны хэлцэл болдог. Уг худалдааны хэлцэлийн хувьд объектив худалдааны хэлцэлээс ялгагдаж буй бас нэг онцлог бол хэлцэлийн зүйл нь биет бараа таваар бус “нэмэлт үнэ цэнэ” гэсэн биет бус зүйлийг объект болгодгоороо уламжлалт худалдааны хэлцэлийн ойлголтын хүрээг өргөжүүлжээ. Мөн Худалдааны хуулийн §502.1.6-т заасан хэлцэлийн зүйл нь биет бус зүйл болох мэдээлэл бөгөөд уламжлалт худалдааны хэлцэлийн зүйлээс эрс ялгаатай байв. Бас Худалдааны хуулийн §502.1.7-т заасан зочид цуглуулан үзвэр, үйлчилгээ үзүүлэн ашиг олох зорилготой хэлцэл нь мөн шинж чанар, гэрээний зүйлийн хувьд уламжлалт худалдааны хэлцлээс ялгаатай.

Энэ нь тодорхой маргааныг бий болгосон бөгөөд хэн худалдаачин бэ? гэдгийг тодорхойлохын тулд заавал тодорхой худалдааны үйл ажиллагааг жагсаан, уг үйл ажиллагааг явуулж буй этгээдийг худалдаачин гэж үзэх нь цаг үетэй нийцээгүй хоцрогдмол арга гэсэн шүүмж гарах болсон байна. Учир дунд зууны Европ болон аж үйлдвэрийн хувьсгал дараах орчин үеийн нийгэм эрс ялгаатай бөгөөд өнөө цаг үед ашиг олох явдлыг тодорхой нэг худалдааны үйл ажиллагаатай холбож ойлгох шаардалгагүй болсон бөгөөд ямар үйл ажиллагаа явуулсан ч аж ахуйн зохин байгуулалтаар явуулвал ашиг олох боломжтой тул жагсаалтын зарчмыг баримтлах шаардалаггүй гэж үзэх болжээ. Үүний дараагаар дагалдах худалдааны хэлцлийн талаар авч үзье. Аж ахуйн үндсэн үйл ажиллагаа болгож биш, аж ахуйн үйл ажиллагааныхаа төлөө хийж буй хэлцэл яагаад худалдааны хэлцэл болсон дараах шатгаантай байдаг. Худалдаачин төдийгүй худалдааны харилцаанд оролцож буй эсрэг тал нь өөрсдийнх нь хийж буй хэлцэлд худалдааны хэлцэлийн эрх зүйн хэм хэмжээ үйлчлэх нь тодорхой болох бөгөөд хууль зүйн тогтвортой байдал хангагдана гэж үздэг.

№	ХУДАЛДААН Ы ХЭЛЦЭЛ	ХУДАЛДААНЫ ХУУЛИЙН ЗААЛТ	ТУХАЙЛБАЛ
1	Дагалдах худалдааны хэлцэл 付随的商行為	Жагсаалтын зарчим хэрэглээгүй. §503.1.Худалдаачны бизнесийнхээ төлөө хийж буй хэлцэл нь худалдааны хэлцэл болно. §503.2.Худалдаачны хийж буй хэлцэл нь бизнесийн төлөө хийж буй хэлцэл гэж тооцогдоно.	Хөрөнгө оруулах зорилгоор зээл авах, ажилчидтай хөдөлмөрийн гэрээ байгуулах, зар сурталчилгааны гэрээ, ажлын байр түрээслэх гэх мэт гэрээнээс гадна бизнес эхлүүлэх бэлтгэл үе шатанд хийгдэх гэрээ мөн энэ төрөлд хамаарна.

Япон улсын худалдааны хуульд тодорхой төрлийн гэрээнүүдийн зохицуулалт хийж өгсөн хэдий ч үүгээр гэрээний төрлийн хүрээ хязгаарлагдахгүй. Өөрөөр хэлбэл худалдааны хуульд тусгагдаагүй байсан ч гэрээ нь худалдааны гэрээ болох боломжтой.

Үүний дараагаар Худалдааны хуулийг хэрэглэхэд талууд бүгд худалдаачин байхыг шаардах уу гэх асуулт тавигддаг.

ХУДАЛДААНЫ ГЭРЭЭНИЙ АНГИЛАЛ	
Хоёр талын худалдааны гэрээ 双方的商行為	Нэг талын худалдааны гэрээ 一方的商行為
Гэрээний талууд аль аль нь худалдаачин байх тохиолдол	Гэрээний нэг тал нь худалдаачин, нөгөө тал нь худалдаачин бус этгээд байх тохиолдол
Гэрээний чөлөөт байдлын зарчим өргөн хүрээнд үйлчилж, төрийн оролцоо хамгийн бага түвшинд байна.	Гэрээний чөлөөт байдлын зарчим тодорхой хэмжээнд хязгаарлагдаж төрийн оролцоо нэмэгдэнэ.
§3.1.Талуудын нэг талд худалдааны хэлцэл болж байгаа хэлцлийн хувьд энэ хууль хоёр талын хоёуланд нь үйлчилнэ.	

Худалдааны хуулийн §3.1-т зааснаар нэг талын худалдааны гэрээнд ч худалдааны хууль хэрэглэгдэхээр байна. Өөрөөр хэлбэл худалдааны хуулийг хэрэглэхэд хоёр тал нь хоёулаа худалдаачин байхыг шаардахгүй бөгөөд зөвхөн нэг тал нь худалдаачин байхад худалдааны хуулийг хэрэглэх үндэслэл бүрэлдэнэ. Мөн Худалдааны хуулийн §3.2-т “Талуудын нэг тал нь 2-оос дээш этгээд байх тохиолдолд тэдгээрийн нэгийнхэн хувьд худалдааны хэлцэл болж байгаа бол энэ хууль нь бүгдэд нь үйлчилнэ” гэж зааснаар гэрээнд оролцогч талууд дунд нэг худалдаачин байхад л худалдааны хуулийг хэрэглэх нөхцөл бүрэлдэнэ. Түүнчлэн тус хуулийн §2.1-т Нийтийн эрх зүйн хуулийн этгээд/公法人/-ийн хийх худалдааны хэлцэлд хуульд өөрөөр заагаагүй бол худалдааны хуулийг хэрэглэхээр зохицуулжээ.

4.1 ХУДАЛДААНЫ ХЭЛЦЛИЙН ЕРӨНХИЙ ЗОХИЦУУЛАЛТ

Худалдааны хуулийн §504-р зүйлээс §522-р зүйл хүртэл худалдааны хэлцлийн ерөнхий зохицуулалт тусгагдсан байдаг.

Эхлээд гэрээ байгуулагдах харилцаа буюу гэрээний санал, түүний хариутай холбогдох харилцааг худалдааны хуулиар зохицуулж буй онцлогийг авч үзье. Энэ талаар Худалдааны хуулийн §507, §508, §509, §510-р зүйлүүдэд зааж өгчээ.

№	ГЭРЭЭ БАЙГУУЛАХ САНАЛ		ХУДАЛДААНЫ ХУУЛЬ	ИРГЭНИЙ ХУУЛЬ
1	Шууд харилцаж байгаа талууд 対話者間	Хугацаа заагаагүй гэрээ байгуулах санал	§507.1.Худалдаачин болох шууд харилцаж буй талуудын хувьд гэрээ байгуулах саналыг хүлээн авсан тал нэн даруй хүлээн зөвшөөрөөгүй бол гэрээний санал хүчингүй болно. <i>(Худалдааны хууль)</i> ※Иргэний хуульд энэ талаар зохицуулалт байхгүй боловч иргэний хуулийн тайлбараар шууд харилцаж байгаа талууд хугацаа заагаагүй гэрээний саналд нэн даруй хариу өгөөгүй бол гэрээ байгуулах санал хүчингүй болно гэж үздэг.	
		Хугацаатай гэрээ байгуулах санал	§521.1.Хариу ирүүлэх хугацаа заасан гэрээний саналаа буцаан авах боломжгүй. §521.2.Санал гаргагч нь өмнөх заалтад заасан гэрээний саналд заасан хугацаанд саналын хариуг хүлээн аваагүй бол санал хүчингүй болно. <i>(Иргэний хууль)</i>	

2	Хоорондоо зайтай байгаа талууд 隔地者間		§508.1.Худалдаачин болох хоорондоо зайтай байгаа талуудын хувьд гэрээний саналын хариуг ирүүлэх хугацаа заагаагүй гэрээний санал хүлээн авсан этгээд нь боломжит хугацааны дотор саналын хариугаа илгээгүй бол тухайн санал нь хүчингүй болно.	§524.1. Хариу ирүүлэх хугацаа заагаагүй хоорондоо зайтай байгаа этгээдэд гаргасан гэрээний саналаа санал гаргагч нь хариу хүлээн авах боломжит хугацаа өнгөртөл буцаан авах боломжгүй.
		Хугацаа заагаагүй гэрээ байгуулах санал		

Эндээс авч үзэхэд гэрээний саналыг хугацаа заасан, хугацаа заагаагүй гэж ангилах мөн шууд ярилцаж байгаа эсвэл хоорондоо зайтай байгаа талуудын гаргасан гэрээний санал гэсэн ангилал нь Худалдааны хууль болон Иргэний хуулийн зохицуулалтыг хэрэглэж, тайлбарлахад чухал ач холбогдолтой.

Иргэний хуульд Худалдааны хуулийн §507.1-тэй адил шууд харилцаж байгаа талуудын дунд гарсан хугацаа заагаагүй гэрээний саналын тухай зохицуулалт байхгүй. Худалдааны хуулийн §507.1 нь зөвхөн хоёр талын худалдааны гэрээнд үйлчлэх буюу гэрээний талууд аль аль нь худалдаачин байх шаардлага тавигдаж байна. Мөн хугацаа заагаагүй гэрээний саналд л хэрэглэгдэх бөгөөд хугацаа заасан бол Иргэний хуулийн §521-р зүйл хэрэглэгдэнэ. Энэ заалт нь худалдаачдын хооронд хийгдэх хэлцэл хурдан шуурхай байх шаардлагын үүднээс тайлбарлагдах боловч иргэний эрх зүйн хэлцэлд мөн шууд харилцаж байгаа талуудын дунд гарсан хугацаа заагаагүй гэрээний саналыг нэн даруй хүлээн зөвшөөрөөгүй бол гэрээний санал хүчингүй болно гэж тайлбарладаг тул энэ заалтын оршин байх ач холбогдол буурчээ.

Харин Худалдааны хуулийн §508.1-ийг Иргэний хуулийн 524.1-тэй харьцуулахад худалдаачдын хооронд хийгдэх хэлцэл хурдан шуурхай байх шаардлагыг хангах зорилготой байна. Эдгээр зохицуулалтын аль аль нь гэрээний саналын хариуг ирүүлэх хугацаа заагаагүй гэрээний саналд хэрэглэгдэх зохицуулалтууд болно. Иргэний хуулийн 524.1-ийн хувьд боломжит хугацаа өнгөрсний дараа гэрээний саналаа буцаан авч байж гэрээний санал хүчингүй болдог бол Худалдааны хуулийн §508.1 нь боломжит хугацааны дотор эсрэг талаас хүлээн зөвшөөрсөн хариу өгөөгүй тохиолдолд гэрээний санал шууд хүчингүй болдог тул хурдан шуурхай байх чанар илүү хангагдаж байна.

Монгол Улсын Иргэний хуультай харьцуулбал Худалдааны хуулийн §507.1-г МУ-ын Иргэний хуулийн §196.1.5-ийн сөрөг тайлбартай, Худалдааны хуулийн §508.1-г МУ-ын Иргэний хуулийн §196.1.4-ийн сөрөг тайлбартай дүйцүүлж болохоор байна.

Гэхдээ Япон улсын хувьд хүсэл зоригийн илэрхийлэл хэдийнээс хүчин төгөлдөр болох талаар хоёр өөр онолыг зэрэгцүүлэн ашигладаг. Энэ нь хүсэл зоригийн илэрхийлэлийг хүлээн авснаар эсвэл хүсэл зоригийн илэрхийлэлийг илгээсэнээр хүчин төгөлдөр болдог зарчим юм.

№	ХҮСЭЛ ЗОРИГИЙН ИЛЭРХИЙЛЭЛ ХҮЧИНТЭЙ БОЛОХ ҮЕ	ИРГЭНИЙ ХУУЛЬ	ТАЙЛБАР
---	---	---------------	---------

1	Хүсэл зоригийн илэрхийлэлийг хүлээн авснаар хүчинтэй болох 到達主義	Гэрээ байгуулах санал 申込み Бусад хүсэл зоригийн илэрхийлэл その他意思表示	§97.1 Хоорондоо зайтай байгаа этгээдэд хандсан хүсэл зоригийн илэрхийлэл нь тухай этгээд хүлээн авсан үеэс эхэлж хүчинтэй болно.	Гэрээ байгуулах саналаа өөрөө ямар нэгэн эрх зүйн харилцаа үүсгэх, өөрчлөхгүй тул илгээснээр хүчинтэй байх тогтолцоог хэрэглэх нь ач холбогдолгүй байна.
2	Хүсэл зоригийн илэрхийлэлийг илгээснээр хүчинтэй болох 発信主義	Гэрээ байгуулах саналын хариу 承諾	§526.1.Хоорондоо зайтай байгаа талуудын гэрээ нь хүлээн зөвшөөрсөн хариуг илгээсэн үеэс байгуулагдана.	Энэ заалтын дагуу саналын хариу илгээгч нь харилцагч этгээдэд хүрэхээс өмнө нь хүсэл зоригийн илэрхийллээ буцаан авах буюу татгалзах боломжгүй болж байгаа ч нөгөө талаас гэрээ байгуулагдсан гэдэгт баттай итгэх боломжтой болж ялангуяа худалдааны харилцаа хурдан шуурхай байх зарчимд нийцдэг байна.

Дээрх хүснэгтээс авч үзвэл ерөнхий тохиолдолд хүсэл зоригийн илэрхийлэл нь харилцагч тал хүлээн авсанаар хүчинтэй болох бөгөөд зөвхөн саналын хариуны хувьд илгээснээр хүчин төгөлдөр болдог тогтолцоог хэрэглэж байна. Гэхдээ Иргэний хуулийн §526.1 нь §521.2 хэрэглэгдэхгүй тохиолдол буюу гэрээ байгуулах саналд хугацаа заагаагүй тохиолдолд л хэрэглэгдэх зохицуулалт болохыг анхаарах хэрэгтэй. Түүнчлэн талууд хоорондоо зайтай байсан ч орчин үеийн технологийн дэвшлийн нөлөөгөөр харилцан холбогдоход цаг хугацааны зай улам бүр богиносж байгаа тул уг заалтын хэрэглээний ач холбогдол буурж хүсэл зоригийн илэрхийлэлийг хүлээн авснаар хүчинтэй болох тогтолцоо руу шилжих чиг хандлагатай байна. Монгол Улсын хувьд Иргэний хуулийн §40.1-т заасанчлан хүсэл зоригийн илэрхийлэл нь нөгөө тал түүнийг хүлээн авснаар хүчин төгөлдөр болох нь ерөнхий зарчим байна. Гэхдээ нөгөө талаас Монгол Улсын иргэний хуулийн §196.2-т ердийн боломжит хугацааны дотор “хариу явуулах” үүрэгтэй гэсэн нь хүсэл зоригийн илэрхийлэлийг илгээснээр хүчинтэй болох зарчмыг хэрэглэсэн байхыг үгүйсгэхгүй юм. Ингэснээр хэрвээ аж ахуй эрхлэгч нь зөвшөөрсөн санал илгээсэн бол нөгөө талд хүрэхээс өмнө татгалзах боломжгүй байдал үүсэх үр дагавартай. Үүнээс гадна дор авч үзсэний дагуу гэрээний саналыг хүлээн зөвшөөрөхтэй зохицуулалт худалдааны хуульд тусгагджээ.

№	ГЭРЭЭ БАЙГУУЛАХ САНАЛЫН ХАРИУ	ХУДАЛДААНЫ ХУУЛЬ	ИРГЭНИЙ ХУУЛЬ
1	Хүлээн зөвшөөрөх эсэх талаараа мэдэгдэх үүрэг	§509.1 Худалдаачин нь байнгын худалдааны харилцаатай байдаг этгээдээс тухайн төрлийн үйл	Гэрээний чөлөөт байдлын зарчмын үүднээс хүлээн авсан

	諾否通知義務	ажиллагаанд хамаарах гэрээ байгуулах саналыг хүлээн авсан бол хойшлуулалгүй гэрээ байгуулах саналыг хүлээн зөвшөөрөх эсэх тухай хариу илгээх үүрэгтэй. §509.2 Худалдаачин нь өмнөх заалтын үүргээ биелүүлээгүй тохиолдолд тухайн худалдаачин нь тус заалтын гэрээ байгуулах саналыг хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ.	санал бүрт хариу өгөх, түүнчлэн түүнийг заавал хүлээн зөвшөөрөх шаардлагагүй нь ойлгомжтой тул Иргэний хуульд тусгайлан хуульчлаагүй байна. Иргэний хуульд саналын хамт дагалдуулан илгээсэн эд зүйлийг хадгалах үүргийг хуульчлаагүй бөгөөд хэрэглэгчийн эрхийг хамгаалахад чиглэсэн хууль болох Тодорхой төрлийн худалдааны үйл ажиллагааны тухай хууль(特定商取引に関する法律)-ийн §59.1-т зааснаар эд зүйлийг хүлээн авсан этгээд 14 хоногийн дотор хүлээн зөвшөөрсөн хариу гаргаагүй, мөн борлуулалт хийж буй этгээд нь бүтээгдэхүүнээ буцаан аваагүй бол санал гаргагч нь эд зүйлээ буцаан шаардах эрхгүй болдог байна.
2	Гэрээний саналыг хүлээн хүлээн зөвшөөрөх үүрэг 承諾義務	Монополь үйл ажиллагаа явуулдаг этгээд бусдаас ирсэн гэрээ байгуулах саналыг хүлээн зөвшөөрөх үүргийг тодорхой хуулиудаар бий болгосон байна. Тухайлбал Цахилгаан түгээх үйл ажиллагааны хуулийн §18.1, Хий нийлүүлэх үйл ажиллагааны тухай хуулийн §16.1 гэх мэт	
3	Гэрээний саналын хамт дагалдуулан илгээсэн эд зүйлийг хадгалах үүрэг 送付物品保管義務	§510.1 Худалдаачин нь тухайн төрлийн үйл ажиллагаанд хамаарах гэрээ байгуулах саналыг хүлээн авсан бол тухайн саналтай хамт хүлээн авсан эд зүйл байгаа бол гэрээний саналаас татгалзсан ч санал гаргагч талын зардлаар эд зүйлийг хадгалах үүрэгтэй. Гэхдээ тухайн эд зүйлийн үнэ нь зардлыг нөхөхөд хангалтгүй эсвэл худалдаачин нь тухайн зүйлийг хадгалсны улмаас хохирол амсах тохиолдолд уг үүргийг хүлээхгүй.	

Хүлээн зөвшөөрөх эсэх талаараа мэдэгдэх үүргийн хувьд Монгол Улсын иргэний хуулийн §196.1.7-ийн сөрөг тайлбар, §196.2-т тус тус заасанчлан ажил хэргийн байнгын холбоотой аж ахуй эрхлэгч нарын хоорондын худалдааг тогтвортой, хурдан шуурхай байх үүднээс мөн тусгаж өгсөн байна. Ялангуяа Япон улсын худалдааны хуулийн §509.1, §509.2 болон Монгол Улсын иргэний хуулийн §196.2 нь адилхан зохицуулалт байна. Гэрээний саналыг хүлээн хүлээн зөвшөөрөх үүргийн хувьд Монгол Улсын иргэний хуулийн §189.4-т тодорхой зах зээлд давамгайлж буй этгээд нь энэхүү үйл ажиллагааны хүрээнд түүнд хандсан этгээдтэй гэрээ байгуулах үүрэгтэй талаар тусгаж өгчээ.

Мөн Япон улсын худалдааны хуулийн §510.1 нь Монгол Улсын Иргэний хуулийн §196.3-тай төстэй байх бөгөөд хэрвээ гэрээний саналын хамт дагалдуулан эд зүйлийг

илгээсэн бол хадгалах үүрэгтэй гэж Монгол Улсын Иргэний хуулийн §196.3-г төсөөтэй хэрэглэж болох юм.

Иймээс гэрээ байгуулах санал болон хүлээн зөвшөөрөх саналтай холбоотой Япон улсын худалдааны эрх зүйн хэм хэмжээтэй адил зохицуулалтууд Монгол улсын иргэний хуульд агуулагдаж байна.

Үүний дараагаар худалдааны хууль болон иргэний хуулийн төлөөллийн зохицуулалт хэрхэн ялгагдаж байгааг авч үзье.

№	ТӨЛӨӨЛӨЛ	ХУДАЛДААНЫ ХУУЛЬ	ИРГЭНИЙ ХУУЛЬ
1	Төлөөлөл илэрхий байх зарчим / 顕名主義 / зөрчигдөх тохиолдол	§504.1 Худалдааны хэлцлийг төлөөлж буй этгээд нь төлөөлүүлэгчийн өмнөөс хийж буйгаа илэрхийлээгүй хэлцэл хийсэн тохиолдолд ч тухайн хэлцлийн үр дагавар төлөөлүүлэгчид үүснэ. Гэхдээ харилцагч тал нь төлөөлөгч төлөөлүүлэгчийн өмнөөс хэлцэл хийж буйг мэдээгүй бол төлөөлөгчөөс үүргийн гүйцэтгэл шаардахад саад болохгүй.	§99.1.Төлөөлөгч нь бүрэн эрхийнхээ хүрээнд төлөөлүүлэгчийн өмнөөс хийж буйгаа илэрхийлж хийсэн хүсэл зоригийн илэрхийллийн үр дагавар нь төлөөлүүлэгчид үүснэ. §100.1.Төлөөлөгч төлөөлүүлэгчийн өмнөөс хэлцэл хийж буйгаа илэрхийлээгүй хийсэн хүсэл зоригийн илэрхийллийг өөрийн нэрийн өмнөөс хийсэн гэж үзнэ. Гэхдээ харилцагч тал нь төлөөлөгч нь төлөөлүүлэгчийн өмнөөс хийж байгааг мэдсэн эсвэл мэдэх боломжтой байсан бол өмнөх зүйлийн 1 дэх хэсэг нэгэн адил үйлчилнэ.
2	Итгэмжлэлд тусгагдаагүй үүргийг гүйцэтгэх	§505.1.Худалдааны хэлцэл хийхээр итгэмжлэгдсэн этгээд нь итгэмжлэлийн зорилгод харшлахгүй хүрээнд итгэмжлэл олгогдоогүй хэлцлийг хийж болно.	§644.1.Итгэмжлэл олгогдсон этгээд нь итгэмжлэлийн үндсэн зорилгын дагуу шударгаар итгэмжлэгдсэн ажлыг гүйцэтгэх үүрэгтэй.
3	Төлөөлүүлэгч нас барснаар төлөөлөх бүрэн эрх дуусгавар болох эсэх	§506.1.Худалдааны хэлцлийн итгэмжлэлээр олгогдсон төлөөлөх бүрэн эрх нь төлөөлүүлэгч нас барснаар дуусгавар болохгүй.	§111.1.Төлөөлөх бүрэн эрх нь төлөөлүүлэгч нас барснаар дуусгавар болно.

Худалдааны хуулийн §504.1 нь иргэний эрх зүйн төлөөлөлд баримтлагддаг “төлөөлөл илэрхий байх зарчим”-ыг зөрчдөг бөгөөд төлөөлөгч нь бусдыг төлөөлж байгаагаа мэдэгдэлгүйгээр хэлцэл хийсэн бол хэлцлийн үр дагавар төлөөлүүлэгчид үүсэхээр зохицуулжээ. Энэ зүйл нь худалдааны арилжаанд харилцагч талд төлөөлүүлэгч нь хэн байх ач холбогдолгүй эсхүл хэн гэдгийг мэдэж байх нь ердийн үзэгдэл тул их

хэмжээгээр, олон дахин хийгддэг хэлцэлд заавал төлөөлүүлэгчийн нэрийг дурдах шаардлагагүй гэх үндэслэлд суурилдаг. Үүнтэй төстэй зохицуулалт мөн Монгол Улсын иргэний хуулийн §65.3-т тусгагдсан бөгөөд хэлцлийн нөгөө талд хэнтэй хэлцэл хийж байгаа нь ач холбогдолгүй байсан бол төлөөлөгч нь бусдыг төлөөлж байгаагаа мэдэгдэлгүйгээр хэлцэл хийсэн тохиолдолд хэлцлийн үр дагавар төлөөлүүлэгчид үүсдэг.

Худалдааны хуулийн §505.1 нь Иргэний хуулийн §644.1-тэй адил гэж үздэг бөгөөд оршин байх ач холбогдолгүй тул Худалдааны хуульд тусгайлан заах шаардлагагүй гэж үздэг байна. Манай улсын Иргэний хуулийн §63.3-т төлөөлөгч нь бүрэн эрхээ шударгаар, төлөөлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд нийцүүлэн хэрэгжүүлэх үүрэгтэй гэж хуульчилсан байх бөгөөд уг заалтыг дэлгэрүүлж тайлбарлан төлөөлүүлэгчийн ашиг сонирхол, итгэмжлэл олгосон зорилгод нийцэж байвал итгэмжлэлд тусгагдаагүй зүйлийг төлөөлөгч гүйцэтгэсэн ч шударгаар төлөөлсөн гэж үзээд үр дагаврыг төлөөлүүлэгчид бий болгох боломжтой.

Худалдааны хуулийн §506.1-т заасан “Худалдааны хэлцлийн итгэмжлэлээр олгогдсон төлөөлөх бүрэн эрх” гэдгийг худалдааны хэлцэл болох итгэмжлэл буюу итгэмжлэл нь өөрөө худалдааны хэлцэл байх тохиолдлыг ойлгодог байна. Иймээс итгэмжлэл олгох гэрээ нь худалдааны дагалдах хэлцэл болно. Төлөөлүүлэгч нас барснаар бизнесийн үйл ажиллагаа шууд зогсохгүй тул бизнесийн үйл ажиллагааг тогтвортой байлгах зорилгын үүднээс уг заалтыг оруулжээ. Манай улсын иргэний хуулийн §67.2.3-т төлөөлүүлэгч буюу төлөөлөгч нас барсан бол төлөөллийн харилцаа дуусгавар болохоор заасан хэдий ч хууль буюу гэрээнд өөрөөр заасан бол төлөөллийн харилцаа дуусгавар болохгүй байх боломжийг нээлттэй орхижээ.

Эндээс дүгнээд үзэхэд төлөөллийн харилцаанд Япон улсад худалдааны эрх зүйн хэм хэмжээ гэх зохицуулалтууд Монгол Улсын иргэний хуульд мөн оршиж байна.

№	ГЭРЭЭ БАЙГУУЛСНААР ҮҮСЭХ ШААРДАХ ЭРХҮҮД	ХУДАЛДААНЫ ХУУЛЬ	ИРГЭНИЙ ХУУЛЬ
1	Хөлс шаардах эрх 報酬請求権	§512.1. Худалдаачин нь өөрийн аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд бусдад өмнөөс хэлцэл хийсэн бол зохих хэмжээгээр хөлсөө шаардаж болно.	§648.1.Итгэмжлэгдсэн этгээд нь гэрээндээ тохиролцоогүй бол итгэмжлэл олгосон этгээдээс хөлсөө шаардах боломжгүй. Энэ заалт нь хэлцлээс бусад ажил даалгах гэрээ/§656.1/, эд хөрөнгө хадгалах гэрээ /§665.1/-д нэгэн адил үйлчлэхээр заагдсан.
Худалдааны хуулийн §512.1-т “бусдад өмнөөс” гэдгийг худалдаачны хийсэн хэлцлийн үр дагавар нь уг заалтад дурдаж буй бусад этгээдэд бий болж буйг ойлгодог. Манай улсад итгэмжлэл олгох үйлдэл нэг талын хэлцэл болох бөгөөд итгэмжлэгдсэн этгээдэд ямар нэг эрх үүсдэггүй буюу хөлс шаардах эрхгүй юм. Харин манай иргэний хуулийн 399.1-т заасан даалгаврын гэрээний хувьд хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол даалгавар өгөгч нь хөлс төлөх үүргийг хүлээхээр хуульчилсан. Мөн манай иргэний			

хуулийн 422.2-т заасан хадгалалтын гэрээнд өөрөөр заагаагүй бол хадгалалт төлбөргүй байх бөгөөд хэрэв хадгалагч хадгалалтыг аж ахуйн үндсэн үйл ажиллагааны хүрээнд явуулж байгаа бол урьдчилан тохиролцоогүй ч хадгалалтын хөлсийг харилцан тохиролцсон гэж үзнэ гэж хуульчилсан байна. Энэ нь иргэний эрх зүй болон худалдааны эрх зүйн зохицуулалтыг аль алыг нь агуулсан байна.			
2	Хүү шаардах эрх 消費貸借の利息請求権	§513.1.Худалдаачид хооронд мөнгө зээлүүлсэн бол зээлдүүлэгч нь хуульд заасан хүүг шаардаж болно.	§587.1. Талуудын нэг нь төрөл, чанар, хэмжээний адил зүйлийг буцаан өгөхөөр тохиролцож, нөгөө талаас мөнгө болон бусад эд зүйлийг хүлээн авснаар зээлийн гэрээний үр дагавар үүснэ. Зээлийн гэрээ нь хүүтэй болон хүүгүй байж болно.
Иргэний хуульд заасан зээлийн гэрээ нь хүүтэй болон хүүгүй байж болох бөгөөд хүүгийн талаар тодорхой тохиролцоо хийж байж хүү шаардах эрхтэй болно. Харин Худалдааны хуулийн §513.1 нь хүүгийн талаар гэрээнд заагаагүй байсан ч хуульд заасан хүүг шаардах эрхийг худалдаачинд бий болгодог. Манай улсын Иргэний хуулийн §281.1-т заасан Зээл гэрээ нь мөн адил хүүтэй болон хүүгүй байж болох бөгөөд 2015 оны 12-р сарын 3-ны өдөр зээлийн гэрээ нь хариу төлбөргүй байх нэмэлт өөрчлөлт оруулсан боловч 2016 оны 5-р сарын 25-ны Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтээр хүчингүй болжээ. Нөгөө талаас манай иргэний хуулийн Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох тухай зохицуулалт болох §451.1-т "...гэрээнд заасан бол түүний хүүг буцаан төлөх үүргийг хүлээхээс" гадна §453.1-т зээлдэгч авсан зээлээ хугацаанд нь төлөөгүй бол хэтэрсэн хугацааны хүү, гэрээнд заасан бол нэмэгдүүлсэн хүү төлөх үүрэгтэй зааж өгсөн байна. Энэ заалт нь худалдааны үйл ажиллагаа гол зорилго болох ашиг олох боломжийг дэмжиж байна.			
3	Төлбөрийн мөнгөний хүү шаардах эрх 立替金の利息請求権	§513.2.Худалдаачин нь өөрийн бизнесийн хүрээнд бусдын өмнөөс мөнгөн төлбөр гүйцэтгэсэн бол тухайн төлбөр гүйцэтгэсэн өдрөөс хойш хуульд заасан хүүг шаардах эрхтэй.	Иргэний хуульд уг агуулгыг тусгаж өгөөгүй байна.
Худалдааны хуулийн §513.1 нь худалдааны хуулийн §512.1-тэй зорилгын хувьд ижил бөгөөд худалдаачин нь бизнесийн үйл ажиллагааныхаа хүрээнд бусдын өмнөөс зардал гаргасан бол түүнээсээ ашиг олж байх боломжийг бий болгож байх шаардлагатай юм.			
4	Худалдааны хэлцэл дэх хүүгийн хэмжээ 商事法定利率	§514.1.Худалдааны хэлцлийн дагуу үүссэн үүргийн хуульд заасан хүүгийн хэмжээ нь жилийн 6% байна.	§404.1. Хүү бий болох шаардах эрхийн тухай өөрөөр тохиролцоогүй бол тухайн хүүгийн хэмжээ жилийн 5% байна.
Худалдааны хуульд заасан хүүгийн хэмжээ нь иргэний хуульд заасан хэм хэмжээнээс			

өндөр байгаа нь худалдаачин хөрөнгийг бусад этгээдүүдээс илүү ашигтайгаар удирдах боломжтой гэсэн үндэслэлд тулгуурладаг. Иргэний болон худалдааны хуульд заасан хүүгийн хэмжээг гэрээгээр тохиролцон өөрчилж болно. 1954 онд батдлагдсан Хүүгийн хэмжээг хязгаарлах хууль/Interest Rate Restriction Act /-иар үнийн дүнтэй уялдуулан ойролцоогоор 15%-иас 29%-ийн хооронд хүүгийн дээд хэмжээг тогтоож өгчээ.			
5	Үүрэг гүйцэтгэх газар 債務の履行	§516.1.Худалдааны хэлцлийн дагуу үүссэн үүргийг гүйцэтгэх газар нь тухайн хэлцлийн шинж эсвэл талуудын хүсэл зоригийн илэрхийллийн дагуу тогтоогдохгүй тохиолдолд тухайн эд зүйлийг шилжүүлэх бол хэлцэл хийсэн үед тухайн эд зүйл оршин байсан газарт, бусад үүргийн гүйцэтгэлийг үүрэг гүйцэтгүүлэгчийн одоо бизнесээ эрхэлж буй газар(бизнесээ эрхэлж буй газар нь байхгүй бол оршин суух хаягаар)-т тус тус гүйцэтгэнэ. §516.2 Зөвшөөрлийн болон мэдүүлгийн шаардах эрхийн төлбөрийг үүрэг гүйцэтгэгчийн одоо бизнесээ эрхэлж буй газар(бизнесээ эрхэлж буй газар нь байхгүй бол оршин суух хаягаар)-т гүйцэтгэнэ.	§484.1.Үүрэг гүйцэтгэх газрын тухай өөрөөр тохиролцоогүй тохиолдолд тодорхой эд зүйлийг шилжүүлэх бол шаардах эрх үүсэх үед тухайн эд зүйл оршин байсан газарт, бусад үүргийн гүйцэтгэлийг үүрэг гүйцэтгүүлэгчийн одоо оршин суугаа газарт тус тус гүйцэтгэнэ. §485.1.Үүрэг гүйцэтгэхэд гарсан зардлын талаар өөрөөр тохиролцоогүй бол зардлыг үүрэг гүйцэтгэгч хариуцна. Гэхдээ үүрэг гүйцэтгүүлэгч нь оршин буй газраасаа шилжсэн зэрэг бусад үйлдлээс хамааран зардал өссөн бол өссөн хэмжээгээр үүрэг гүйцэтгүүлэгч хариуцна.
Худалдааны хуулийн §516.2-т төлбөрийг үүрэг гүйцэтгэгчийн одоо бизнесээ эрхэлж буй газарт гүйцэтгэнэ гэсэн бол иргэний хуулийн §484.1-т тодорхой эд зүйлийг шилжүүлэхээс бусад тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгчийн одоо оршин суугаа газарт гүйцэтгэнэ гэж заасан. Эхнийх нь үүрэг гүйцэтгэгч өөрийн байгаа газартаа гүйцэтгэх үүрэг бөгөөд (取立債務-Holschuld), сүүлийнх нь үүрэг гүйцэтгүүлэгчийн оршин суугаа газартаа гүйцэтгэх үүрэг(持参債務-Bringschuld) юм. Харин худалдааны хуулийн §516.1-т тодорхой эд зүйлийг шилжүүлэхээс бусад үүргийн гүйцэтгэлийг үүрэг гүйцэтгүүлэгчийн одоо бизнесээ эрхэлж буй газарт гүйцэтгэхээр заасан нь иргэний хуулийн §484.1-тэй адил зарчмыг хэрэглэсэн байна. Эд зүйлийг шилжүүлэх үүргийн гүйцэтгэл нь худалдааны хуулийн §516.1-т зааснаар хэлцэл хийсэн үед тухайн эд зүйл			

оршин байсан газарт, иргэний хуулийн §484.1-т зааснаар шаардах эрх үүсэх үед тухайн эд зүйл оршин байсан газарт тус тус гүйцэтгэхээр ялгаатай зохицуулжээ. Манай улсын иргэний хуулийн §207.1.3-т мөнгөн төлбөрийн үүргийг үүрэг гүйцэтгүүлэгчийн оршин суугаа газарт, нөгөө талаас §207.1.4-т бусад бүх үүргийг үүрэг гүйцэтгэгчийн оршин суугаа газарт гүйцэтгэнэ гэж дээрх зарчимуудын аль альныг нь хэрэглэжээ.			
6	Үүрэг гүйцэтгэх хугацаа 債務の履行の時間	§520.1.Хууль эсвэл заншлаар худалдаачны арилжааны хугацааг тодорхойлсон бол тухайн арилжааны хугацааны дотор үүргийг гүйцэтгэж, эсвэл үүргийн гүйцэтгэлийг шаардаж болно.	§412.1.Үүргийн гүйцэтгэлийн тухай тодорхой хугацаа заасан байгаа бол үүрэг гүйцэтгэгч нь тухайн хугацаа болсон үеэс хугацаа хэтрүүлсний хариуцлага хүлээнэ. §412.2. Үүргийн гүйцэтгэлийн тухай тодорхой хугацаа заагаагүй бол үүрэг гүйцэтгэгч нь тухайн хугацаа болсныг мэдсэн үеэс хугацаа хэтрүүлсний хариуцлага хүлээнэ. §412.3. Үүргийн гүйцэтгэлийн тухай хугацаа тогтоогоогүй бол үүрэг гүйцэтгэгч нь гүйцэтгэлийн шаардлагыг хүлээн авсан үеэс хугацаа хэтрүүлсний хариуцлага хүлээнэ.
Зөвхөн худалдааны эрх зүйн харилцаанд гэлтгүй иргэний эрх зүйн харилцаанд нэгэн адил байх ёстой учир худалдааны хуульд уг заалт оршин байх ач холбогдолгүй юм.			
7	Хөөн хэлэлцэх хугацаа 消滅時効	§522.1.Худалдааны хэлцлийн дагуу үүссэн шаардах эрх нь энэ хуульд өөрөөр заагаагүй бол 5 жилийн хугацаанд хэрэгжүүлээгүй тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа дуусгавар болно. Гэхдээ бусад хууль, тогтоомжинд 5 жилээс богино хөөн хэлэлцэх хугацааг тогтоосон бол тухайн заалтын дагуу шийдвэрлэнэ.	§167.1. Үүргийн шаардах эрх нь 10 жилийн хугацаанд хэрэгжүүлэхгүй бол дуусгавар болно. §167.2. Үүргийн шаардах эрх болон өмчийн эрхээс бусад эдийн засгийн эрх нь 20 жилийн хугацаанд хэрэгжүүлэхгүй бол дуусгавар болно.
Иргэний хуульд мөн хөөн хэлэлцэх хугацааг 5 жилээс бага буюу 3, 2, 1 жил байх			

тохиолдлуудыг хуульчилж өгсөн.

№	Хөөн хэлэлцэх хугацаа	Хуулийн зохицуулалт
1	3 жил	§170.1. Дараах шаардах эрхийг 3 жилийн хугацаанд хэрэгжүүлэхгүй бол дуусгавар болно. Гэхдээ 2 дугаарт заасан шаардах эрхийн хөөн хэлэлцэх хугацааг барилга байгууламж дууссан үеэс тоолж эхэлнэ. §170.1.1.Эмч, сувилагч, эм найруулагчийн эмчилгээ, сувилгаа эсвэл эм найруулалттай холбогдох шаардах эрх §170.1.2.Барилгын зураг төсөл, бүтээн байгуулалт эсвэл хяналтыг аж ахуйн үйл ажиллагаагаа болгосон этгээдийн барилга байгууламжтай холбогдох шаардах эрх §171.1.Өмгөөлөгч эсвэл өмгөөллийн хуулийн этгээд нь хэрэг хаагдсан үеэс, нотариатч нь ажил үүргээ гүйцэтгэсэн үеэс 3 жил өнгөрвөл ажил үүргийн хүрээнд хүлээн авсан бичиг баримтын тухайд хариуцлагаас чөлөөлөгдөнө.
2	2 жил	§172.1 Өмгөөлөгч, өмгөөллийн хуулийн этгээд эсвэл нотариатч нь ажил үүрэгтэйгээ холбогдох шаардах эрхээ туслалцаа үзүүлсэн хэрэг хаагдсан үеэс 2 жил хэрэгжүүлээгүй бол дуусгавар болно. §172.2 Өмнөх заалтаас үл хамааран хэрэг доторх тодорхой хэсэг хаагдсан үеэс 5 жил өнгөрсөн бол өмнөх заалтын хугацаан дотор байсан ч тухайн хэсэгтэй холбогдох шаардах эрх дуусгавар болно. §173.1 Дараах шаардах эрхийг 2 жилийн хугацаанд хэрэгжүүлэхгүй бол дуусгавар болно. §173.1.1 Үйлдвэрлэгч, бөөний худалдаачин эсвэл жижиглэн худалдаачны борлуулсан бүтээгдэхүүн эсвэл түүний хариу төлбөртэй холбогдох шаардах эрх §173.1.2 Өөрийн ур чадварыг ашиглан захиалга авч эд зүйлийг бүтээх эсвэл өөрийн ажлын газартаа бусдын ажлыг гүйцэтгэхийг аж ахуйн үйл ажиллагаагаа болгосон этгээдийн уг ажилтай нь холбогдох шаардах эрх §173.1.3 Шинжлэх ухаан, урлаг уран сайхан эсвэл ур чадвар олгох боловсролын үйл ажиллагаа явуулдаг этгээд нь сурагчдын боловсрол, хувцас, хоол хүнс, орон байрны төлбөрийг шаардах эрх
3	1 жил	§174.1 Дараах шаардах эрхийг 1 жилийн хугацаанд хэрэгжүүлэхгүй бол дуусгавар болно. §174.1.1. Сар эсвэл түүнээс бага хугацаагаар тогтоогдох ажилтны цалинтай холбоотой шаардах эрх §174.1.2. Өөрийн ажиллах хүчийг нийлүүлэх эсвэл урлагийн үзүүлбэрийг аж ахуйн үйл ажиллагаагаа болгосон этгээдийн хөлс эсвэл нийлүүлсэн эд зүйлийн хариу төлбөртэй холбоотой шаардах эрх §174.1.3.Тээврийн зардалтай холбоотой шаардах эрх §174.1.4. Зочид буудал, хоолны газар, уушын газар, үзвэр үйлчилгээний газрын төлбөртэй холбогдох шаардах эрх §174.1.5. Хөдлөх хөрөнгө ашигласны төлбөртэй холбоотой

	шаардах эрх
Худалдааны хуулийн §522.1 нь худалдааны хэлцэл хурдан шуурхай байх шаардлагын үүднээс Иргэний хуулийн ерөнхий зохицуулалт болох 10 жилийн хугацааг богиносгож байгаагаараа зөвтгөгддөг боловч бүхий л худалдааны хэлцэлд нэг адил байдлаар зохицуулсан нь шүүмжлэлд өртдөг байна. Өөрөөр хэлбэл уг заалт нь худалдааны хэлцэл тус бүрийн онцлогийг харгалзан үзээгүй гэдгээрээ шүүмжлүүлдэг. Мөн Иргэний хуулийн дээрх хөөн хэлэлцэх хугацааг богиносгосон заалтууд нь өдөрт тутмын худалдааны харилцааг зохицуулах шинжтэй байх бөгөөд худалдааны бүртгэл хийгдэж, хадгалагдаад байдаггүй учир хөөн хэлэлцэх хугацааг богиносгодог байна. Гэвч тухайлбал §173.1.1-т заасан үйлдвэрлэгч, бөөний худалдаачин эсвэл жижиглэн худалдаачид буюу худалдааны бүртгэл хөтлөх үүрэг хүлээсэн этгээдэд энэ заалт үйлчлэх эсэх нь маргаан дагуулдаг боловч Дээд шүүхийн жишгээр худалдаачинд мөн энэ заалт хамаарна гэж үздэг. Монгол Улсын иргэний хуулийн §75.1-т зааснаар хөөн хэлэлцэх хугацаа 10 жил боловч §75.2.1-т гэрээний үүрэгтэй холбоотой шаардлага гаргах хөөн хэлэлцэх хугацаа 3 жил байхаар заасан нь Япон улсын иргэний болох худалдааны хуулийн зохицуулалтаас аль альнаас нь богино хугацаа тогтоож өгсөн.	

2017 оны 5 сарын 26-ны өдөр Япон Улсын Иргэний хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хууль батлагдсан бөгөөд 3 жилийн дотор Засгийн газрын шийдвэрээр дагаж мөрдөх хугацааг тогтоохоор болоод байна. Энэ өөрчлөлт нь Япон улсын Иргэний хууль анх батлагдсанаас хойшоос үүргийн эрх зүйн зохицуулалт орж байгаа анхны томоохон өөрчлөлт ажээ. Үүнээс худалдааны хуулийн хэм хэмжээнд өөрчлөлт орж буй нь “хуульд заасан хүүгийн хэмжээ”, “хөөн хэлэлцэх хугацаа”-нд өөрчлөлт орохоор болсон.

Япон Улсын Иргэний хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулиар хүүгийн хэмжээг 3%-руу буулгасан бөгөөд гурван жил тутамд эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан хүүгийн хэмжээг шинэчлэн тогтоох тогтолцоог оруулж ирсэн. Үүнтэй зэрэгцэн Худалдааны хуулийн §514-р зүйлийг хүчингүй болгож хүүгийн нэг тогтолцоо үйлчлэхээр болжээ.

Хөөн хэлэлцэх хугацааг зохицуулж буй Иргэний хуулийн §166.1-г “Үүргийн шаардах эрх бүхий этгээд нь эрхээ хэрэгжүүлж болохыг мэдсэн үеэс 5 жилийн хугацаанд хэрэгжүүлээгүй бол үүргийн шаардах эрх дуусгавар болно”, §166.2-г “Үүргийн шаардах эрх бүхий этгээд нь эрхээ хэрэгжүүлж болох үеэс 10 жилийн хугацаанд хэрэгжүүлээгүй бол үүргийн шаардах эрх дуусгавар болно” гэж тус тус өөрчлөхөөр болсон. Нөгөө талаас Иргэний хуулийн §170-§174 нь хүчингүй болж ерөнхий зохицуулалт үйлчлэхээр болсны зэрэгцээ Худалдааны хуулийн §522 мөн хүчингүй болж байна.

Худалдааны хэлцлээс үүдэх үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулах зохицуулалтуудын талаар авч үзье.

№	ҮҮРГИЙН ХАРИЛЦАА	ХУДАЛДААНЫ ХУУЛЬ	ИРГЭНИЙ ХУУЛЬ
1	Хэд хэдэн үүрэг гүйцэтгэгч үүргийн гүйцэтгэлийг хамтран хариуцах	§511.1 Хэд хэдэн этгээд нь аль нэгнийх нь эсвэл бүгдийнх нь хувьд худалдааны хэлцэл болох хэлцэлд үүрэг хүлээсэн бол тухайн үүргийг тус бүртээ хамтран хариуцна. /連帯債務/	§427.1 Хэд хэдэн этгээд үүрэг гүйцэтгүүлэгч эсвэл үүрэг гүйцэтгэгч байх тохиолдолд өөрөөр тохиролцоогүй бол үүрэг гүйцэтгүүлэгч бүр эсвэл үүрэг гүйцэтгэгч бүр тус тус адил хэмжээгээр эрх эдэлж, эсвэл үүрэг

			хүлээнэ. /分割債務・債権/
Үүрийн харилцаанд олон этгээд оролцох тохиолдолд иргэний хуулийн §427.1-ийн дагуу үүрэг гүйцэтгэгчид үүргээ гүйцэтгэхдээ бие биеэсээ хамааралгүйгээр өөрт ногдох хэсгээ хариуцах бөгөөд үүрэг үл хуваагдах шинжтэй эсхүл гэрээ болон хуульд өөрөөр заагаагүй л бол хэсгээр үүрэг гүйцэтгэх нь үндсэн зарчим юм. Харин худалдааны хуулийн §511.1-ийн дагуу үүргийг бүхэлд нь гүйцэтгэх хүртэл үүрэг гүйцэтгэгчдийн хэн нь ч үүргээс чөлөөлөгдөхгүй буюу хамтран үүрэг гүйцэтгэхээр зохицуулагдсан. Худалдааны хуульд хамтран үүрэг гүйцэтгэх зарчмыг сонгон авсан шалтгаан нь худалдааны хэлцлээс үүсэх үүргийг илүү баталгаажуулахыг зорьсон бөгөөд хамтран үүрэг гүйцэтгэгчдийн хэн нэг нь үүрэг гүйцэтгэх чадамжгүй боллоо гэхэд бусад үүрэг гүйцэтгэгчид үүргийг бүхэлд нь гүйцэтгэх үүрэг хүлээдэгт буй юм. Ингэснээр хэсгээр үүрэг гүйцэтгэхтэй харьцуулахад хамтран үүрэг гүйцэтгэх тогтолцоо нь үүргийн гүйцэтгэлийг илүү баталгаажуулдаг байна. Монгол Улсын иргэний хуулийн §242.11-т “Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй, ...бол тэдгээрийн үүрэг тэнцүү байна” гэж хуульчилснаас харахад хэсгээр үүрэг гүйцэтгэх нь ерөнхий зарчим юм. Харин хууль болон гэрээнд тусгайлан хамтран үүрэг гүйцэтгэх талаар заасан бол уг зарчмыг баримтална.			
2	Батлан даагч хамтран үүрэг гүйцэтгэх	§511.2 Батлан даагч байгаа тохиолдолд үүрэг нь үндсэн үүрэг гүйцэтгэгчийн худалдааны хэлцлээс үүссэн үүрэг бол, эсвэл батлан даалт нь худалдааны хэлцэл бол, үндсэн үүрэг гүйцэтгэгч болон батлан даагч нь тус тусдаа хэлцлээр үүрэг хүлээхээр байсан ч тухайн үүргийг тус бүр хамтран хариуцна.	§452.1 Үүрэг гүйцэтгүүлэгч нь батлан даагчаас үүргийн гүйцэтгэлийг шаардсан бол, батлан даагч нь эхлээд үндсэн үүрэг гүйцэтгэгчээс шаардахыг шаардаж болно. Гэхдээ үндсэн үүрэг гүйцэтгэгчид дампуурлын хэрэг үүсгэгдсэн байгаа эсвэл ор сураггүй болсон бол энэ заалт үйлчлэхгүй. §453.1 Үүрэг гүйцэтгүүлэгч нь өмнөх зүйлийн заалтын дагуу үндсэн үүрэг гүйцэтгэгчээс шаардсаны дараа байсан ч батлан даагч нь үндсэн үүрэг гүйцэтгэгч төлбөрийн чадвартай мөн гүйцэтгүүлэхэд хялбар гэж баталсан бол үүрэг гүйцэтгүүлэгч нь үндсэн үүрэг гүйцэтгэгчийн хөрөнгөөс үүргийг гүйцэтгүүлнэ.
Иргэний хуулийн дагуу гэрээнд өөрөөр заагаагүй бол §452.1, §453.1-т заасан хариу эсэргүүцлийг батлан даагч гаргаж болно. Харин худалдааны хуульд зааснаар тухай хэцэл нь худалдааны хэлцэл бол батлан даагч нь иргэний хуульд заасан хариу эсэргүүцэл гаргах боломжгүй бөгөөд хамтран үүрэг гүйцэтгэхтэй нэгэн адил үүргийг гүйцэтгэх шаардлагатай болно. Монгол Улсын иргэний хуулийн §460.1-ийн дагуу батлан даагч нь үүрэг гүйцэтгэгчийн өмнөөс нөхөх хариуцлага хүлээнэ гэж ерөнхий зарчмыг тодорхойлж, §460.2-т гэрээнд			

заасан бол батлан даагч нь үүрэг гүйцэтгэгчтэй хамтран үүрэг гүйцэтгэгч байх боломжтой байна.			
3	Хөрөнгийн барьцаалан зээлдүүлэгчийн эрх	§515.1 Иргэний хуулийн 349-р зүйлийн заалт нь худалдааны хэлцлээс үүссэн үүргийн шаардах эрхийг баталгаажуулах зорилгоор хийсэн барьцаалан зээлдэх эрхэд үйлчлэхгүй.	§349.1 Барьцаалан зээлдэгч нь хөрөнгө барьцаалах хэлцэл эсвэл үүрэг гүйцэтгэх хугацаанаас өмнөх гэрээгээр барьцаалагчид хариу төлбөр болгон хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг олгож, мөн бусад хуульд заасан аргыг ашиглалгүйгээр хөдлөх хөрөнгийг захиран зарцуулуулахыг гэрээгээр тохиролцож болохгүй.
Иргэний хуулиар хөрөнгийг барьцаалан зээлдэж байгаа тохиолдолд барьцаагаар хангагдах үүргийг гүйцэтгээгүй бол барьцаалагч нь барьцаалагдсан хөрөнгийг өөрийн өмчлөлд шууд шилжүүлж авахыг хориглодог. Энэ нь үүрэг гүйцэтгэгчийн эдийн засгийн хүнд байдлыг ашиглан үүрэг гүйцэтгүүлэгч их хэмжээний ашиг олох явдлаас сэргийлэх зорилготой. Гэвч Барьцаалан зээлдэх газрын аж ахуйн үйл ажиллагааны хуулийн §19.1-т “Барьцаалан зээлдэх газар нь барьцааны хугацааны өнгөрснөөр тухайн барьцааны зүйлийн өмчлөх эрхийг олж авна” гэж заасан нь иргэдийн ашиг сонирхол хамгийн ихээр хөндөгдөж болох барьцаалан зээлдэх газарт уг хамгаалалт үйлчлэхгүй байгаа нь иргэний хуулийн зохицуулалтын ач холбогдлыг сулруулдаг. Харин худалдааны хуулиар барьцаалан зээлдүүлэгч нь барьцаалагдсан хөрөнгийг өөрийн өмчлөлд шилжүүлж авах гэрээг хийж болохыг зөвшөөрсөн. Учир нь үүрэг гүйцэтгэгч нь худалдаачин байх тохиолдолд эдийн засгийн эрсдэлийг хангалттай тооцоож уг харилцаанд оролцож буй тул уг хамгаалалт шаардлагагүй юм. Энэ нь худалдааны хэлцэл дэх итгэлийг нэмэгдүүлж, түүнийг идэвхжүүлэх зорилготой. Монгол Улсын Иргэний хуулийн §286.4-т “Барьцаалан зээлдэх газар нь гэрээний хугацаанд барьцааны зүйлийн бүрэн бүтэн байдлыг хангах үүрэгтэй, харин уг зүйлийг өмчлөх болон бусад хэлбэрээр захиран зарцуулах эрхгүй” гэж заан өмчлөх эрх шилжих бусад хэлбэрээр захиран зарцуулахыг хориглосон байна. Манай улсын барьцаалан зээлдэх зүйл нь зөвхөн хөдлөх эд хөрөнгө байдаг бол Япон улсын барьцаалан зээлдэх зүйл нь бүхий л хөрөнгө байж болдог.			
4	Саатуулан барих эрх	§521.1 Худалдаачдын хооронд аль алинд нь худалдааны хэлцэл болох хэлцлээс үүсэх үүргийг гүйцэтгэх хугацаа болсон бол үүрэг гүйцэтгүүлэгч нь үүргийг гүйцэтгэх хүртэл үүрэг гүйцэтгэгчтэй байгуулсан худалдааны хэлцлийн дагуу түүний эзэмшилд байгаа үүрэг гүйцэтгэгчийн өмчлөлийн эд юмс эсвэл үнэт цаасыг	§295.1 Бусдын эд зүйлийг эзэмшигч нь тухай эд зүйлтэй холбогдож үүссэн шаардах эрхтэй бол шаардах эрхийг хангах хүртэл тухайн эд зүйлийг саатуулан барих эрхтэй. Гэхдээ тухайн үүргийг гүйцэтгэх хугацаа тохироогүй бол энэ заалт хамаарахгүй.

		саатуулан барих эрхтэй. Гэхдээ талууд өөрөөр тохиролцсон бол энэ заалт хамаарахгүй.	
--	--	---	--

Иргэний хуулийн дагуу саатуулан барих эрх үүсэхийн тулд барьцаагаар хангагдах шаардах эрх болон барьцааны зүйл нь хооронд холбоотой байх шаардлагатай буюу барьцааны зүйлтэй холбогдож үүссэн шаардах эрх байх хэрэгтэй. Харин худалдааны хуулийн дагуу худалдаачин хооронд тогтмол хийгдэж буй худалдааны арилжаанаас үүссэн шаардахыг эрхийг хангуулахын тулд тухайн арилжаатай холбоогүйгээр тусдаа худалдааны хэлцлийн улмаас нөгөө талын худалдаачны өмчлөлийн зүйл шаардах эрх бүхий худалдаачны эзэмшилд байгаа бол үүнийг саатуулан барих байдлаар тухайн шаардах эрхээ хангуулж болно. Өөрөөр хэлбэл шаардах эрх болон саатуулан барьж буй зүйл нь тодорхой хэлцлээр холбогдсон байхыг иргэний хууль шиг шаарддаггүй байна.

Дээрх хүснэгтэд авч үзсэн худалдааны хуулийн худалдааны хэлцлээс үүдэх үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулах зохицуулалт нь иргэний хуультай харьцуулахад талуудад баталгаат байдлыг илүү бий болгож, худалдааны хэлцэл идэвхтэй хийгдэх орчныг бүрдүүлж байна.

Үүний дараагаар үнэт цаасаар дамжуулан худалдааны хэлцлээс үүсэх үүргийг хэрхэн гүйцэтгэж буй талаар авч үзье.

№	ҮНЭТ ЦААСААР ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХ	ХУДАЛДААНЫ ХУУЛЬ	ИРГЭНИЙ ХУУЛЬ
1	Үнэт цаасаар гэрчлэгдсэн үүргийг гүйцэтгэх хугацаа	§517.1 Зөвшөөрлийн шаардах эрх эсвэл мэдүүлгийн шаардах эрхийн үүрэг гүйцэтгэгч нь үүргийн гүйцэтгэлийг гүйцэтгэх хугацаа заасан байсан ч тухайн хугацаа өнгөрсний дараа эзэмшигч нь тухайн үнэт цаасыг үзүүлэн, гүйцэтгэлийг шаардсан үеэс хугацаа хожимдуулсны хариуцлага хүлээнэ.	§412.1 Үүргийн гүйцэтгэлийг гүйцэтгэх тодорхой хугацаа заасан бол үүрэг гүйцэтгэгч нь тухайн хугацаа өнгөрсөн үеэс хугацаа хожимдуулсны хариуцлага хүлээнэ.

Иргэний хуулийн дагуу үүргийн гүйцэтгэлийг гүйцэтгэх тодорхой хугацаа заасан тохиолдолд тухайн хугацаа өнгөрсөн бол хугацаа хожимдсон гэж үзнэ. Харин худалдааны хуулийн дагуу гэрээнд заасан үүрэг гүйцэтгэх хугацаа өнгөрсөн ч хугацаа хэтрүүлсэн гэж үзэхгүй бөгөөд үнэт цаасны эзэмшигч нь үнэт цаасаа үзүүлэн үүрэг гүйцэтгэхийг шаардсан үеэс эхлэн үүрэг гүйцэтгэх хугацаа өнгөрсөн гэж үзнэ. Гэхдээ вексель, чек, хувьцааны хувьд тус тусдаа бие даасан хуулиараа зохицуулагддаг тул энэ зохицуулалт үйлчлэхгүй. Энэ зохицуулалт нь хуурай замаар ачаа тээвэрлэлтийн дагалдах бичиг (貨物引換, inland bill of lading, carriage note), усан замаар ачаа тээвэрлэлтийн дагалдах бичиг (船荷証券, bill of lading), агуулахын баримт (倉庫証券, warehouse receipt) гэх мэт үнэт цаасуудын дагуу үүрэг гүйцэтгэхэд чухал ач холбогдолтой зохицуулалт болно.

2	Үнэт цаасыг үрэгдүүлсэн тохиолдолд эрхээ хэрэгжүүлэх арга	§518.1 Мөнгө бусад эд юмс эсвэл үнэт цаасны хариу үүргийг олж авах эрх бүхий үнэт цаас эзэмшигч нь тухай үнэт цаасыг үрэгдүүлсэн тохиолдолд Шүүхийн онцгой ажиллагааны журмын тухай хуулийн §114-т заасан нийтэд мэдэгдэх(公示催告 ²⁷) хүсэлт гаргасан бол үүрэг гүйцэтгэгчээр тухайн үүргийн зүйлийг хадгалуулах эсвэл зохих хэмжээний барьцаа өгөн үнэт цаасны агуулгын дагуу үүргийг гүйцэтгүүлэн авч болно.	Тодорхой зохицуулалт байхгүй.
3	Үнэт цаасыг шударгаар олж авах	§519.1 Мөнгө бусад эд юмс эсвэл үнэт цаасны хариу үүргийг олж авах эрх бүхий үнэт цаасыг шилжүүлэхэд тухайн үнэт цаасны шинж чанарын дагуу Векселийн хуулийн §12, §13, §14.2 зүйл эсвэл Чекийн хуулийн §5.2 зүйл болон §9 зүйлийн заалт нэгэн адил үйлчилнэ.	Тодорхой зохицуулалт байхгүй.

4.2 ХУДАЛДААНЫ ХЭЛЦЛИЙН ТУСГАЙ АНГИ

Япон улсын иргэний болон худалдааны хуульд тусгагдсан гэрээнүүдийг доорх хүснэгтээр харуулъя.

№	ИРГЭНИЙ ХУУЛЬ	ХУДАЛДААНЫ ХУУЛЬ
1	Бэлэглэл §549-554	Худалдах, худалдан авах гэрээ §524-528
2	Худалдах, худалдан авах §555-585	Тооцоо нийлэх гэрээ §529-534
3	Буцаан худалдан авах гэрээ §579	Далд хамтран ажиллах гэрээ §535-542
4	Арилжааны гэрээ §586	Худалдааны зуучлалын гэрээ §543-550
5	Зээл §587-592	Худалдааны комиссын гэрээ §551-558
6	Эд хөрөнгө үнэ төлбөргүй ашиглуулах §593-600	Тээвэр зуучлалын гэрээ §559-568
7	Эд хөрөнгө хөлслөх §601-622	Тээвэрлэлтийн гэрээ §569-592
8	Хөдөлмөрийн гэрээ §603-631	Хадгалалтын гэрээ §593-628
9	Ажил гүйцэтгэх §632-642	Далайн тээвэрлэлтийн гэрээ §737-787

²⁷ Нийтэд мэдэгдэх гэдэг нь шүүх тодорхой бус эсвэл сураггүй болсон сонирхогч этгээдэд хандан 2 сараас дээш хугацааны дотор өргөдөл гаргахгүй бол эрхээ алдах болохыг анхааруулан шүүхэд нэхэмжлэл эсвэл эрхээ хэрэгжүүлэх талаар мэдэгдэхийг олон нийтэд зарлахыг хэлнэ.

10	Даалгаврын гэрээ §643-656	
11	Хадгалалтын гэрээ §657-666	
12	Хамтран ажиллах гэрээ §667-688	
13	Насан туршийн тэтгэмжийн гэрээ §689-694	
14	Эвлэрлийн гэрээ §695-696	

4.2.1 ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

Худалдааны хуульд худалдах, худалдан авах гэрээтэй холбоотой 5 зүйл буюу харьцангуй цөөхөн зохицуулалт тусгагджээ. Энэ нь иргэний хуульд уг гэрээний харилцааг дэлгэрэнгүй зохицуулалт зохицуулсан холбоотой юм. Худалдааны хуулийн эдгээр 5 зүйлийн онцлог нь худалдагчийн ашиг сонирхлыг түлхүү хамгаалсан зохицуулалтууд байдаг. Зорилго нь худалдагчийн хувьд тухайн арилжаа баттай хийгдэх, хурдан шуурхай байх нөхцөлийг хангахыг чухалчилжээ.

№	ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ	ХУДАЛДААНЫ ХУУЛЬ	ИРГЭНИЙ ХУУЛЬ
1	Худалдагчийн хадгалуулах эрх	§524.1 Худалдаачин хооронд худалдах, худалдан авах гэрээ байгуулсан тохиолдолд худалдан авагч гэрээний зүйлийг хүлээн авахаас татгалзсан эсвэл хүлээн авах боломжгүй бол худалдагч нь гэрээний зүйлийг хадгалуулах эсвэл зохих хугацаа тогтоон хүлээн авахыг шаардсаны дараа дуудлага худалдаагаар гэрээний зүйлийг борлуулж болно. Энэ тохиолдолд худалдагч нь гэрээний зүйлийг хадгалуулсан эсвэл дуудлага худалдаагаар худалдах гэж байгаа бол хойшлуулалгүй худалдан авагчид энэ тухай мэдэгдлээ илгээх үүрэгтэй.	§494.1 Үүрэг гүйцэтгүүлэгч нь үүргийн гүйцэтгэлийг хүлээн авахаас татгалзах эсвэл үүнийг хүлээн авах боломжгүй бол үүрэг гүйцэтгэх боломжтой этгээд нь үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнөөс гэрээний зүйлийг хадгалуулж тухайн үүргээс чөлөөлөгдөнө. Үүрэг гүйцэтгэгч нь гэм буруугүйгээр үүрэг гүйцэтгүүлэгчийг баттай мэдэж чадаагүй тохиолдолд ч нэгэн адил байна.
Дээрх хоёр зохицуулалтын хувьд төдийлөн ялгаа бол харагдахгүй болов уу. Гэхдээ гол ялгаа нь худалдааны хуулийн зохицуулалт нь үүргийн гүйцэтгэлийн зүйлийг хадгалуулсан тухай мэдэгдлийг илгээснээр эрх зүйн дагавар үүсдэг/ 発信主義 / зарчмыг хэрэглэн, арилжааны харилцааг илүү хурдан шуурхай болгохыг зорьжээ.			
2	Худалдагчийн зарах эрх	Худалдагч нь гэрээний зүйлийг хадгалуулахаас гадна худалдаж болохыг §524.1-ээс харна уу. §524.2. Муудах зэрэг бусад шалтгаанаар үнэ нь буурч болзошгүй байгаа зүйлийг өмнөх заалтад заасан мэдэгдлийг хийлгүйгээр дуудлага худалдаагаар худалдаж болно.	§497.1 Гэрээний зүйлийг хадгалуулахад тохиромжгүй бол эсвэл устах, муудаж болзошгүй бол үүрэг гүйцэтгэгч нь шүүхийн зөвшөөрлөөр гэрээний зүйлийг худалдаж үнийг нь хадгалуулж болно. Тухайн эд зүйлийг

		§524.3.Өмнөх заалтын дагуу гэрээний зүйлийг худалдсан бол худалдагч нь үнийг хадгалуулна. Гэхдээ үнийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн хариу төлбөртөө тооцож авахад саад болохгүй.	хадгалахад хэт их зардал гарахаар бол нэгэн адил байна.
Иргэний хуульд гэрээний зүйлийг зөвхөн §497.1-т заасан тохиолдол буюу гэрээний зүйлийг хадгалуулахад тохиромжгүй эсвэл устах, муудаж болзошгүй мөн хадгалахад хэт их зардал гарах тохиолдолд л худалдаж болохоос гадна худалдах бол шүүхийн зөвшөөрөл авах шаардлагатай болдог. Харин худалдааны хуульд ийм хязгаарлалт байхгүй. Мөн Иргэний хуулийн дагуу дуудлага худалдаагаар худалдсан гэрээний зүйлийн үнийг бүгдийг нь хадгалуулах шаардлагатай бол худалдааны хуулийн дагуу үнээс өөрийн хариу төлбөрөө авах боломжтой.			
3	Хугацаатай худалдах худалдан авах гэрээнээс татгалзах эрх	§525.1. Худалдаачин хооронд худалдах худалдан авах гэрээ байгуулсан тохиолдолд гэрээний шинж чанар эсвэл талуудын хүсэл зоригийн дагуу тогтоосон цаг, өдөр эсвэл тодорхой хугацааны дотор үүргийг гүйцэтгэхгүй бол гэрээний зорилго биелэгдэх боломжгүй болох тохиолдолд талуудын нэг нь үүргээ гүйцэтгэлгүй тухайн хугацаа хэтрүүлсэн бол нөгөө тал нь нэн даруй үүргийн гүйцэтгэлийг шаардааснаас бусад тохиолдолд гэрээнээс татгалзсан гэж үзнэ.	§541.1. Талуудын нэг нь үүргээ гүйцэтгэхгүй бол нөгөө тал нь зохих хугацааг тогтоон үүрэг гүйцэтгэхийг шаардах ба уг хугацаанд үүргээ гүйцэтгэхгүй бол гэрээнээс татгалзаж болно. §542.1. Гэрээний шинж чанар эсвэл талуудын хүсэл зоригийн дагуу тогтоосон цаг, өдөр эсвэл тодорхой хугацааны дотор үүргийг гүйцэтгэхгүй бол гэрээний зорилго биелэгдэх боломжгүй болох тохиолдолд талуудын нэг нь үүргээ гүйцэтгэлгүй тухайн хугацааг хэтрүүлсэн бол нөгөө тал нь өмнөх заалтад заасан шаардлага гаргалгүйгээр нэн даруй гэрээнээсээ татгалзаж болно.
Иргэний хуулийн дагуу нөгөө тал нь гэрээнээс татгалзаж байгаа бол татгалзах хүсэл зоригөө нөгөө талдаа илэрхийлэх шаардлагатай болно. Харин худалдааны хуулийн дагуу нөгөө тал нь татгалзаж буй бол татгалзах хүсэл зоригөө илэрхийлэх шаардлагагүй бөгөөд хугацаа хэтэрсэн үеэс гэрээнээс татгалзсан үр дагавар үүснэ. Иргэний хуулийн дагуу худалдагч татгалзах хүсэл зоригөө илэрхийлэх хүртэл худалдан авагч нь гэрээний үүргээ гүйцэтгэх эсвэл худалдагч талыг гэрээнээс татгалзахыг хүлээх гэсэн сонголттой болж, бүтээгдэхүүний үнэ өсвөл харьцангуй хямд үнээр үнэтэй эд зүйл олж авах тул гэрээний үүргээ гүйцэтгэх ба, эсрэгээр нь бүтээгдэхүүний үнэ буурвал хямд зүйлийг үнэтэй авахыг хүсэхгүй бөгөөд үүргээ гүйцэтгэхгүй буюу гэрээнээс татгалзах замыг сонгох юм. Иймээс худалдааны хуульд уг нөхцөл байдлаас сэргийлж худалдагчийг хамгаалах, худалдааны арилжаа хурдан шуурхай байх, цаг хугацааг чанд баримтлах зорилгоор уг зохицуулалтыг бий болгожээ.			
4	Худалдан авагчийн хянан	§526.1.Худалдаачин хооронд худалдах худалдан авах гэрээ	§570.1 Гэрээний зүйлд нуугдмал доголдол байгаа бол

	шалгах, мэдэгдэх үүрэг	байгуулсан тохиолдолд худалдан авагч нь тухайн гэрээний зүйлийг хүлээн авсан үеэс хойшлуулалгүй тухайн зүйлийг хянан шалгах ёстой. §526.2.Өмнөх заалтад тусгагдсаны дагуу худалдан авагч нь гэрээний зүйлд хянан шалгалт хийж доголдол байгааг эсвэл тоо хэмжээ дутуу байгааг илрүүлсэн бол нэн даруй худалдагчид энэ тухай мэдэгдлээ илгээгүй бол тухайн доголдол эсвэл тоо, хэмжээ дутуу шалтгаанаар гэрээнээс татгалзах эсвэл хариу төлбөрийг багасгах мөн хохирол шаардах боломжгүй. Гэрээний зүйлд нэн даруй илрүүлэх боломжгүй доголдол байгаа бол худалдан авагч нь 6 сарын дотор доголдлыг илрүүлбэл нэгэн адил авч үзнэ. §526.3. Өмнөх заалт нь худалдагч тухайн доголдол эсвэл тоо, хэмжээ дутуу байгаа талаар мэдэж байсан бол үйлчлэхгүй.	§566.3 нэгэн адил үйлчилнэ. Гэхдээд албадан дуудлага худалдаа үүнд хамаарахгүй. §566.3 Худалдан авагч нь үйл явдлыг мэдсэнээс хойш 1 жилийн дотор шаардах эрхээ хэрэгжүүлнэ.
Иргэний хуулийн дагуу доголдлыг мэдсэнээс хойш нэг жилийн дотор гэрээнээс татгалзах, үнийг бууруулах, хохирол шаардах эрхээ хэрэгжүүлэх боломжтой. Харин худалдааны хуулийн дагуу доголдлын талаар мэдсэн бол хойшлуулалгүй нөгөө талдаа мэдэгдэх үүрэгтэй ба мэдэгдээгүй бол шаардах эрхээ алдах юм. Уг зохицуулалтын зорилго нь худалдан авагч урт хугацаанд гэрээнээс татгалзах эсвэл хохирол нэхэмжлэх эрхтэй байх нь худалдагчийг эрсдэлтэй байдалд оруулж, зөвхөн худалдан авагч өөрт ашигтай сонголтыг хийх боломжийг бүрдүүлдэг учраас худалдааны хуульд энэ байдлыг халжээ. Түүнчлэн худалдаачин болох худалдан авагч нь хэрэглэгчтэй харьцуулахад доголдлыг танин мэдэх боломж өндөр тул гэрээний зүйлийг хүлээн авах үедээ шалган авах, доголдол байвал мэдэгдэх үүргийг бий болгожээ. Түүнчлэн худалдааны хуульд мэдэгдлийг илгээснээр эрх зүйн дагавар үүсдэг зарчмыг хэрэглэсэн байна.			
5	Худалдан авагчийн гэрээний зүйлийг хадгалах, хадгалалтад өгөх үүрэг	§527.1.Өмнөх зүйлийн 1 дэх заалтад заасан тохиолдолд худалдан авагч нь гэрээнээс татгалзсан байсан ч худалдагчийн зардлаар гэрээний зүйлийг хадгалах эсвэл хадгалалтад өгөх үүрэгтэй. Гэхдээ гэрээний зүйл устаж эсвэл муудах болзошгүй бол шүүхийн зөвшөөрлөөр гэрээний зүйлийг дуудлага худалдаагаар худалдаж үнийг хадгалах, эсвэл хадгалалтад өгнө. §528.1.Өмнөх зүйлийн зохицуулалт	§545.1 Талуудын нэг нь гэрээнээс татгалзах эрхээ хэрэгжүүлсэн бол талууд тус бүр нөгөө талаа өмнөх байдалд нь оруулах үүрэгтэй. Гэхдээ гуравдагч этгээдийн эрхийг зөрчиж болохгүй.

	нь худалдагчаас худалдан авагчид шилжүүлсэн эд зүйл нь захиалсан эд зүйлээс ялгаатай тохиолдолд тухайн худалдагчаас худалдан авагчид шилжүүлсэн эд зүйл болон худалдагчаас худалдан авагчид шилжүүлсэн эд зүйлийн тоо, хэмжээ нь захиалсан тоо, хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд тухайн хэтэрсэн хэсгийн тоо, хэмжээний эд зүйлд нэгэн адил үйлчилнэ.	
--	---	--

Иргэний хуулиар талууд гэрээнээсээ татгалзсан бол зөвхөн авсан зүйлээ буцаах үүрэг хүлээж байгаа бол худалдааны хуулиар үүн дээр нэмээд шилжүүлж авсан зүйлээ хадгалах, хадгалалтад шилжүүлэх үүргийг худалдан авагчид хүлээлгэжээ. Учир нь худалдааны хэлцэлд худалдагч нь зардал, хугацаа зарцуулан эд зүйлийг буцаан авахаас илүүтэй гэрээний зүйлийг байгаа газар нь худалдсан нь ашигтай байх тохиолдол олон байдаг болохоор ажээ.

Тээвэрлэлт болон хадгалалт нь бусдын аж ахуйн үйл ажиллагааг дэмжих шинжтэй аж ахуйн үйл ажиллагаа болно. Тээвэрлэлт болон хадгалалт нь аж ахуйн үндсэн үйл ажиллагаа болж хийгдэж байвал худалдааны хэлцэл болно (§502.4, §502.10). Тээвэрлэлт нь талуудын хооронд байгаа зайг даван туулан холбох, хадгалалт нь талуудын хооронд дахь цаг хугацааны зөрүүг даван туулах чиг үүрэгтэй юм.

4.2.2 ТЭЭВЭРЛЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тээвэрлэлт нь эд зүйл болон хүнийг газар зүйн хувьд шилжүүлэх юм. Энэ нь нийгэм оршин тогтнох, хөгжихөд дутагдаж болохгүй амин чухал үүргийг гүйцэтгэж байдаг. Тээвэрлэлт нь ямар замаар хийгдэж байгаагаас хамаараад хуурай газрын тээвэр, далайн тээвэр, агаарын тээвэр гэсэн 3 төрөлд хуваагдана. Ямар төрлөөсөө хамаараад зохицуулалт нь ялгаатай болохыг доорх хүснэгтээс харж болно.

№	ТӨРӨЛ	ЗОХИЦУУЛАЛТ
1	Хуурай газрын тээвэр	Худалдааны хуулийн §569
2	Далайн тээвэр	Худалдааны хуулийн §737, 1957 онд батлагдсан Олон улсын далай дахь ачаа тээвэрлэлтийн хууль /Уг хууль нь 1924 онд Брусельд батлагдсан “Ачааны дагалдах бичигтэй холбогдох зохицуулалтын нэгдмэл байдлыг хангах олон улсын гэрээ”-нд тулгуурласан хууль юм. 船荷証券に関するある規則の統一のための国際条約./
3	Агаарын тээвэр	Олон улсын агаарын тээврийн Варшавын гэрээнээс бусад зохицуулалт нь нийтийн эрх зүйн хэм хэмжээ байна.

Уг судалгааны хүрээнд хуурай газрын тээвэрлэлтийн талаар авч үзнэ. Худалдааны хуулийн §569.1-т “Тээвэрлэгч гэдэгт хуурай газар эсвэл нуур, гол, усан зогсоол, боомт дахь ачаа эсвэл зорчигч тээвэрлэлтийг аж ахуйн үйл ажиллгаагаа болгодог этгээдийг хэлнэ” гэж заажээ. Уг заалтаас хуурай газрын тээвэрлэлт гэх ойлголт өргөн хүрээтэй байх бөгөөд

газраар хийх тээвэрлэлтээс гадна нуур, гол, усан зогсоол, боомт дахь тээвэрлэлт орж буйг харж болно.

Ачаа тээвэрлэлтийн гэрээ нь ачаа илгээгч болон тээвэрлэгчийн хооронд байгуулагдана. Ачааг хүлээн авагч нь гэрээний тал болохгүй. Харин §583.1-т “Ачаа хүрэх газартаа ирсний дараа ачаа хүлээн авагч нь тээвэрлэлтийн гэрээний дагуу үүсэх ачаа илгээгчийн эрхийг эдэлнэ” гэж заасны дагуу ачаа илгээгчийн эрхийг олж авдаг байна. Тээвэрлэлтийн гэрээгээр тээвэрлэгч нь ачааг хүргэх газар хүртэл тээвэрлэх үүрэг хүлээнэ. Энэ утгаараа тээвэрлэлтийн гэрээ нь ажил гүйцэтгэх гэрээний нэг төрөл болдог.

№	АЧАА ТЭЭВЭРЛЭЛТИЙН ГЭРЭЭ	
	ТЭЭВЭРЛЭГЧИЙН ҮҮРЭГ	ЗОХИЦУУЛАЛТ
1	Ачааны бичиг /an inland bill of lading / өгөх үүрэг 貨物引換証交付義務	§571.1 Тээвэрлэгч нь ачаа илгээгчийн шаардлагаар ачааны бичгийг гаргаж өгнө. §571.2 Ачааны бичигт дараах агуулгыг тусгаж тээвэрлэгч нь гарын үсэг зурсан байхыг шаардана. 1. Ачааны төрөл, тоо хэмжээ, эзлэхүүн болон баглаа боодлын төрөл, баглаа боодлын тоо, тэмдэг, хүрэх газар, ачаа хүлээн авагчийн нэр, барааны тэмдэг 2. Ачаа илгээгчийн нэр, барааны тэмдэг 3. Тээвэрлэлтийн төлбөр 4. Ачааны бичгийг үйлдсэн газар болон үйлдсэн он сар өдөр
Худалдааны хуулийн 570-р зүйлд зааснаар тээвэрлэгчийн хүсэлтээр ачаа илгээгч нь дараах агуулгыг тусган гарын үсгээ зуран тээвэрлэлтийн илгээх бичиг/ 運送状 / гаргах шаардлагатай байдаг. Үүнд: ачааны төрөл, тоо хэмжээ, эзлэхүүн, баглаа боодлын тоо, тэмдэг, хүрэх газар, ачаа хүлээн авагчийн нэр, барааны тэмдэг, саналыг үйлдсэн газар, он сар өдрийг тусгах шаардлагатай байна. Илгээх бичиг болон ачааны бичиг аль аль нь гэрээ байгуулах чиг үүрэг гүйцэтгэхгүй. Илгээх бичиг нь нотлох баримт болох бол ачааны бичиг нь тээвэрлэгч ачааг хүлээн авсныг нотлох мөн зөвшөөрлийн үнэт цаас болно. Тээвэрлэлт хийхэд цаг хугацаа зарцуулах тул энэ хугацаанд ачаа илгээгч нь ачааг худалдах, барьцаалах боломжийг үнэт цаас болох ачааны бичиг олгоно.		
2	Ачаа илгээгчийн зааврыг дагах үүрэг 運送人の指図に従う義務	§582.1 Ачаа илгээгч болон ачааны бичигтэй этгээд нь тээвэрлэгчийн эсрэг тээвэрлэлтийг зогсоох, ачааг буцаах болон бусад арга хэмжээ авах шаардлага гаргаж болно. Уг тохиолдолд тээвэрлэгч нь гүйцэтгэсэн тээвэрлэлтэй тэнцэх хэмжээний төлбөр, бусдын өмнөөс төлсөн хураамж, зааварласан арга хэмжээг авахтай холбоотой гарсан зардлыг шаардах эрхтэй.
Уг зохицуулалт нь тээвэрлэлт хийгдэж байхад нөхцөл байдал өөрчлөгдсөн бол тухайн өөрчлөлттэй уялдуулан шийдвэр гаргах боломжийг ачаа илгээгчид олгосон зохицуулалт юм. Нөгөө талаас энэхүү зохицуулалт нь тээвэрлэгчийн ашиг сонирхлыг хамгаалах зохицуулалт мөн болдог. Тухайлбал ачааг буцаах гэдгийг хүргэх газраас эргүүлээд ачуулсан газарт авчрах гэж ойлгохгүй бөгөөд заавар өгсөн газарт тухайн ачааг ачаа илгээгчид шилжүүлэн өгөх гэж ойлгоно. Ийнхүү шилжүүлэн өгөхдөө тээвэрлэгч нь гүйцэтгэсэн тээвэрлэлтэй тэнцэх хэмжээний төлбөр, бусдын өмнөөс төлсөн хураамж,		

зааварласан арга хэмжээг авахтай холбоотой гарсан зардлыг шаардах эрхтэй юм. Ачааг анх ачуулсан газарт буцаах заавар нь шинэ тээвэрлэлтийн гэрээний санал болно.		
3	Хохирол нөхөн төлөх хариуцлага 損害賠償責任	§577.1 Тээвэрлэгч нь өөрөө эсвэл тээвэр зуучлагч мөн түүний ажилтан болон тээвэрлэлтэд туслалцаа авсан этгээд ачааг хүлээн авах, шилжүүлэх, хадгалах болон тээвэрлэхдээ анхаарал болгоомжтой байсныг нотолсноос бусад тохиолдолд ачаанд үүссэн хорогдол, хохирол мөн хугацаа хожимдсоны улмаас үүссэн хохирлыг хариуцан арилгана.
Иргэний хуулийн 415-р зүйлийн 1 дэх хэсэгт “үүрэг гүйцэтгэгч нь үүргийн мөн чанарт нийцүүлэн үүргээ гүйцэтгээгүй бол үүрэг гүйцэтгүүлэгч нь үүссэн хохирлыг арилгахыг шаардах эрхтэй. Үүрэг гүйцэтгэгчийн гэм буруугаас болж үүрэг гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд мөн адил байна” гэсэн заалтыг өргөжүүлсэн заалт гэж үздэг бөгөөд иргэний хуулийн уг зохицуулалт нь үүргийн гүйцэтгэлд туслагчийн анхааралгүй үйлдлийн улмаас үүсэх хохирол нь үүргийн гүйцэтгэлтэй холбоотой үүссэн байх шаардлагатай байх ёстой бол худалдааны хуулийн дагуу үүрэг гүйцэтгэх үед л үүссэн бол бүхий л хохирлыг хамааруулж үздэг байна. Өмнө нь уг заалтыг Ромын эрх зүйгээс эхтэй ресептум /receptum, レセプトム/ гэх ойлголтыг агуулга болгож буй зохицуулалт гэж үздэг байжээ. Уг ойлголт нь тээвэрлэгч эсвэл буудлын эзэн нь ачаа илгээгч, зочдоос хүлээн авсан ачаа болон гар тээшийг ресептум буюу хүлээн авсан л бол буцаан өгөх үүрэгтэй бөгөөд давагдашгүй хүчний улмаас устаж үгүй болсон, хохирол учирсны хариуцлагаас чөлөөлөгдөхгүй гэж авч үздэг ойлголт юм.		
4	Нөхөн төлөх хохирлын хэмжээ 損害賠償額	§580.1 Ачаа бүхэлдээ устаж үгүй болсон тохиолдолд хохирол нөхөн төлүүлэх хэмжээг ачаа хүргэгдэх газрын ачаа хүргэгдэх ёстой өдрийн үнээр тооцно. §580.2 Ачааны зарим хэсэг нь устаж эсвэл хохирол учирсан тохиолдолд хохирол нөхөн төлүүлэх хэмжээ нь ачаа хүргэгдэх газрын ачаа хүлээлгэн өгсөн өдрийн үнээр тооцно. Гэхдээ хугацаа хожимдуулсан бол өмнөх заалтын зохицуулалт нэгэн адил үйлчилнэ. §581.1 Ачаа нь тээвэрлэгчийн санаатай эсвэл илт болгоомжгүй үйлдлийн улмаас устаж үгүй болсон, хохирол үүссэн, хугацаа хожимдсон бол тээвэрлэгч бүхий л хохирлыг барагдуулах үүрэг хүлээнэ.
Иргэний хуулийн 416-р зүйлийн 1 дэх хэсэгт “үүргээ гүйцэтгээгүйн улмаас үүссэн хохирлын шаардлага нь үүний улмаас ердийн нөхцөлд үүсэж болох хохирлыг арилгуулахыг зорилгоо болгоно” гэж зааж өгсөн. Тус зүйлийн 2 дахь хэсэгт “Онцгой нөхцөл байдлын улмаас үүссэн хохирол байсан ч талууд тухайн нөхцөл байдлыг урьдчилан харсан эсвэл урьдчилан харах боломжтой тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч нь хохирлоо шаардаж болно” гэж заан гэрээний эрх зүйн харилцаанаас үүдэлтэй хохирол шаардах хүрээг тодорхойлж өгсөн байдаг. Харин худалдааны хуулийн уг зохицуулалт нь хохирлын хэмжээг хуулиар тодорхой зааж өгч буй юм. Өөрөөр хэлбэл бодитоор учирсан хохирол их байсан ч хуульд заасан хэмжээгээр хохирлыг нөхөн төлөхөд хангалттай бөгөөд бодитоор учирсан хохирол бага байсан ч хуульд заасан хэмжээгээр хохирлыг барагдуулах шаардлагатай болно. Худалдааны хуулийн §581.1 нь тээвэрэгчийн санаатай эсвэл илт болгоомжгүй үйлдлийн улмаас хохирол бий болсон бол хуульд заасан хэмжээгээр бус бодитоор учирсан хохирлыг		

шаардах боломжтой болгож байна.		
5	Өндөр үнэтэй эд зүйлийг тээвэрлэх	§578.1 Мөнгө, үнэт цаас болон бусад өндөр үнэтэй ачааг ачаа илгээгч нь тээвэрлүүлэхдээ төрөл болон үнийг тодорхой мэдэгдээгүй бол ачаа тээвэрлэгч нь хохирлыг нөхөн төлөхөөс чөлөөлөгдөнө.
Өндөр үнэ бүхий эд зүйл нь хулгай, дээрэмд өртөх өндөр эрсдэлтэй тул ачаа илгээгч нь тээвэрлэгчид тодорхой мэдэгдээгүй бол ачаанд үүссэн хохирлыг шаардах эрхгүй юм. Хэрвээ өндөр үнэ бүхий зүйл байгаа гэдгийг мэдэгдсэн бол тээвэрлэгч онцгой анхаарал тавих, даатгал хийлгэх, тээвэрлэлтийн зардлаа нэмэгдүүлэх гэх мэт арга хэмжээ авах боломжтой учраас энэ талаар мэдэгдэхийг ачаа илгээгчид үүрэг болгосон байна.		
6	Тээвэрлэгчийн хариуцлагыг чөлөөлөх зохицуулалт	§588.1 Тээвэрлэгчийн хариуцлага нь ачаа хүлээн авагч ямар нэг гомдлын шаардлага гаргалгүйгээр ачааг хүлээн аван тээвэрлэлтийн болон бусад зардлыг төлсөн тохиолдолд дуусгавар болно. Гэхдээ хохирол болон зарим хэсэг нь утсаныг шууд илрүүлэх боломжгүй ачааг шилжүүлсэн өдрөөс хойш 2 долоо хонгийн дотор тээвэрлэгчид мэдэгдвэл тээвэрлэгчийн хариуцлага дуусгавар болохгүй. §588.2 Өмнөх заалтын зохицуулалт ачааны хохирол болон зарим хэсэг нь утсан талаар тээвэрлэгч мэдэж байсан тохиолдолд хэрэглэгдэхгүй. §589.1 Энэ хуулийн 562, 563, 566, 567-р зохицуулалт нь тээвэрлэгчид нэгэн адил үйлчилнэ. §566.1 Тээвэр зуучлагчийн хариуцлага ачаа хүлээн авагч нь ачаа хүлээн авсан өдрөөс хойш нэг жил өнгөрвөл хөөн хэлэлцэх хугацааны дагуу дуусгавар болно. §566.2 Өмнөх заалтад тусгасан хугацааг ачаа бүхэлдээ утсан тохиолдолд шилжүүлэн өгөх ёстой өдрөөс тоолно. §566.3 Өмнөх 2 заалт нь тээвэр зуучлагч гэмтэл хорогдлын талаар мэдэж байсан тохиолдолд үйлчлэхгүй.
Эдгээр зохицуулалт нь тээвэрлэгчид ашигтай зохицуулалт бөгөөд удаан хугацааны турш эрх зүйн тодорхойгүй байдал үргэлжлэхээс тээвэрлэгчийг хамгаалах зорилготой юм. Гэхдээ тээвэрлэгч гэмтэл хорогдлын талаар мэдэж байсан бол хариуцлагаас чөлөөлөхгүй байхаар хуульчилж өгчээ.		

Зоригч тээвэр ачаа тээвэрлэлтээс ялгаатай нь хүнийг тээвэрлэж буй тул тээвэрлэгч тээвэрлэж буй зүйлээ эзэмшинэ гэсэн ойлголт байдаггүй.

№	ЗОРЧИГЧ ТЭЭВЭРЛЭЛТ	
	ТЭЭВЭРЛЭГЧИЙН ҮҮРЭГ	ЗОХИЦУУЛАЛТ
1	Зорчигчийн өмнө хүлээх хариуцлага 旅客に対する責任	§590.1 Зорчигч тээвэрлэгч нь өөрөө эсвэл түүний ажилтан тээвэрлэлт хийхдээ анхаарал болгоомжтой байсан гэдгээ нотолсноос бусад тохиолдолд зорчигчид үүссэн хохирлыг барагдуулах үүрэгтэй. §590.2 Шүүхээс хохирлын хэмжээг тогтоохдоо хохирогч болон түүний гэр бүлийн нөхцөл байдлыг харгалзан үзнэ.
Худалдааны хуулийн §590.1 нь ерөнхий зохицуулалт болох Иргэний хуулийн §415.1-ийг		

дахин бататгасан зохицуулалт бөгөөд агуулгын хувьд ялгаагүй юм. Харин Худалдааны хуулийн §590.2 нь Иргэний хуулийн §416.2-ийн тусгай зохицуулалт болно. Учир нь зорчигчийн амь нас, эрүүл мэндэд учирсан хохирлыг тээвэрлэгч урьдчилан харах боломжгүй байсан ч төлүүлэхийг зорьж буй зохицуулалт юм.		
2	Зорчигчийн тээшин учирсан хохирлыг хариуцах 手荷物に関する責任	§591.1 Зорчигч тээвэрлэгч нь зорчигчоос хүлээн авсан тээшийг төлбөртэй тээвэрлэж буй эсэхээс үл хамааран ачаа тээвэрлэгчтэй нэгэн адил хариуцлага хүлээнэ. §591.2 Тээшийг хүргэх газарт хүргэх ёстой өдрөөс нэг долоо хонгийн дотор зорчигч тээшээ авахаар шаардлагаа гаргаагүй бол энэ хуулийн 524-р зүйл нэгэн адил үйлчилнэ. Гэхдээ зорчигчийн оршин суугаа болон байгаа хаяг нь тодорхойгүй бол зорчигчид чиглэсэн мэдэгдэл хийх, мэдэгдэх шаардлагагүй.
Тээшийг тээвэрлэгчид шилжүүлэн өгснөөр зорчигч тээвэрлэлтийн гэрээнээс гадна ачаа тээвэрлэлтийн гэрээ байгуулагддаг байна. Гэхдээ ачаа тээвэрлэлтийн гэрээний бүхий л зохицуулалт хэрэглэгдэхгүй бөгөөд зөвхөн хохирол арилгахтай холбоотой зохицуулалтыг хэрэглэнэ.		

4.2.3 АГУУЛАХЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тээвэрлэлт нь эд баялгийн эргэлт орон зайг дамжин явагдахад гол үүрэгтэй бол, хадгалалт нь эд баялгийн эргэлтийг цаг хугацааны хувьд холбоход гол үүрэг гүйцэтгэдэг. Иргэний болон худалдааны хууль аль алинд нь хадгалалтын гэрээ (寄託契約)-ний талаар зохицуулсан байна. Хадгалалтын үйл ажиллагааг аж ахуйн үйл ажиллагаагаа болгож буй тохиолдолд худалдааны хуулийн §502-р зүйлийн 10 дахь хэсэгт заасан аж ахуйн шинжтэй худалдааны хэлцэл болно.

Агуулахын үйл ажиллагаа эрхлэхийн тулд Агуулахын үйл ажиллагааны хууль (倉庫営業法²⁸) -д заасны дагуу Дэд бүтцийн сайдаас зөвшөөрөл авах шаардлагатай болдог.

№	АГУУЛГА	ХУДАЛДААНЫ ХУУЛЬ	ИРГЭНИЙ ХУУЛЬ
1	Гэрээний шинж	§593.1 Аж ахуйн үйл ажиллагааныхаа хүрээнд хадгалалтын үйл ажиллагаа явуулж байгаа худалдаачин нь хариу төлбөр аваагүй байсан ч хадгалж буй эд зүйлээ хамгаалах үүрэг хүлээнэ. §594.1 Буудал, зоогийн газар, халуун усны газар болон бусад үйлчлүүлэгч олноороо цуглардаг газрын эзэн нь үйлчлүүлэгчээс эд зүйлийг хадгалахаар авсан дараа тухайн эд зүйл устаж үгүй	§657.1 Талуудын нэг тал нь нөгөө талын төлөө хадгалахаа амлаж эд зүйлийг хүлээн авснаар хадгалалтын гэрээний үр дагавар үүснэ.

²⁸ Warehouse Business Act - 1956 онд агуулахын үйл ажиллагааны зохистой байдлыг хангах, агуулахын баримтын баталгаат байдлыг хангах зорилгоор батлагдсан хууль.

		болсон эсвэл хохирол учирсан нь давагдашгүй хүчин зүйлийн улмаас болсон гэдгийг нотлох хүртэл хохирол нөхөн төлөх хариуцлагаас чөлөөлөгдөхгүй.	
Иргэний хуульд заасан хадгалалтын гэрээ нь хадгалуулах эд зүйлийг шилжүүлснээр байгуулагддаг гэрээ бол худалдааны хуульд заасан хадгалалтын гэрээ нь тохиролцсоноор байгуулагдана гэж олонх судлаачид үздэг байна.			
2	Хадгалах хугацаа	§619.1 Талууд хадгалах хугацааны талаар харилцан тохиролцоогүй тохиолдолд агуулахын үйл ажиллагаа эрхлэгч нь эд зүйлийг хадгалсан өдрөөс 6 сарын хугацаа өнгөртөл буцаах эрхгүй, гэхдээ хүндэтгэн үзэх шалтгаан байх тохиолдолд энэ заалт үйлчлэхгүй.	§663.1 Талууд эд хөрөнгийн хадгалах хугацааны талаар харилцан тохиролцоогүй бол хадгалагч нь хэзээ ч эд зүйлийг буцаан өгч болно. §663.2 Буцаан өгөх хугацааны талаар тохиролцсон бол хадгалагч нь хүндэтгэн үзэх шалтгаангүй бол тухайн хугацаанаас өмнө буцаах боломжгүй.
Худалдааны хуульд талууд хадгалах хугацааны талаар тохиролцоогүй тохиолдолд 6 сар гэсэн тодорхой хугацааг хуульчилж өгсөн байна. Энэ нь хадгалуулагчийг хамгаалах зорилготой бөгөөд агуулахын үйл ажиллагаа явуулдаг этгээдэд эд зүйл хадгалуулж байгаа нь тодорхой хугацаанд эд зүйлийг хадгалуулах гэсэн хадгалуулагчийн хүсэл зоригийг илтгэдэг байна.			
3	Хадгалалтын гэрээний онцлог	Худалдааны хуульд тусгай зохицуулалт байхгүй.	§658.1 Хадгалагч нь хадгалуулагчаас зөвшөөрөл аваагүй бол хадгалуулсан эд хөрөнгийг ашиглах, эсвэл гуравдагч этгээдэд хадгалуулж болохгүй. §658.2 105-р зүйл болон 107-р зүйлийн 2 дахь хэсгийн заалт хадгалагч нь гуравдагч этгээдэд эд хөрөнгийг хадгалуулж болох тохиолдолд нэгэн адил үйлчилнэ.
Хадгалуулагчаас хадгалагчтай хадгалалтын гэрээ байгуулах үндсэн шалтгаан нь агуулахын байршил, байгууламж, хадгалагчийн төлбөрийн чадамж байдаг тул тусгайлан тохиролцоогүй бол агуулахын үйл ажиллагаа эрхлэгч нь хадгалахаар хүлээн авсан эд хөрөнгийг бусад агуулахын үйл ажиллагаа эрхлэгчээр хадгалуулахыг хохирдог байна.			
4	Хадгалуулагчийн буцаан шаардах эрх	Худалдааны хуульд тусгай зохицуулалт байхгүй.	§662.1 Талууд хадгалах эд зүйлийг буцаан шилжүүлэх хугацаа тогтоосон байсан ч хадгалуулагч нь хэзээ ч буцаан шаардаж болно.

Хадгалалтын гэрээнд хадгалуулагч нь хүссэн үедээ хадгалуулсан эд зүйлээ буцаан шаардан авах эрхтэй.		
5	Агуулахын баримт	§598.1 Агуулахын үйл ажиллагаа эрхлэгч нь хадгалуулагчийн хүсэлтээр хадгалуулсан эд зүйлийн хадгалах бичиг /預り証 -deposit receipt/ болон барьцааны бичиг/ 質入証券 -pledge receipt/-ийг олгоно. §627.1 Агуулахын үйл ажиллагаа эрхлэгч нь хадгалуулагчийн хүсэлтээр хадгалах бичиг болон барьцааны бичгийн оронд агуулахын баримт /倉荷証券 -warehouse receipt/-ыг олгоно.
Иргэний хуульд зохицуулалт байхгүй.		
Япон улсын худалдааны практикт хадгалах бичиг болон барьцааны бичиг нь ашиглагддаггүй бөгөөд агуулахын баримтыг голчлон ашигладаг байна. Агуулахын баримт нь эд хөрөнгийг агуулахад хадгалж байх зуур тухайн эд хөрөнгийг худалдах, барьцаалах боломжийг хадгалуулагчид олгодог санхүүгийн хэрэгсэл болно.		
6	Хадгалуулагчийн хяналт тавих эрх	§616.1 Хадгалуулагч болон хадгалах бичиг эзэмшигч нь ажлын цагт агуулахын үйл ажиллагаа эрхлэгчээс хадгалуулж буй зүйлээ шалгах, дээж авах болон хадгалахтай холбоотой шаардлагатай арга хэмжээг авч болно. §627.2 Агуулахын баримтанд хадгалах бичгийн зохицуулалт нэгэн адил үйлчилнэ.
Иргэний хуульд зохицуулалт байхгүй.		
Хадгалуулагчийн энэхүү эрх нь хадгалалтад хяналт тавих боломжийг олгож түүний ашиг сонирхлыг хамгаалахад үйлчилдэг. Хадгалуулсан зүйлийг худалдах үед худалдан авагч нь агуулахад хадгалагдаж буй эд хөрөнгийг агуулахын баримт эзэмшигчийн хувьд шалгах боломжийг олгоно.		
7	Хохирол нөхөн төлөх үүрэг	§617.1 Агуулахын үйл ажиллагаа эрхлэгч өөрөө эсвэл түүний ажилтан нь эд хөрөнгийн хадгалахдаа анхаарал болгоомжтой байх үүргээ гүйцэтгэсэн гэдгээ нотлох хүртэл эз хөрөнгө устаж үгүй болсон хорогдсоны хохирлыг арилгах үүргээс чөлөөлөгдөхгүй.
Хохирол нөхөн төлөх үүрэг		§416.1 Үүргээ гүйцэтгээгүйн улмаас үүссэн хохирлын шаардлага нь үүний улмаас ердийн нөхцөлд үүсэж болох хохирлыг арилгуулахыг зорилгоо болгоно. §416.2 Онцгой нөхцөл байдлын улмаас үүссэн хохирол байсан ч талууд тухайн нөхцөл байдлыг урьдчилан харсан эсвэл

			урьдчилан харах боломжтой тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч нь хохирлоо шаардаж болно.
Худалдааны хууль уг заалт иргэний хуулийн гэрээний үүргийн зөрчлөөс үүдэх хохирол шаардах эрхийн зохицуулалтын агуулгыг давтсан агуулгатай. Гэвч уг зохицуулалт заавал дагаж мөрдөх шинжгүй заалт гэж үздэг учир практикт өөрөөр тохиролцох байдал олонтоо ажээ. Ихэнхи стандарт гэрээнд хохирол нь үйл ажиллагаа эрхлэгч болон түүний ажилтны санаатай эсвэл илт болгоомжгүй үйлдлийн улмаас үүссэн гэдгийг хадгалуулагч тал нотлохоос нааш агуулахын үйл ажиллагаа эрхлэгч нь хариуцлага хүлээхгүй байхаар зохицуулалт хийгддэг байна.			
8	Хариуцлагаас чөлөөлөгдөх онцгой тохиолдол	§625.1 Агуулахын үйл ажиллагаа эрхлэгчид энэ хуулийн 588-р зүйлийн заалт нэгэн адил үйлчилнэ. 588.1Тээвэрлэгчийн хариуцлага нь ачаа хүлээн авагч ямар нэг гомдлын шаардлага гаргалгүйгээр ачааг хүлээн аван тээвэрлэлтийн болон бусад зардлыг төлсөн тохиолдолд дуусгавар болно. Гэхдээ хохирол учирсан болон зарим хэсэг нь утсаныг шууд илрүүлэх боломжгүй ачааг шилжүүлсэн өдрөөс хойш 2 долоо хонгийн дотор тээвэрлэгчид мэдэгдвэл тээвэрлэгчийн хариуцлага дуусгавар болохгүй. §588.2 Өмнөх заалтын зохицуулалт ачааны хохирол болон зарим хэсэг нь утсан талаар тээвэрлэгч мэдэж байсан тохиолдолд хэрэглэгдэхгүй.	Иргэний хуульд зохицуулалт байхгүй.
Эдгээр зохицуулалт нь агуулахын үйл ажиллагаа эрхлэгчид ашигтай зохицуулалт бөгөөд удаан хугацааны турш эрх зүйн тодорхойгүй байдал үргэлжлэхээс түүнийг хамгаалах зорилготой юм.			
9	Хөөн хэлэлцэх хугацаа	§626.1 Хадгалуулсан эд хөрөнгө устаж үгүй болсон эсвэл хохирол учирсны дагуу үүссэн агуулахын үйл ажиллагаа эрхлэгчийн хариуцлага нь агуулахаас гаргасан өдрөөс 1 жил өнгөрсөн бол хөөн хэлэлцэх хугацааны дагуу дуусгавар болно.	

		§626.2 Өмнөх заалтын хугацааг хадгалуулсан эд зүйл бүхэлдээ устсан тохиолдолд агуулахын үйл ажиллагаа эрхлэгч нь хадгалах бичиг эзэмшигчид эсвэл эзэмшигч нь мэдэгдэхгүй бол хадгалуулагчид эд хөрөнгө бүхэлдээ устсаныг мэдэгдлийг илгээсэн өдрөөс эхлэн тоолно. §626.3 Өмнөх 2 заалтын зохицуулалт нь агуулахын үйл ажиллагаа эрхлэгч мэдэж байсан бол хэрэглэгдэхгүй.	
Худалдааны хуульд ерөнхий хөөн хэлэлцэх хугацааг богиносгож 1 жил гэж хуульчилж буй нь аж ахуй эрхлэгчийн хувьд удаан хугацааны турш эрх зүйн тодорхойгүй байдал үргэлжлэхээс хамгаалж байгаа болно.			

4.2.4 ХУДАЛДААНЫ ЗУУЧЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Аж ахуйн үйл ажиллагаа өргөжин тэлэхийн хэрээр түүнийг үр дүнтэй явуулах үүднээс аж ахуй эрхлэгчээс ангид, бие даасан худалдаачны хувиар аж ахуйн үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх этгээд оршин байх нь зайлшгүй шаардлагатай болжээ.

№	ХУДАЛДААНЫ ЗУУЧЛАЛЫН ГЭРЭЭ	
	ХУДАЛДААНЫ ЗУУЧЛАГЧ	ЗОХИЦУУЛАЛТ
1	Худалдааны зуучлагч 商事仲立人	§543.1 Зуучлагч гэж бусдын хооронд хийгдэх худалдааны хэлцлийн зуучлалыг үйл ажиллагааг болгож буй этгээдийг хэлнэ.
Худалдааны хэлцэлд зуучилж байгаа этгээдийг худалдааны зуучлагч гэх бөгөөд худалдааны бус хэлцэлд зуучилж байвал худалдааны зуучлагч болохгүй.		
2	Зуучлагчийн дээж хадгалах үүрэг 見本品保管義務	§545.1 Зуучлагч нь зуучилж буй хэлцэлтэйгээ холбоотойгоор дээж хүлээн авсан бол хэлцэл дуусгавар болох хүртэл хадгалах шаардлагатай.
Талуудын хооронд гэрээний зүйлийн чанарын талаар маргаан гарсан бол нотлох баримт үлдсэн маргаанаас урьдчилан сэргийлэх зорилгоор уг зохицуулалтыг бий болгожээ. Иймд зуучлагч нь баттайгаар маргаан гарахгүй боллоо гэх хүртэл дээжийг хадгалах үүрэг хүлээдэг байна.		
3	Зуучлагчийн баримт олгох үүрэг 結約書交付義務	§546.1 Талуудын хооронд хэлцэл хийгдсэн бол зуучлагч нь нэн даруй талуудын нэр, худалдааны тэмдэг, хэлцэл хийгдсэн он сар өдөр болон хэлцлийн агуулгыг тодорхойлсон баримтыг үйлдэж талуудад олгоно. §546.2 Талууд үүргээ шууд биелүүлэхээс бусад хэлцэлд зуучлагч нь өмнөх заалтад дурдсан баримтад талуудаар гарын үсэг зуруулан нөгөө талд нь олгоно. §546.3 Өмнөх 2 заалтын тохиолдолд талуудын нэг тал нь

		баримтыг хүлээн аваагүй, гарын үсэг зураагүй бол зуучлагч нь нэн даруй нөгөө талд мэдэгдэл илгээх шаардлагатай.
Зуучлагчийн үйлдэж буй баримт нь гэрээ биш боловч зуучлагчийн баримт нь гэрээ болно гэж давхацуулж болно.		
4	Зуучлагчийн бүртгэл хөтлөх, хуулбар олгох үүрэг 仲立人日記帳の作成・謄本交付義務	§547.1 Зуучлагч нь бүртгэлийн дэвтэртээ өмнөх зүйлийн 2 дахь хэсэг заасан агуулгыг тэмдэглэх шаардлагатай. §547.2 Талууд зуучлагчаас өөрсдийнхөө зуучлуулсан хэлцэлтэй холбоотой бүртгэлийн дэвтрийн хуулбарыг олгохыг хэзээ ч шаардаж болно.
Зуучлагчид бүртгэл хөтлөх шаардлага тавьж буй нь эрх зүйн харилцааг тодорхой болгож маргаанаас урьдчилан сэргийлэх чиг үүрэгтэй байна.		
5	Нэр нууцлах үүрэг 氏名黙秘義務	§548.1 Талууд өөрийн нэр болон худалдааны тэмдгийг нөгөө талдаа илэрхий болгохыг зуучлагчид хориглосон бол 546-р зүйлийн 1 дэх хэсгийн баримт болон өмнөх зүйлийн 2 дахь хэсгийн хуулбар дээр нэр болон худалдааны тэмдгийг зааж болохгүй.
6	Зуучлагчийн оролцох үүрэг 仲立人の介入義務	§549.1 Зуучлагч нь талуудын нэг талын нэр болон худалдааны тэмдгийг нөгөө талд нь ил болгоогүй бол нөгөө талын өмнө өөрөө үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээнэ.

Худалдааны зуучлалын гэрээ нь зуучлал гэсэн бодит үйлдлийг худалдааны зуучлагчид даалгавар болгож буй тул Иргэний хуульд хуулийн 656-р зүйлд хуульчлагдсан даалгаврын гэрээ болох бөгөөд Иргэний хуулийн 644-р зүйлийн 1 дэх хэсэгт “Даалгавар гүйцэтгэгч нь даалгаврын зорилгын дагуу шударга туршлага бүхий этгээдийн анхаарал болгоомжоор /善良な管理者の注意をもって/ даалгаврыг гүйцэтгэх үүрэг хүлээнэ” гэж заасны дагуу худалдааны зуучлагч нь худалдааны харилцааны мэргэжлийн оролцогч болохын хувьд өндөр анхаарал болгоомжтой байх үүрэг хүлээдэг.

4.2.5 ХУДАЛДААНЫ КОМИССЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Аж ахуйн үйл ажиллагаа өргөжүүлэхийг хүсэж буй тохиолдолд тухайн газарт салбараа байгуулах, эсвэл төлөөлөгч болон худалдааны төлөөлөгчийг ашиглаж болно. Гэхдээ эдгээр арга нь зардал өндөртэй байх, төлөөлөгч эрхээ урвуулан ашиглах гэх мэт эрсдэлийг өөртөө агуулж байдаг. Харин худалдааны комиссоор дамжуулж аж ахуйн үйл ажиллагаагаа өргөжүүлэх нь эдгээр эрсдэлээс зайлсхийх хамгийн үр дүнтэй арга юм.

№	ХУДАЛДААНЫ КОМИССЫН ГЭРЭЭ	
	ХУДАЛДААНЫ КОМИСС	ЗОХИЦУУЛАЛТ
1	Худалдааны комисс 問屋	§551.1 Худалдааны комисс гэж өөрийн нэрээр бусдын өмнөөс бараа бүтээгдэхүүнийг борлуулах, худалдан авахыг үйл ажиллагаагаа болгосон этгээдийг хэлнэ. §558.1 Тус бүлгийн заалт нь өөрийн нэрээр бусдын өмнөөс борлуулах, худалдан авахаас бусад хэлцэл хийхийг үйл ажиллагаагаа болгосон этгээдэд нэгэн адил үйлчилнэ. §552.1 Худалдааны комисс нь бусдын өмнөөс хийсэн

		борлуулалт, худалдан авалтын дагуу гэрээний эсрэг талын өмнө эрх олж аван үүрэг хүлээнэ. §552.2 Худалдааны комисс болон үйлчлүүлэгчийн хооронд тус бүлгийн зохицуулалтаас гадна даалгавар болон төлөөлөлтэй холбоотой зохицуулалт нэгэн адил үйлчилнэ.
Худалдааны комисс нь худалдах худалдан авах гэрээний тал болох бөгөөд хууль зүйн хувьд тус гэрээнээс үүсэх эрх үүргийн субъект болдог.		
2	Худалдааны комиссын мэдэгдэх үүрэг 通知義務	§557.1 Энэ хуулийн 27-р зүйл болон 31-р зүйл худалдааны комисст нэгэн адил үйлчилнэ. §27.1 Худалдааны төлөөлөгч нь хэлцэлд төлөөлсөн эсвэл зуучилсан бол нэн даруй худалдаачинд энэ тухай мэдэгдэл илгээх үүрэг хүлээнэ.
Иргэний хуулийн 645-р зүйлийн 1 дэх хэсэгт “Даалгавар гүйцэтгэгч нь даалгавар өгөгчөөс шаардлага гаргасан бол гүйцэтгэж буй даалгаврын нөхцөл байдлын талаар мэдээлэх, даалгаврыг гүйцэтгэсний дараа бол нэн даруй түүний явц болон үр дүнгийн талаар мэдээлэх үүрэгтэй” гэж зааснаас авч үзвэл иргэний хууль дахь мэдэгдэх үүрэг нь даалгавар өгөгч шаардсан үед мэдээлэх бол худалдааны комисс нь шаардлага гарсан эсэхээс үл хамааран мэдээлэл өгөх үүрэг хүлээдэг байна.		
3	Үйлчлүүлэгчийн заасан үнийг дагах үүрэг 指値遵守義務	§554.1 Худалдааны комисс нь үйлчлүүлэгчийн заасан үнээс хямд үнээр борлуулалт хийх эсвэл өндөр үнээр худалдан авалт хийсэн бол өөрөө зөрүүг нь төлсөн бол тухайн борлуулалт, худалдан авалтын үр дагавар үйлчлүүлэгчид үүснэ.
Ердийн нөхцөлд үйлчлүүлэгч нь борлуулалт хийлгэхээр бол хамгийн доод үнийг заах бөгөөд худалдан авалт хийлгэхээр бол хамгийн дээд үнийг заадаг байна. Хэрвээ заасан үнийг зөрчсөн тохиолдолд худалдааны комисс зөрүүг өөрөө хариуцан төлбөл худалдааны комиссын үйл ажиллагааны үр дагавар үйлчлүүлэгчид үүснэ.		
4	Үүргийн гүйцэтгэлийг батлан даах үүрэг 履行担保義務	§553.1 Худалдааны комисс нь үйлчлүүлэгчийн өмнөөс хийсэн борлуулалт, худалдан авалтад эсрэг тал нь үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд өөрөө тухайн үүргийг гүйцэтгэх хариуцлага хүлээнэ. Гэхдээ тусгайлан тохиролцсон эсвэл өөр заншил байгаа тохиолдолд уг заалт үйлчлэхгүй.
Уг зохицуулалт нь үйлчлүүлэгчийг хамгаалах зорилго бүхийн зохицуулалт бөгөөд худалдааны комиссын тогтолцоонд хандах итгэлийг баталгаажуулах чиг үүрэгтэй.		

Худалдааны комиссын гэрээ нь худалдааны комисс болон үйлчлүүлэгчийн хооронд байгуулагдах бөгөөд иргэний хууль дахь даалгаврын гэрээний шинжийг агуулсан гэрээ юм.

4.2.6 ТЭЭВРИЙН КОМИССЫН ГЭРЭЭ

Япон улсын худалдааны хуульд тэвээрийн комиссын гэрээ зөвхөн зохицуулагдсан боловч практикт Тэвэрийн төлөөлөгч, зуучлалын үйл ажиллагаа үйл ажиллагаа идэвхтэй явагддаг бөгөөд Тэвэрийн төлөөлөгч, зуучлалын талаар мөн хуульчлах ёстой гэсэн хандалга илүүтэй байна.

№	ТЭЭВЭР КОМИССЫН ГЭРЭЭ
----------	------------------------------

	ТЭЭВРИЙН КОМИСС	ЗОХИЦУУЛАЛТ
1	Тээврийн комисс 運送取扱人	§559.1 Тээврийн комисс гэж өөрийн нэрээр ачаа Тээврийн комиссын үйл ажиллагааг үйл ажиллагаагаа болгож буй этгээдийг хэлнэ. §559.2 Тээврийн комисст энэ бүлэгт өөрөөр зааснаас бусад тохиолдолд худалдааны комисстой холбогдох зохицуулалт нэгэн адил үйлчилнэ.
Тээврийн комиссын үйл ажиллагаа гэдэгт ачаа Тээврийн комиссын үйл ажиллагааг хэлэх бөгөөд Тээврийн комисс гэж өөрийн нэрээр бусдын зардлаар тээвэрлэлтийн хэлцэл хийхийг үйл ажиллагаагаа болгож буй этгээдийг хэлнэ.		
2	Хохирол 債務不履行責任	§560.1 Тээврийн комисс нь өөрөө эсвэл түүний ажилтан ачааг хүлээн авах, шилжүүлэх, хадгалах, тээвэрлэгч эсвэл өөр тээврийн комиссыг сонгох болон бусад тээвэрлэлттэй холбоотой анхаарал болгоомжтой байх үүргээ биелүүлснээ нотлох хүртэл ачаа устаж үгүй болсон, хорогдсон болон хугацаа хожимдсонтой холбоотой хохирол нөхөн төлөх хариуцлагаас чөлөөлөгдөхгүй.
Энэхүү иргэний хуулийн гэрээний үүргийн зөрчлөөс үүсэх хохирол нөхөн төлөх зохицуулалттай адил агуулгатай бөгөөд түүнийг тодотгож буй зохицуулалт гэж үзэх үзэл нийтлэг байна.		
3	Хэд хэдэн этгээд оролцох тохиолдол	§563.1 Хэд хэдэн этгээд солигдон тээврийн комиссийн үйл ажиллагаа явуулах тохиолдолд залгамжлан авсан этгээд нь өмнөх этгээдийн оронд түүний эрхийг хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.
Дамжуулан тээврийн комиссын үйл ажиллагаа явуулах гэдэгт дамжуулан тээвэрлэх шаардлагатай ачааг тээврийн комисс нь өөрийн нэрээр үйлчлүүлэгчийн зардлаар өөр тээврийн комисстой тээврийн комиссийн гэрээ байгуулахыг хэлдэг.		

4.2.7 САНХҮҮГИЙН ТҮРЭЭСИЙН ГЭРЭЭ

Санхүүгийн түрээс /Financial leasing/ нь санхүүгийн хэлцлийн нэг төрөл юм. Иргэний хуульд заасан эд хөрөнгө хөлслөх гэрээний нэг төрөл болно.

№	ХАРИЛЦАА	ТҮРЭЭСЛЭГЧ	ЛИНЗИНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧ	НИЙЛҮҮЛЭГЧ
1	Түрээсийн зүйлийг сонгох リース物件の選択	Бараа бүтээгдэхүүн лизингээр авах гэж буй этгээд нь нийлүүлэгч буюу борлуулагчтай сонгосон бүтээгдэхүүнээ авахаар тохиролцох бөгөөд		үйлчлүүлэгч болон нийлүүлэгчийн аль нэг нь лизингийн үйл ажиллагаа эрхлэгчид мэдэгдэнэ.

2	Санхүүгийн түрээсийн гэрээ байгуулах リース契約の締結	Лизингийн үйл ажиллагаа эрхлэгч нь түрээслэгчийг судалж үзэн зохистой гэж үзвэл түрээслэгчтэй лизингийн гэрээ байгуулна.	
3	Худалдах худалдан авах гэрээ байгуулах 売買契約		Лизингийн үйл ажиллагаа эрхлэгч нь нийлүүлэгчтэй худалдах худалдан авах гэрээ байгуулна.
4	Түрээсийн зүйлийг шилжүүлэх リース物件の引渡し	Нийлүүлэгч нь түрээслэгчид сонгосон бараа бүтээгдэхүүнийг нь	шилжүүлэн өгнө.
5	Түрээсэлсэн баримт 借受証	Түрээслэгч түрээсийн зүйлийг хүлээн авч шалгаж үзсэний дараа, лизингийн үйл ажиллагаа эрхлэгчид тухайн эд зүйлийг түрээсэлсэн баримтаа гаргаж өгнө.	
6	Үнийг төлөх 代金支払		Түрээсэлсэн баримтыг хүлээн авсан лизингийн үйл ажиллагаа эрхлэгч нь нийлүүлэгчид түрээсийн зүйлийн үнийг бүхэлд нь төлнө.
7	Түрээсийн төлбөрийг шаардах リース料金請求	Гэрээнд заасан тогтмол хугацаанд түрээсийн төлбөрийг төлнө.	

Дээрх хүснэгтэд санхүүгийн түрээсийн харилцааны ерөнхий бүтцийг авч үзсэн бөгөөд санхүүгийн түрээсийн гэрээ нь эд хөрөнгө хөлслөх гэрээний нэг төрөл боловч эд хөрөнгө хөлслөх гэрээний зохицуулалт бүхэлдээ хэрэглэгдэхгүй юм. Учир нь санхүүгийн түрээсийн гэрээ эд хөрөнгө хөлслөх гэрээ болохын сацуу санхүүгийн хэрэгсэл болдог болохоор юм. Тиймээс лизингийн үйл ажиллагаа эрхлэгч нь түрээсийн зүйлийг шилжүүлэх үүрэг хүлээхгүй, мөн түрээсийн зүйлийн доголдолоос үүсэх хариуцлагыг хүлээдэггүй байна.

Түрээсийн төлбөрийг эд хөрөнгө хөлслүүлсний төлбөр гэж үздэггүй бөгөөд лизингийн үйл ажиллагаа эрхлэгчээс түрээслэгчийг санхүүжүүлсний хариу төлбөр гэж үздэг байна. Түүнчлэн түрээслэгч нь гэрээний хугацаанд гэрээнээс татгалзаж түрээсийн төлбөрөөс чөлөөлөгдөх боломжгүй байдаг.

4.2.8 ТООЦОО НИЙЛЭХ ГЭРЭЭ

№	ТООЦОО НИЙЛЭХ ГЭРЭЭ	
	ХУДАЛДААЧИН	ЗОХИЦУУЛАЛТ
1	Тооцоо нийлэх	§529.1 Тооцоо нийлэх гэрээ нь худалдаачин хооронд эсвэл

	гэрээ	худалдаачин болон худалдаачин бус этгээдийн хооронд байнга худалдаа хийх тохиолдолд тодорхой хугацаан дахь худалдаанаас үүсэх эрх болон үүргийн нийт хэмжээг харилцан тооцож түүний үлдэгдлийг төлөхийг тохиролцсоноор түүний үр дагавар үүснэ.
Тооцоо нийлэх гэрээ нь талуудын хоорондын байнгын худалдааны харилцаанаас шаардах эрх, үүрэг үүсэх тохиолдолд тухай бүр үүргийн гүйцэтгэлийг хэрэгжүүлэлгүй тодорхой хугацаа өнгөрсний дараа харилцан шаардах эрх, үүргээ нийтэд нь тооцож дуусгавар болгон, зөвхөн үлдэгдлийн үүргийн гүйцэтгэлийг хэрэгжүүлэх зорилготой гэрээ юм.		
2	Тусгай зохицуулалт	§530.1 Вексель болон бусад арилжааны үнэт цааснаас үүссэн шаардах эрхийг болон үүргийг тооцоо нийлэх гэрээнд хамруулсан тохиолдолд тухайн арилжааны үнэт цаасны үүрэг гүйцэтгэгч нь төлбөрөө гүйцэтгээгүй бол талууд тухайн үүргийг тооцоо нийлэх гэрээнээс хасаж болно.
Тооцоо нийлэх гэрээ байгуулагдсанаар төлбөр төлөх хугацааг хойшлуулах үр дагавартай байдаг боловч талууд хүсвэл арилжааны үнэт цаасны хувьд уг зарчим хэрэгжихгүй байх боломжийг бий болгожээ.		
3	Хугацаа	§531.1 Талууд тооцоо нийлэх хугацааг тохироогүй бол гэрээний хугацаа 6 сар байна.
4	Үл маргах	§532.1 Талууд нь шаардах эрх болон үүрэг бүрийн агуулгыг тэмдэглэсэн тооцооны бичгийг хүлээн зөвшөөрсөн бол дараа нь бичгийн агуулгын талаар гомдол гаргах боломжгүй. Гэхдээ тухайн тооцооны бичгийн агуулгад төөрөгдөл эсвэл алдаа байгаа тохиолдолд энэ заалт үйлчлэхгүй.
Эдгээр зохицуулалт нь талуудыг эрх зүйн тодорхойгүй байдлаас хамгаалах зорилготой.		
5	Хүү тооцох	§533.1 Тооцоо нийлсний дараах үлдэгдэлд үүрэг гүйцэтгүүлэгч нь тооцоог хаасан өдрөөс эхлэн хуульд заасан хүү шаардах эрхтэй. §533.2 Өмнөх заалтын зохицуулалт нь тухайн тооцоо нийлэхтэй холбоотой шаардах эрх болон үүрэг тооцоонд орсон өдрөөс түүнд хүү тооцоход саад болохгүй.
6	Гэрээнээс татгалзах	§534.1 Талууд нь хэзээ тооцоо нийлэх гэрээнээс татгалзаж болно. Тооцоо нийлэх гэрээнээс татгалзсан тохиолдолд шууд тооцоо хааснаар үлдэгдлийг төлөхийг шаардаж болно.

Тооцоо нийлэх гэрээ нь талуудын хоорондын шаардах эрх, үүргийн харилцааг хөнгөвчлөхөөс гадна тооцоо нийлэх гэрээ байгуулагдсанаар тодорхой хугацааны дотор үүссэн шаардах эрх, үүргийн хувьд тооцож дуусгавар болох хүртэл төлбөр төлөх хугацааг хойшлуулах үр дагавар үүсгэдэг мөн энэ хугацаанд үүсэх шаардах эрх, үүргийг бусад этгээдэд шилжүүлэх, битүүмжлүүлэх боломжгүй бөгөөд үүнийг тооцоо нийлэх гэрээний үл хуваагдах зарчим гэж нэрлэдэг. Үүний үр дүнд харилцан тооцож дуусгавар болгох гэж буй шаардах эрх, үүргийн хэмжээгээр бусад этгээдээс тэргүүн ээлжид эрхээ хангуулах боломжтой болох бөгөөд тус гэрээ нь уг шинжээрээ баталгааны шинжтэй чиг үүргийг гүйцэтгэдэг.

4.2.9 ТӨЛБӨР ТООЦООНЫ ГЭРЭЭ

Гэрээний нэг тал нь нөгөө талдаа бусдад мөнгөн төлбөр гүйцэтгэхийг даалгавар болгож буй гэрээг төлбөр тооцооны гэрээ гэнэ. Уг гэрээгээр төлбөрийн даалгавар гүйцэтгэгч/支払人/ өөрийн нэрийн өмнөөс даалгавар өгөгч/委託者、振出人/-ийн зардлаар мөнгөн төлбөрийг гүйцэтгэх, хүлээн авах этгээд/受取人/ нь өөрийн нэрээр мөнгөн төлбөрийг хүлээн авах эрх хэмжээтэй болно.

Төлбөр тооцооны гэрээнд суурилсан эрх зүйн харилцааны хамгийн энгийн жишээ бол чек, векселийн эрх зүй тогтолцоо болно.

4.2.10 ДААТГАЛ

Худалдааны хуулийн 2-р хэсгийн 10-р бүлэг буюу 629-р зүйлээс 683-р зүйлээр ердийн даатгал, 3-р хэсгийн 6-р бүлгээр далайн даатгалын харилцааг зохицуулж байжээ. 2008 онд бие даасан Даатгалын шинэ хууль баталснаар худалдааны хуулийн 10-р бүлгийн зохицуулалтууд хүчингүй болсон. Даатгалын хуулийн 2-р зүйлд “Даатгалын гэрээ гэж даатгалын гэрээ/保険契約/, хамтын тусламжийн гэрээ/共済契約/ болон бусад ямар нэртэй байхаас үл хамааран талуудын нэг тал нь тодорхой нөхцөл байдал үүссэнийг нөхцөл болгож эд хөрөнгө (амь насны даатгал болон гэмтэл, өвчний тогтсон хэмжээт даатгал бол зөвхөн мөнгөн хөрөнгө байна.) олгохоор, нөгөө тал нь хариу болгож тодорхой нөхцөл байдал үүсэх эрсдэлээс хамаараасан даатгалын хураамж төлөхөөр тохиролцсон гэрээг хэлнэ” гэж хуульчилжээ. Доорх хүснэгтэд Даатгалын хуулийн ерөнхий бүтцийг харуулав.

№	Даатгалын хуулийн бүлэг	Дэд хэсэг
1	Ерөнхий үндэслэл 総則	-
2	Хохирлын даатгал 損害保険	Гэрээ байгуулах Гэрээний үр дагавар Даатгалын төлбөрийг олгох Гэрээ дуусгавар болох Гэмтэл, өвчний хохирлын даатгалын тусгай зохицуулалт Үл хамаарах тохиолдол
3	Амь насны даатгал 生命保険	Гэрээ байгуулах Гэрээний үр дагавар Даатгалын төлбөрийг олгох Гэрээ дуусгавар болох
4	Гэмтэл, өвчний тогтсон хэмжээт даатгал 傷害疾病定額保険	Гэрээ байгуулах Гэрээний үр дагавар Даатгалын төлбөрийг олгох Гэрээ дуусгавар болох
5	Бусад 雑則	-

Тус хуулийн 2-р зүйлийн 6 дахь хэсэгт “Хохирлын даатгалын гэрээ/損害保険契約/ гэж даатгалын гэрээнүүдийн дотроос даатгагч нь тодорхой гэнэтийн тохиолдол үүсэхэд бий болох хохирлыг нөхөн төлөхөөр тохиролцсон гэрээ хэлнэ”, тус зүйлийн 7 дахь хэсэгт

“Гэмтэл, өвчний хохирлын даатгалын гэрээ/傷害疾病損害保険契約/ нь хохирлын даатгалын гэрээнүүдийн дотроос даатгагч нь хүний гэмтэл, өвчний улмаас үүсэх хохирлыг нөхөхөөр тохиролцсон гэрээг хэлнэ”, тус зүйлийн 8 дахь хэсэгт “Амь насны даатгалын гэрээ/生命保険契約/ нь даатгалын гэрээнүүд дотроос даатгагч нь хүн амьд явах/生存/ эсвэл нас барах/死亡/-тай холбогдуулж тодорхой хэмжээний даатгалын нөхөн төлбөр олгохоор тохиролцсон гэрээг хэлнэ”, тус зүйлийн 8 дэх “Гэмтэл, өвчний тогтсон хэмжээт даатгалын гэрээ/傷害疾病定額保険契約/ нь даатгалын гэрээний дотроос даатгагч нь хүний гэмтэл, өвчинд тулгуурлан тодорхой хэмжээний даатгалын нөхөн төлбөр олгохоор тохиролцсон гэрээг хэлнэ” гэж тус тус хуульчилжээ. Тус хуулийн даатгалын гэрээний тодорхойлолт нь даатгагч болон даатгуулагч хооронд байгуулагдах даатгалын гэрээг тодорхойлж буй боловч энэхүү гэрээний тодорхойлолт нь даатгалын тогтолцооны агуулгыг илэрхийлэхэд хангалтгүй байдаг. Учир нь даатгалын гэрээний нөхцөл болох даатгалын хураамж, даатгалын нөхөн төлбөр нь магадлалын онолд авч үздэг их тооны хуулийн /law of large numbers/ дагуу тооцоологддог бөгөөд даатгалын гэрээ байгуулах нэг тохиолдол гэхээсээ олон тооны даатгалын гэрээ байгуулагдах нь даатгалын тогтолцоо хэрэгжих урьдач нөхцөл болдог байна. Даатгалын тохиолдол болох гал түймэр эсвэл нас барах гэх мэт үйл явдлууд нь даатгуулагчийн хувьд гэнэтийн бөгөөд тааварлашгүй үйл явдал боловч үүнийг олон тооны даатгуулагч дээр авч үзвэл тодорхой хугацааны тодорхой даатгалын тохиолдол гарах дунджийг тооцоолдог. Даатгалын тогтолцоо энэхүү тооцоолол дээр суурилдаг бөгөөд ирээдүйд гарах боломжтой даатгалын тохиолдлыг тооцоолон түүнийг нөхөхүйц байдлаар даатгалын хураамжийн хэмжээг тооцоолдог байна.

Япон улсад Даатгалын тухай хуулиас гадна Даатгалын үйл ажиллагааны тухай хууль²⁹ хэрэгжиж байна. Уг хуулиар амь насны даатгалыг нэг дэх салбар, хохирлын даатгалыг хоёр дахь салбар гэж хуваан даатгалын үйл ажиллагаа эрхлэгч нь нэгэн зэрэг уг хоёр салбарын даатгалын үйл ажиллагаа эрхлэхийг хориглодог байсан боловч зохицуулалтыг зөөлрүүлэх бодлого/規制緩和政策/-ын хүрээнд охин компани байгуулан үндсэн үйл ажиллагаанаасаа өөр даатгалын салбар руу нэвтэрч үйл ажиллагаа явуулах боломжтой болжээ. Түүнчлэн уг хоёр даатгалын хослуулсан гурав дахь даатгалын салбар бий болсон бөгөөд тухайлбал хорт хавдрын даатгал, эмчилгээний даатгал үүнд хамаарах ба амь насны даатгалын үйл ажиллагаа эрхлэгч, хохирлын даатгалын үйл ажиллагаа эрхлэгч аль аль нь уг салбарын даатгалын үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрдөг байна. 2008 оны Даатгалын тухай хуулиар өмнөх Худалдааны хуульд зөвхөн амь насны даатгал болон хохирлын даатгалын гэрээний зохицуулалт байсныг өргөтгөн “гэмтэл, өвчний хохирлын даатгал/傷害疾病損害保険/”, “гэмтэл, өвчний тогтсон хэмжээт даатгал/定額保険/”-ын гэрээний зохицуулалтыг оруулж ирсэн нь гурав дахь даатгалын салбарын илрэл юм.

Даатгалын гэрээг шинж чанараас нь хамаараад хохирлын даатгалын гэрээ/損害保険契約/, тогтсон хэмжээт даатгалын гэрээ/定額保険契約/ гэж ангилдаг байна. Хохирлын даатгалын гэрээнд эд хөрөнгөд учирсан хохирлын даатгал, бусад хохирол учруулсаны хариуцлагын даатгал энэ ангилалд хамаарах бөгөөд даатгалын нөхөн төлбөрийн хэмжээ учирсан хохирлоос хэтрэхийг хориглох зарчим үйлчилдэг. Харин тогтсон хэмжээт даатгалд энэ зарчим үйлчлэхгүй бөгөөд уг даатгалын төрлийн сонгодог жишээ нь амь насны даатгал юм. Учир нь амь насанд учирсан хохирлыг бодитоор тогтооход хүндрэлтэй

²⁹ 保険業法 - Insurance Business Act- 1939 онд батлагдсан бөгөөд 1995 онд шинэчилсэн найруулга нь батлагджээ.

тул урьдчилан тогтсон хэмжээгээр даатгалын нөхөн төлбөрийг гүйцэтгэх шаардлагатай болдогтой холбоотой.

№	ДААТГАЛЫН АНГИЛАЛ	ТӨРӨЛ
1	Хохирлын даатгал 損害保険	Галын даатгал
		Авто машины даатгал
		Тээврийн даатгал
		Далайн тээврийн даатгал
		Агаарын тээврийн даатгал
		Батлан даалтын даатгал
		Хариуцлагын даатгал
		Бусад даатгал
		Гэмтэл, өвчний хохирлын даатгал
2	Тогтсон хэмжээт даатгал 定額保険	Амь насны даатгал
		Гэмтэл, өвчний даатгал

Даатгалын тухай хууль дахь гэрээний эрх зүйн харилцааг дараах байдлаар тодорхойлсон байна.

№	АГУУЛГА	ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ
1	Мэдээлэх үүрэг 告知義務	§4.1 Даатгуулагч болон даатгагдсан этгээд нь хохирлын даатгалын гэрээг байгуулах үедээ хохирлын даатгалын гэрээний дагуу нөхөн төлөхөөр болсон хохирол үүсэх боломж (аюул)-той холбоотой чухал мэдээллийн дундаас даатгагч мэдээлэхийг шаардсан бол бодит байдлыг мэдээлэх үүрэгтэй. §28.1 Даатгагч нь даатгуулагч эсвэл даатгагдсан этгээд мэдээлэх агуулгын тухайд санаатай эсвэл илт болгоомжгүй улмаас бодит байдлыг мэдээлээгүй, эсвэл бодит бус мэдээлэл өгсөн бол хохирлын даатгалын гэрээнээс татгалзаж болно. §37.1 Даатгуулагч болон даатгагдсан этгээд нь амь насны даатгалын гэрээг байгуулахдаа даатгалын тохиолдол үүсэх боломжийн талаар чухал мэдээллийн дундаас даатгагч мэдээлэхийг шаардсан тохиолдолд бодит байдлыг мэдээлэх үүрэгтэй. §55.1 Даатгагч нь даатгуулагч эсвэл даатгагдсан этгээд мэдээлэх агуулгын тухайд санаатай эсвэл илт болгоомжгүй улмаас бодит байдлыг мэдээлээгүй, эсвэл бодит бус мэдээлэл өгсөн бол амь насны даатгалын гэрээнээс татгалзаж болно. §66.1 Даатгуулагч болон даатгагдсан этгээд нь гэмтэл, өвчний тогтсон хэмжээт даатгал гэрээг байгуулахдаа нөхөн төлбөр олгох нөхцөл байдлын үүсэх боломжийн талаар чухал мэдээллийн дундаас даатгагч мэдээлэхийг шаардсан тохиолдолд бодит байдлыг мэдээлэх үүрэгтэй. §84.1 Даатгагч нь даатгуулагч эсвэл даатгагдсан этгээд мэдээлэх агуулгын тухайд санаатай эсвэл илт болгоомжгүй улмаас бодит байдлыг мэдээлээгүй, эсвэл бодит бус мэдээлэл өгсөн бол гэмтэл, өвчний тогтсон хэмжээт даатгал гэрээнээс татгалзаж болно.

Даатгуулагч болон даатгагдсан этгээд нь даатгалын тохиолдол үүсэх боломжийн талаар даатгагчийн шаардсанаар мэдээлэл өгөх үүрэг хүлээх ба уг үүргээ биелүүлээгүй тохиолдолд даатгагч гэрээнээс татгалзах боломжтой байна. Гэхдээ даатгагч нь бодит байдлыг мэдэж байсан эсвэл өөрийн болгоомжгүйн улмаас мэдээгүй бол гэрээнээс татгалзах боломжгүй.		
2	Мэдээлэх үүргээ зөрчсөний улмаас гэрээнээс татгалзсаны үр дагавар 告知義務違反による解除の効力	§31.1 Хохирлын даатгалын гэрээнээс татгалзах тохиолдолд ирээдүйд чиглэн түүний үр дагавар үүснэ. §59.1 Амь насны даатгалын гэрээнээс татгалзах тохиолдолд ирээдүйд чиглэн түүний үр дагавар үүснэ. §88.1 Гэмтэл, өвчний тогтсон хэмжээт даатгалын гэрээнээс татгалзах тохиолдолд ирээдүйд чиглэн түүний үр дагавар үүснэ.
Мэдээлэх үүргээ зөрчсөний улмаас даатгалын гэрээнээс татгалзсан тохиолдолд үр дагавар нь ирээдүйд чиглэн үүсэх боловч татгалзахаас өмнө үүссэн даатгалын тохиолдлын нөхөн төлбөрийг даатгагч олгох шаардлагагүй. Гэхдээ мэдээлээгүй бодит байдал болон даатгалын тохиолдлын хооронд шалтгаант холбоо байхгүй бол даатгагч даатгалын нөхөн төлбөр олгох үүргээс чөлөөлөгдөхгүй.		
3	Даатгагчаас баримт олгох үүрэг 保険契約締結時の書面交付	§6.1 Даатгагч нь хохирлын даатгалын гэрээ байгуулсан бол нэн даруй даатгуулагчид дор дурдсан агуулгыг тэмдэглэсэн баримт олгоно. - Даатгагчийн нэр - Даатгуулагчийн нэр - Даатгагдсан этгээд нэр болон бусад түүнийг тодорхойлоход шаардлагатай агуулга - Даатгалын тохиолдол - Нөхөн төлбөр олгох хугацаа - Даатгуулсан эд зүйл - Нөхөн төлбөр олгох хэмжээ болон арга - Даатгалын хураамж болон төлбөр хийх арга - Мэдээлэх үүрэг түүний зорилго - Амь насны даатгалын гэрээ байгуулсан он сар өдөр - Баримт бичсэн он сар өдөр
Даатгагчаас баримт олгох үүрэг нь хохирлын даатгалын гэрээнээс гадна амь насны даатгалын гэрээ/§40/, гэмтэл, өвчний тогтсон хэмжээт даатгал гэрээ / §69/ байгуулсан тохиолдолд уг үүргийг мөн даатгагчид хүлээлгэжээ.		
4	Даатгалын тохиолдол үүссэн тухай мэдэгдэх 通知義務	§14.1 Даатгуулагч болон даатгагдсан этгээд даатгалын тохиолдол улмаас хохирол үүссэнийг мэдсэн бол нэн даруй даатгагчид энэ тухай мэдэгдэх үүрэгтэй.

Даатгалын тохиолдол бий болсон талаар мэдэгдэх үүргийг мөн амь насны даатгал/§50/, гэмтэл, өвчний тогтсон хэмжээт даатгал/§79/-ын гэрээний харилцаанд мөн Даатгуулагч болон даатгалын нөхөн төлбөр хүлээн авах этгээд хүлээсэн байна.		
5	Даатгалын нөхөн төлбөр олгох хугацаа 保険給付の履行期	§21.1 Даатгалын нөхөн төлбөр олгох хугацаа тогтоосон хэдий ч, тухайн хугацаа нь даатгалын тохиолдол, нөхөн төлөх хохирлын хэмжээ, даатгагч хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл болон бусад даатгалын нөхөн төлбөр олгохын тулд тодорхой болгохыг хохирлын даатгалын гэрээгээр шаардлагатай гэсэн агуулгыг тодруулахын тулд боломжит хугацаа өнгөрөх өдрийн дараах өдөр бол тухайн хугацаа өнгөрсөн өдрөөр даатгал нөхөн төлбөр олгох хугацаа гэнэ. §21.2 Даатгалын нөхөн төлбөр олгох хугацааг заагаагүй бол даатгалын нөхөн төлбөр шаардсаны дараа тухайн шаардлагатай холбогдох даатгалын тохиолдол болон нөхөн төлөх хохирлын хэмжээг тогтооход шаардлагатай хугацаа өнгөрөх хүртэл даатгагч нь хугацаа хожимдсоны хариуцлага хүлээхгүй. §21.3 Даатгагч нь өмнөх 2 хэсэгт заасан агуулгыг тодорхой болгохын тулд судалгаа явуулахдаа даатгуулагч болон даатгагдсан этгээд зохистой шалтгаангүйгээр тухайн шалгалтад саад хийх, эсвэл шалгалт хийлгэхээс татгалзсан бол даатгагч үүний улмаас даатгалын нөхөн төлбөр олгох хугацаа хожимдсоны хариуцлагыг хүлээхгүй.
Даатгалын гэрээгээр тохиролцсон даатгалын нөхөн төлбөр олгох хугацаа нь ердийн боломжит хугацаанаас урт бол ердийн боломжит хугацаа дууссан өдрийн дараах өдрөөс эхлэн даатгагчид даатгалын нөхөн төлбөр олгох үүрэг үүсэхээр хуульчилжээ. Энэ зохицуулалт мөн амь насны даатгал/§52.1/, гэмтэл, өвчний тогтсон хэмжээт даатгал/§83.1/-ын гэрээний харилцаанд мөн үйлчилдэг байна.		
6	Даатгагч даатгалын нөхөн төлбөр олгохоос чөлөөлөгдөх тохиолдол 保険者の免責	§17.1 Даатгагч нь даатгуулагч болон даатгагдсан этгээдийн санаатай эсвэл илт болгоомжгүй үйлдлээс үүссэн хохиролд хариуцлага хүлээхгүй. Дайн болон бусад олон нийтийн үймээнээс болж үүссэн хохиролд хувьд мөн адил байна. §17.2 Хариуцлагын даатгалын гэрээнд өмнөх заалтыг хэрэглэхдээ зөвхөн санаатай тохиолдолд хэрэглэнэ. §51.1 Амь насны даатгалын гэрээний даатгагч нь дараах тохиолдолд нөхөн төлбөр олгох хариуцлага хүлээхгүй. - Даатгагдсан этгээд амиа хорлосон - Даатгуулагч даатгагдсан этгээдийн амь насыг санаатайгаар хохироосон - Даатгагдсан этгээд даатгагдсан этгээдийн амь насыг санаатайгаар хохироосон - Дайн болон бусад олон нийтийн үймээнээс болж даатгагдсан этгээд нас барсан §80.1 Даатгагч нь дараах тохиолдолд даатгал нөхөн төлбөр олгох хариуцлага хүлээхгүй. - Даатгагдсан этгээд нь санаа болон илт болгоомжгүй үйлдлээрээ даатгалын тохиолдлыг бий болгосон

		- Даатгуулагч нь санаа болон илт болгоомжгүй үйлдлээрээ даатгалын тохиолдлыг бий болгосон - Даатгагдсан этгээд нь санаа болон илт болгоомжгүй үйлдлээрээ даатгалын тохиолдлыг бий болгосон - Дайн болон бусад олон нийтийн үймээнээс болж даатгалын тохиолдол бий болсон
7	Даатгуулагч гэрээнээс татгалзах 保険契約者 による解除	§27.1 Даатгуулагч хохирлын даатгалын гэрээнээс татгалзаж болно.
Амь насны даатгал/§54/, гэмтэл, өвчний тогтсон хэмжээт даатгал/§83/-ын гэрээний харилцаанд нэгэн адил зохицуулалт үйлчилж байна.		

ТАВДУГААР БҮЛЭГ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын хувьд худалдааны үйл ажиллагаатай холбоотой институтуудыг бий болгох, худалдааны хэлцлийн нийтлэг үндэслэл, худалдааны хэлцлийн тусгай төрлийн талаарх зохицуулалтын хүрээнд худалдааны хуулийн зорилго, зорилтыг тодорхойлох нь зүйтэй байна.

Худалдааны хуулийг бүтээхдээ Иргэний хууль, Өрсөлдөөний хууль, Хөдөлмөрийн хууль, Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хууль болон бусад аж ахуйн харилцааг зохицуулж байдаг хууль тогтоомжтой хэрхэн уялдуулах тал дээр анхаарал хандуулах шаардлагатай.

Монгол Улсын Иргэний хуулийн 2-р зүйлийн 2.1 дэх хэсэгт заасан “Иргэний хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ”, 3-р зүйлийн 3.3 дахь хэсэгт “Монгол Улсын Үндсэн хууль, энэ хуулиас бусад хууль хоорондоо зөрчилдвөл тухайн асуудлыг илүү нарийвчлан зохицуулсан хуулийн, тийм хууль байхгүй бол сүүлд хүчин төгөлдөр болсон хуулийн заалтыг хэрэглэнэ” гэх заалтуудын агуулгыг шинэчлэн найруулах. Учир нь Худалдааны хууль батлагдах тохиолдолд Монгол Улсын Үндсэн хуульд нийцэх ёстой нь гарцаагүй боловч Иргэний хуульд нийцэх шаардлагатай эсэх нь гол асуудал юм. Иргэний хууль нь хувийн эрх зүйн харилцааны ерөнхий хууль бол, Худалдааны хууль нь хувийн эрх зүйн харилцаанаас арилжааны эрх зүйн харилцааг зааглан, тусгайлан зохицуулж буй тусгай хууль гэж дээрх орнуудад үзэж буй тул энэ системчлэлийг нь дагах нь зөв болов уу. Өөрөөр хэлбэл Иргэний хууль болон Худалдааны хууль хоорондоо зөрчилдвөл аж ахуйн шинжтэй харилцаанд Худалдааны хуулийг тэргүүн ээлжинд хэрэглэх эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

Вьетнам улсын Худалдааны хуулийг аваад үзвэл “Худалдааны үйл ажиллагаан дахь заншил”, “Худалдааны заншил” гэсэн 2 ойлголтыг хэрэглэж байх бөгөөд тодорхой хэмжээнд ялгаатай байна. Манай улсын Иргэний хуулийн 198-р зүйлийн 198.6 дахь хэсэгт “талуудын хооронд тогтсон практик”, “ажил хэргийн хүрээнд тогтсон заншил” гэсэн ойлголтыг хэрэглэсэн байдаг. Энэ нь зөвхөн тодорхой нутаг дэвсгэрт тогтсон заншлаас гадна зөвхөн талуудын хооронд тогтсон практик, заншил мөн чухал ач холбогдолтойг илтгэж буй тул худалдааны хууль бүтээхдээ анхаарах ёстой асуудал юм.

Монгол Улс бизнэс эрхлэгчийн үйл ажиллагааны онцлогт тохирсон, тусгайлан зохицуулах хэм хэмжээг нэгтгэн кодификачлахдаа “Худалдааны хууль” гэсэн уламжлалт нэрийг авч хэрэглэх нь зүйтэй.

Хуулийн хэрэглэх хүрээг тодорхойлохдоо субъектив онолд тулгуурлах. Учир нь энэхүү онолд тулгуурлах нь хуулийг хэрэглэхэд амар болгоно. Аливаа хийдэл гарахаас сэргийлнэ.

Худалдааны хуулийн субъектийн ерөнхий нэр нь “худалдаачин” байх уу “аж ахуй

эрхлэгч” байх уу гэх сонголт байх бөгөөд одоо хэрэгжиж буй Иргэний хуульд аж ахуй эрхлэгч гэж хэрэглэж байх тул “аж ахуй эрхлэгч” гэх нэр томъёог хэрэглэх нь зүйтэй байна. Нөгөө талаас худалдаачин гэх нэр томъёо нь орчин үеийн аж ахуй харилцаанд хэрэглэхэд хэт явцуу ойлголт гэж үзэгдэх болжээ.

- 1) Аж ахуйн үйл ажиллагаа гэдэгт юуг ойлгох талаар тодорхойлолт өгөх
- 2) Аж ахуй эрхлэгчийг заавал аж ахуй эрхлэгч болох, аж ахуй эрхлэгч гэж үзэх, сайн дураар аж ахуй эрхлэгч болох гэж ангилах
- 3) Насанд хүрээгүй этгээд нь худалдааны үйл ажиллагаа явуулах тохиолдолд заавал бүртгүүлэх тогтолцоог бий болгох.
- 4) Эрх зүйн чадамжгүй худалдаа эрхлэгчийн асран хамгаалагчийг бүртгэх тогтолцоог бий болгох
- 5) Жижиг худалдаа эрхлэгчийн хувьд бүртгүүлэх шаардлагагүй байхаар хуульчлах Худалдааны бүртгэлийн гол зорилго нь нь тухайн худалдаа эрхлэгчдэд хамаарах тодорхой үйл баримт найдвартай болохыг гэрээний нөгөө талд батлан харуулах зорилготой байна. Түүнчлэн худалдааны бүртгэлд итгэсэн гуравдагч этгээдийг хамгаалах зорилготой бөгөөд хэлцлийн баталгаат байдлыг хангахад гол чиг үүрэг гүйцэтгэж байна.
- 6) Хувь худалдаа эрхлэгч худалдааны бүртгэл хийлгэх боломжтой тогтолцоог бий болгох
- 7) Манай улсад хуулийн этгээдийн бүртгэлийн тодорхой мэдээллийг олон нийтэд нээлттэй байгаа боловч хангалтгүй байгаа бөгөөд тухайлбал хөрөнгийн хэмжээний талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох шаардлагатай байна.Түүнчлэн нээлттэй болгсон мэдээллэд итгэсэн гуравдагч этгээдийн ашиг сонирхолыг хамгаалах эрх зүйн үр дагавар бүхий зохицуулалт бий болгох шаардалгатай.
- 8) Хувь худалдаа эрхлэгч өөрийн нэрээс гадна бусад зохиомол нэрээр худалдааны үйл ажиллагаа явуулах боломжийг бүрдүүлэх
- 9) Худалдааны нэрийг хууль бусаар ашиглах тохиолдолд зөрчлийн хуулиар шийтгэх тогтолцоог бий болгох
- 10) Худалдааны нэрийг бусдад шилжүүлж ашиглуулах тохиолдолд үүсэх харилцааг зохицуулах, гуравдагч этгээд хохирохоос сэргийлэх
- 11) Худалдааны эрхлэгчийн гишүүнчлэлийн бүтэц өөрчлөгдөхөд худалдааны нэртэй холбоотой үүсэх харилцааг зохицуулах

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

1. 伊藤光男,商法総則・商行為法、第6版、有斐閣法律学叢書
Кондо Мицүо, Арилжааны эрх зүйн ерөнхий анги, Арилжааны хэлцлийн эрх зүй, 6 дахь хэвлэл
2. 近藤光男、現代商法入門、有斐閣アルマ
Кондо Мицүо, Орчин үеийн арилжааны эрх зүйн гарын авлага, Юүхикакү хэвлэлийн компани
3. 落合誠一,大塚龍児,山下友信、商法1総則・商行為、有斐閣。11へ “ーシ”
Очиай Сэйичи, Ооцүка Рюүжи, Ямашита Томонобү, Арилжааны тухай хууль 1; Ерөнхий анги, Арилжааны хэлцэл, Юүүхикакү
4. 廣瀬孝壽、ト “イツ民法の消費者概念規定改正に関する一考察”、北九州工業高等専門学校研究報告第49号、2015年
Хиросэ Такатоши, Герман улсын Иргэний кодексийн Хэрэглэгч гэх ойлголтыг тодорхойлсон заалттай холбоотой нэмэлт өөрчлөлт, Китаkjюшү технологийн дээд сургуулийн судалгааны товхимол (No49), 2015 он
5. 田島純藏、消費者契約の法律相談、青林書院
Тажима Жүнзо, Хэрэглэгчийн гэрээтэй холбоотой эрх зүйн зөвлөгөө, Сэйрин хэвлэлийн газар, 2007 он
6. Bürgerliches Gesetzbuch, Handkommentar, 10. Auflage 2019 Холбооны Бүгд Найрамдах Герман улсын Иргэний кодекс, Өврийн тайлбар толь, 10 дахь хэвлэл, 2019 он
7. Teresa Rodriguez de las Heras Ballell, Introduction to Spanish private law; Facing the special and economic challenges, routledge-Cavendish, 2009
8. Ханнс Зайделийн Сан, “Эрх зүйн боловсрол” академи, Арилжааны эх зүйн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны тайлан, Улаанбаатар хот, 2019 он <http://legaldata.mn/b/519>
9. Black’s law dictionary, 9 дэх хэвлэл <https://archive.org/details/BlacksLawDictionary-Editions1-9>
10. ト “イツ商法典(第1編~第4編)、法務省大臣官房司法法制部、平成28年8月
ХБНГУ-ын Иргэний хуулийн кодификац (1 дүгээр бүлэг - 4 дүгээр бүлэг) /Япон хэл дээрх орчуулга/, Хууль зүйн яамны Элчин сайдын хувийн эрх зүйн хэлтэс, 2016 оны 8 сар <http://www.moj.go.jp/content/001206509.pdf>
11. 廣瀬孝壽、ト “イツ民法の消費者概念規定改正に関する一考察”、北九州工業高等専門学校研究報告第49号、2015年
Хиросэ Такатоши, Герман улсын Иргэний кодексийн Хэрэглэгч гэх ойлголтыг тодорхойлсон заалттай холбоотой нэмэлт өөрчлөлт, Китаkjюшү технологийн дээд

сургуулийн судалгааны товхимол (No49), 2015 он
http://library.kct.ac.jp/content/files/ResRep49/10G_Hirose.pdf

12. ヨハネス・ハーカ ー、ト ーイツ消費者保護の基礎、2012 年

<http://www.ritsumei.ac.jp/acd/cg/law/lex/12-2/deguchihonma1.pdf>

13. 市原正七、商人資格取得時期について、1981 年 Ичихара Шоошичи, Арилжаа эрхлэгчийн эрх зүйн байдлыг олж авах хугацааны тухай /Судалгааны ажил/, 1981 он <https://www.chukyou.ac.jp/educate/law/academic/hougaku/data/16/2/ichihara.pdf>

МОНГОЛ ЭХ СУРВАЛЖ

1. Б.Буянхишиг “ХБНГУ-ын Иргэний хуулийн” орчуулга 2016 он
2. Б.Буянхишиг “ХБНГУ-ын Худалдааны хуулийн” орчуулга 2018 он
3. Нарангэрэл С., Эрх зүйн эх толь бичиг, Анхны хэвлэл, Улаанбаатар хот, 2007 он
4. Нарангэрэл С., Хууль зүйн англи-Монгол эх толь бичиг. 4 дэх хэвлэл, Улаанбаатар хот, 2015 он
5. Байгал С., Иргэний эрх зүйн ерөнхий анги, Улаанбаатар хот, 2009 он
6. А. Кают нар, Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар, Улаанбаатар хот, 2006 он
7. Буянхишиг Б., Иргэний эрх зүйн удиртгал, анхны хэвлэл, Улаанбаатар хот, 2012 он
8. Улаанбаатар Б., Иргэний эрх зүйн толь бичиг, УБ хот, 2005 он
9. Булган Г., Арилжааны эрх зүйд хамаарах /Commercial law/ Монгол улсын эрх зүйн зохицуулалт, харьцуулсан судалгаа; Магистрын ажил, 2017 он
10. Банзрагч Г., Эдийн засгийн захиргааны эрх зүй, Улаанбаатар хот, 2013 он
11. Д.Энхзул “Хувийн эрх зүйн байгууллагын хэлбэрийн талаарх зарим асуудал” Эрх зүй сэтгүүл, №37, 2017 он
12. Ханс Кристоф Григолайт “Арилжааны эрх зүйн үндсэн зарчим” Хууль дээдлэх ёс сэтгүүл, №3, 2018 он
13. Монголын хууль тогтоомжийн нийгэмлэг ТББ хамтран Япон сангаас зохион байгуулсан “Япон улсын хууль тогтоомжийн хөгжил: Худалдаа (арилжаа)-ны эрх зүй “/Эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл/, Улаанбаатар хот,

ЭРХ ЗҮЙН ЭХ СУРВАЛЖ

1. Монгол Улсын Иргэний хууль
2. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль
3. Өрсөлдөөний тухай хууль
4. Жижиг, дунд үйлдвэрийн тухай
5. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль
6. Тариалангийн тухай хууль